



---

## Алсын хараа

Дэлхийн жишиг Монголын банк

---

## Эрхэм зорилго

Хөгжлийн голомт

---

## Стратеги

Нээлттэй банк

# Агуулга

---

**01** Удиртгал

---

**02** Компанийн засаглал

---

**03** Эдийн засаг, санхүүгийн тойм

---

**04** Бизнесийн тойм

---

**05** Тогтвортой хөгжил

---

**06** Нийгмийн хариуцлага

---

**07** Үйл ажиллагааны удирдлага

---

**08** Хараат бус аудиторын тайлан

---

07	Голомт банкны ололт амжилт
08	Санхүүгийн голлох үзүүлэлт
10	Мэндчилгээ

---

14	Засаглал
17	ТУЗ-ийн бүрэлдэхүүн
22	ТУЗ-ийн дэргэдэх хороод
29	Хувьцаа эзэмшигчид
34	Комплаенс
40	Дотоод аудитын үйл ажиллагаа
42	Удирдлагын баг, бүтэц

---

47	Эдийн засгийн тойм
60	Банкны салбарын тойм
69	Голомт банкны санхүүгийн үр дүн

---

77	Байгууллагын банк
84	Жижиг, дунд бизнесийн банк
90	Иргэдийн банк
97	Дижитал банк
110	Олон улсын бизнес, хамтын ажиллагаа

---

117	Тогтвортой хөгжил
-----	-------------------

---

125	Нийгмийн хариуцлага
-----	---------------------

---

129	Хүний нөөцийн удирдлага
134	Хөрөнгийн удирдлага
136	Харилцагчийн үйлчилгээ
138	Эрсдэлийн удирдлага

---

146	Хараат бус аудиторын тайлан
-----	-----------------------------

# Удиртгал

Нийт актив

# 15.6

их наяд төгрөг

Банкны нийт актив өмнөх оноос 34.1 хувиар өсөж, 15.6 их наяд төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх хувь 21.6% болж өслөө. Ингэснээр активын хэмжээгээр банкны системийн хоёр дахь том банк болов.

## Голомт банкны ололт амжилт

---

**The Banker**

Монгол Улсын Шилдэг  
банк 2024

---

**Infosys**

Maximizing Customer  
Engagement 2024

---

**cfi.co**

Монгол Улсын Шилдэг  
Дижитал банк 2024

---

**Great  
Place  
To  
Work®**

Ажиллахад  
таатай газар 2024

---



Монгол Улсын  
ТОП-100 ААН

---

## Санхүүгийн голлох үзүүлэлт

Нийт хөрөнгө

**15,597**  
/тэрбум төг/

Өөрийн хөрөнгө

**1,430**  
/тэрбум төг/

Харилцах, хадгаламж


**9,377**  
/тэрбум төг/

Цэвэр зээл

**7,351**  
/тэрбум төг/

Цэвэр ашиг

**419**  
/тэрбум төг/



## Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ



### Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд болон хамтран ажиллагсад аа,

Голомт банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш хөгжил өсөлтийг үзүүлсэн гурав дахь жилтэйгээ золгож байна. 2024 он Голомт банкны хувьд тэлэх стратеги баримтлан санхүүгийн өндөр дэвшилт үзүүлснээр Монгол Улсын банк санхүүгийн салбарт тэргүүлэгч байр сууриа бататгаад зогсохгүй олон улсад ч мөн нэрээ тамгалсан жил боллоо. Сайн сайхныг санхүүжүүлэх бидний эрмэлзэл, компанийн сайн засаглал, тогтвортой хөгжилд түүчээлсээр ирсэн бидний хүчин чармайлт бүхэн Голомт банкны амжилтын хөдөлгөгч хүч байв.

2024 оны хамгийн том амжилт бол Монголын банкны салбараас анх удаа Засгийн газрын баталгаагүй, олон улсын хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалах бондыг Голомт банк амжилттай гаргасан явдал бөгөөд энэхүү үйл явдал нь дэлхийн зах зээлд байр сууриа бататгахад томоохон алхам болсон юм. Тодруулбал, бид дэлхийд нэр хүнд бүхий томоохон банкнууд болох J.P.Morgan, Deutsche Bank болон нэр хүндтэй хуулийн фирмүүдийн дүгнэлтээр сайн засаглал, үлгэр жишээ санхүүгийн удирдлага, ил тод байдал нь олон улсын жишигт нийцсэн хэмээн хүлээн зөвшөөрөгдлөө.

Голомт банк тогтвортой өсөлтийн замналаар үйл ажиллагаа амжилттай үргэлжлүүлсээр 2024 онд ч мөн өсөлт, тэлэлт үзүүлсэн үр дүнтэй ажиллаа. Бид анх хувьцаагаа олон нийтэд санал болгох үед гаргасан банкны санхүү үйл ажиллагааны үр дүнгийн төсөөллөө давуулан биелүүлсэн амжилт гаргасан төдийгүй тайлант хугацаанд Голомт банкны ROE (өөрийн хөрөнгийн өгөөж) 33.6%-аар өссөн байдал нь бидний санхүүгийн чадавч болоод хөрөнгийн үр ашигтай удирдлагын илэрхийлэл болсон юм. Харилцагч төвтэй тэлэлтийн стратеги болон зах зээл дэх боломжийг үр ашигтайгаар удирдсаны үр дүнд Голомт банкны нийт актив 34.1%-аар өсөж, зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлээ.

Түүнчлэн нийт зээлийн хэмжээ 54.3%-аар өссөн нь бизнесийн болон иргэдийн зээлийн хэрэгцээнээс гадна стратегийн хувьд зах зээлээ тэлэх бодлого баримталж, үйл ажиллагааны бүтээмжид анхаарсны үр дүн боловч бид зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогоо хатуу баримталж, эрсдэлийн зохистой удирдлагыг сулруулалгүйгээр өсөлтөө хангасан нь ирээдүйд тогтвортой өсөлтөө хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн. Монгол Улсын банкны салбарын зээлийн багцтай Голомт банкны багц ижил бүтэцтэй цорын ганц банк юм. Иргэд, жижиг дунд болон том байгууллагуудад жигд зээл олгож, харилцагч нартаа эн тэнцүү үйлчилж ирсэн нь эдийн засгийн бүхий л салбарт харилцагчдынхаа амжилт, өсөлтийг дэмжин, хамтарч зөвлөж, үйлчилж ирсний илэрхийлэл билээ.

Мөн Голомт банк тогтвортой санхүүжилтийн төлөөх зорилтоо биелүүлж, 2024 онд ногоон зээлийн багцаа 52.8%-аар өсгөснийг та бүхэнд дуулгахад таатай байна. Энэхүү өсөлт нь нийт оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг хүргэхийн зэрэгцээ байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх бидний хичээл зүтгэлийг илтгэж байна.

Түүнчлэн бид 2023 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрлэлийн Танхимтай хамтран “Women Owned” худалдааны тохирлын тэмдгийг танилцуулсан бөгөөд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, жендэрийн тэгш байдлыг хангахад тал бүрээр хичээн ажиллаж байна.

2025 онд Голомт банкны хувьд салбартаа анхдагч байсаар ирсэн амжилтын түүхэн 30 жилийн ой тохиож буй. Бид эдгээр он жилүүдэд Монгол Улсын банк санхүүгийн салбарт түүчээлэн улсынхаа эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулсаар ирлээ. Үүгээр зогсохгүй бид илүү сайн сайхан нийгмийг цогцлооход гар бие оролцож, тогтвортой эерэг өөрчлөлтийг бий болгохын тулд нийгмийн хариуцлагын төслүүдэд оруулах хүчин чармайлтаа тасралтгүй нэмэгдүүлсэн.

Голомт банк 2025 он ба ирээдүйд инновац, тогтвортой байдал, санхүүгийн чадамж дээр тулгуурлан өсөлтөө

хадгалах зорилготой ажиллаж байна. Бид олон улсын зах зээлд байр сууриа тэлснээр Монгол улсын эдийн засгийн суурь болсон бизнесүүдээ дэмжин санхүүжилт, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг нээж буйгаас гадна эдийн засгийн солонгорлыг дэмжих боломж юм.

Бид Монгол Улсын уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтыг хэрэгжүүлж, ирээдүйд хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх төслүүдэд хөрөнгө оруулан ногоон санхүүжилтийн чиглэлээр тогтвортой алхмуудыг хийж байна. Үүний зэрэгцээ Голомт банк олон улсын шилдэг туршлагуудад нийцүүлсэн компанийн засаглал, хөрөнгө оруулагчдын харилцаа, ил тод байдлыг улам бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлснээр бид зөвхөн тогтвортой өсөлтийн бат бөх суурийг тавиад зогсохгүй Голомт банкныг Монгол Улсад болон олон улсын тавцанд найдвартай болоод сайн засаглалтай санхүүгийн байгууллага гэдгийг нотолж байгаа юм.

Бидэнд итгэл хүлээлгэн амжилт бүрд үргэлж хамт байдаг эрхэм харилцагч, хамтрагч байгууллага, хөрөнгө оруулагч, хамт олон та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

#### Ч.Мөнхцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Голомт банк 2024 онд түүхэн мөр, тод амжилтаа бататган ажиллаж, банк, санхүүгийн системээ түүчээлэн тэргүүлэгч байр сууриа хадгалсаар ирэх он жилүүдэд амжилттай ажиллах нөхцөлөө бүрдүүлсэн нэг жилийг үдэж байна.

Монгол Улсын хөгжлийн голомт байх эрхэм зорилго дор нэгдсэн Голомтчууд бид улс эх орныхоо хөгжилд хөтлөх, эдийн засгаа тэлэх төслүүдийг дэмжин санхүүжүүлэх нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан ажилласаар ирсэн билээ. Бидний өмнө тулгарсан сорилт, бэрхшээлүүдийг 2,700 гаруй ажилтныхаа хамтаар даван туулж, үнэмлэхүй амжилтыг бүтээлээ.

Тайлант хугацаанд Голомт банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг Moody's агентлаг "B2", S&P Global агентлаг "B+" болгож, нэг зэрэглэлээр ахиулснаар олон улсын зах зээлээс татах хөрөнгө оруулалт нэмэгдэх, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл сайжрах зэрэг эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэв.

Бид анх удаа олон улсын зах зээл дээрээс гурван жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож, арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкнуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээсэн нь түүхэн үйл явдал боллоо. Мөн бид 12-р сард 8.5 хувийн өгөөжтэй 100 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд дахин санал болгож, захиалга нээгдсэн даруйдаа амжилттай зарагдаж дууссан нь Монголын хөрөнгө оруулагчид төдийгүй дэлхийн топ хөрөнгө оруулалтын сангууд Голомт банканд итгэл хүлээлгэж буй илрэл билээ.

Голомт банкны бодлого, стратеги нь зөвхөн өнөөдрийг бус, ирээдүйг харсан, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэсээр ирсэн. 2024 онд банкны нийт хөрөнгө 15.6 их наяд төгрөгт хүрснээр банкны системд эзлэх хувь 21.6 хувь болж, санхүүгийн үзүүлэлтээр системийн хоёр дахь том банк боллоо. Зээлийн багц 54.3 хувиар өсөж, 7.5 их наяд төгрөгт хүрснээр банкны системийн хэмжээнд нийт зээлийн 20.1 хувийг эзлэв. Татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 100.2 хувиар өсөж, 418.8 тэрбум төгрөгт хүрлээ. Энэхүү өсөлт нь банкны оновчтой стратеги, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээ, үр ашигтай удирдлагын бодлого, мэргэшсэн хамт олны хүчин чармайлтын үр дүн юм.

Бидний хувьд 2024 он олон улсын түвшинд хамтын ажиллагаагаа тэлж, цар хүрээгээ өргөжүүлсэн жил байлаа. Бизнес эрхлэгчдэд зориулсан үйлчилгээгээ сайжруулахаар Олон Улсын Санхүүгийн Корпорацитай гэрээ үзэглэснээс гадна Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай анхны хамтын ажиллагааг эхлүүлж, 20 сая ам.долларын "Залуу бизнес эрхлэгчид" болон

“Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр болсныг энд онцолъё. Тодруулбал, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээ санхүүгийн хувьд дэмжин тэдэнд тохирсон бизнесийн орчин, бодит дэмжлэгийг нэмэгдүүлэхэд анхаарч буй энэ цаг үед ийнхүү олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтарч байгаа нь Монгол Улсын жижиг, дунд бизнесийн салбар руу чиглэсэн томоохон дэмжлэг болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Бид зөвхөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч төдийгүй харилцагчид, бизнес эрхлэгчдэд тогтвортой хөгжлийн түнш нь байж, урт хугацааны үнэ цэнийг хамтдаа бүтээхийг зорьдог. Иймдээ ч өөрийн болон зээлийн багц дахь хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжиж буй дотоодын цор ганц банк билээ. Олон улсын PCAF аргачлалаар тооцоноор бид 2024 онд өөрийн шууд болон шууд бус үйл ажиллагаагаар 2.7 сая тонн хүлэмжийн хий ялгаруулсан бол зээлээр дамжуулан санхүүжүүлсэн төслүүд 1.6 сая тонн хүлэмжийн хийг ялгаруулжээ. Бид 2030 он гэхэд өөрийн ялгаруулж буй хүлэмжийн хийг 30 хувь бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Цахим банкны хөгжлийг эрчимжүүлэн төлбөрийн систем, зээлийн үйлчилгээнд инновац нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарсан жил байв. Дэлхийн шилдэг төлбөр тооцооны

систем болох Apple Pay үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх эрх авсан анхны байгууллага болж, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн дэвшлийг нутагшуулж, дижитал банкны үйлчилгээг бүрэн дүүрэн нэвтрүүлж, хэрэглэгч, харилцагч төвтэй банк гэдгээ дахин нэг шат ахиуллаа. Энэ бол Голомт банк төдийгүй монголчуудын хамтран бүтээсэн амжилт төдийгүй банк, санхүүгийн үйлчилгээгээр бид дэлхийтэй эн зэрэгцэх түвшинд алхаж, Дэлхийн жишиг Монголын банк байх Голомт банкны алсын хараа амжилттай хэрэгжиж буйн тод илрэл юм.

Ирж буй 2025 онд Голомт банкны 30 жилийн ой тохиож, хөгжилд хөтөлсөн гурван арваны нэгэн шинэ түүхээ хамтдаа бичих гэж байна. Бид банк, санхүүгийн салбартаа тэргүүлэгч байж, Монгол Улсын хөгжлийн хурдасгуур, хөдөлгөх хүч болсон томоохон төслүүдийг бүтээн босгоход хувь нэмрээ оруулж, жижиг, дунд бизнесүүдээ дэмжин өөрийн болон зээлийн багц дахь хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулан байгальд ээлтэй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахаа мэдэгдье. Дэлхийн жишиг Монголын банк байх алсын харааны хүрээнд бид ирээдүйн ололт амжилтын суурийг батжуулан харилцагч, хөрөнгө оруулагчид, түншүүд, хамтран ажиллагсад та бүхний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэн ажиллах болно гэдгээ илэрхийлье.

**А.Одонбаатар**

Гүйцэтгэх захирал



# Компанийн засаглал



Жижиг хувьцаа  
эзэмшигчдийн тоо

# +21,000

Бат бөх засаглалын тогтолцоог бий болгож, тогтвортой сайжруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахад өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллах засаглалын зарчмуудыг оновчтой тодорхойлж, бодлого журамдаа ил тодоор тусгах нь нийт засаглалын оролцогч талууд нийцэн ажиллахад хэрэглэгддэг суурь шаардлага юм.

## Банк болон банкны засаглалын жилийн онцлох үйл явдал

Голомт банкны зохистой засаглалын тогтолцоо олон улсын жишигт хүрснийг бататгах үйл явдал нь олон улсын зах зээлд 2024 онд амжилттай гаргасан бонд байв. Учир нь:

# 1

Дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын J.P. Morgan, Deutsche банкнууд болон тэдгээртэй хамтран ажилласан хуулийн фирмүүдийн хөндлөнгийн хяналт шалгалтаар зохистой засаглал үйл ажиллагааг дүгнүүлэн нийцсэн.

# 2

Хөндлөнгийн аудитын байгууллагаас газар дээрх шалгалт хийсний үндсэн дээр санхүүгийн бүртгэл, тайлагнал нь зохистой хэмээн сүүлийн гурван жилийн тайланг дахин бататгасан.

# 3

Reg S/144A журмын дор буюу АНУ болон бусад орнуудад нээлттэй бонд гаргах нь засаглал комплаенс талаас банкны тайлагнал, үйл ажиллагаа нь эдгээр дэлхийн жишигт нийцсэнийг илтгэж байна.

# 4

Дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын сангууд Голомт банкны санхүү, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл тайлантай танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулах шийдвэрээ гаргасан.


# 5

Голомт банкны бондод хөрөнгө оруулсан бүх этгээдэд нээлттэй ил тод байдлаар санхүү үйл ажиллагааны тайланг хүргэх үүднээс Investor Relations буюу хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагаагаа сайжруулсан.

Олон улсын бонд гаргах нь ил тод байдал, хариуцлага, санхүүгийн удирдлагын дэлхийн хамгийн өндөр стандартыг баримтлах бидний зорилгыг бэхжүүлж, олон улсын санхүүгийн салбарт тогтсон практикт нийцүүлэх, үйл ажиллагаа хууль журамд нийцсэн байх, Монгол Улсын болон олон улсын оролцогч талууд бидний үйл ажиллагаанд итгэх итгэлийг бататгах үйл явдал болсон. Голомт банкны дэлхийн хэмжээнд найдвартай, сайн засаглалтай байгууллага болж, олон улсын хөрөнгө оруулагчид болон түншүүдийг татах чадавхыг бэхжүүлж байгааг онцлох нь зүйтэй юм.

Бонд гаргасан нь мөн тогтвортой өсөлтийг хангах бидний амлалтыг баталгаажууллаа. Түүнчлэн энэ чухал алхам нь хөрөнгө оруулагчдыг өргөжүүлэх, санхүүгийн уян хатан байдлыг сайжруулах боломжийг олгож, ирээдүйн өсөлт, санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэн хөгжүүлэх замыг нээсэн гэж үзэж байна. Олон улсын хөрөнгийн эх үүсвэрийг бий болгосноор бид зээлийн чадавхыг нэмэгдүүлэх, чухал төслүүдийг дэмжих, цаашлаад үндэсний эдийн засгийн дэвшилд хувь нэмрээ улам нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна.

## Компанийн засаглалын тогтолцоо



### Засаглал

Аливаа байгууллагын засаглалыг сайн удирдах үндсэн цөм нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) ба гол учир нь тухайн байгууллагад зохистой засаглалыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий мэргэжлийн гишүүдээс бүрдсэн хамтын шийдвэр гаргадаг зөвлөлийн бүтэц юм.

## Төлөөлөн удирдах зөвлөл

---

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь ур чадварын хувьд тэнцвэртэй, олон талт манлайлагчдын бүрэлдэхүүнтэй бөгөөд шийдвэр гаргалтын түвшинд хараат бус, хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн чадвартай юм.



### Ч.Мөнхцэцэг

---

#### ТУЗ-ийн дарга

Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг Уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуульд тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Ажлын гараагаа 1996 онд Монголын Хөрөнгийн Биржээс эхлүүлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг байгууллагуудад ажиллаж байсан.

2010 оноос “Тойм” сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан.

ТУЗ-ийн түвшинд Ч. Мөнхцэцэг нь Олон улсын сургууль, Масс медиа групп зэрэг байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр ажилласан 11 жилийн туршлагатай. 2012 оны 12-р сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12-р сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна.

## ТУЗ-ийн бүрэлдэхүүн



### Ж.Үнэнбат

#### ТУЗ-ийн гишүүн

Ж.Үнэнбат нь 1985 онд Москвагийн Эдийн засаг, статистикийн дээд сургуулийг Эдийн засагч, статистик мэргэжлээр төгсөж, 1994 онд АНУ-ын Нью-Йоркийн Колумбын их сургуульд Олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой.

1990 оноос Монголбанканд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996 оноос 2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 2000-2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгчээр ажилласан. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийж, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.

2010 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдож, 2020 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



### Д.Мөнхтөр

#### ТУЗ-ийн гишүүн

Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажилласан туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Тэрээр “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хувьцаа эзэмшигч болсон бөгөөд эдгээр 149 цөөнх хувьцаа эзэмшигчийг төлөөлж, 2012 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



### О.Ганжолоо

#### ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуульд Эдийн засгийн онолын чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалсан. ИБУИНХУ болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч юм. Тэрээр “PwC International Limited” компанийн Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж байсан бөгөөд өмнө нь “Бодь Интернэшнл” ХХК-ийн Санхүү хариуцсан захирал, 2016-2023 он хүртэл “Голомт Файнэншил Групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. 2022 оноос эхлэн Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



## Жэймс Б.Двайер

### ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Жэймс Б.Двайер нь АНУ-ын Notre Dame их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд тус сургуулийн 40,000 гишүүнтэй төгсөгчдийн холбооны Ерөнхийлөгчөөр дараалан сонгогдон ажиллаж байсан.

2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор Монголд анх хөл тавьж, Хойд Америкийн Бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан бөгөөд 2007 онд Монголын Бизнесийн Зөвлөлийг үүсгэн байгуулж, 2016 он хүртэл Гүйцэтгэх захирал, 2017 оны дөрөвдүгээр сар хүртэл ТУЗ-ийн Дэд даргаар ажиллаж байсан.

Тэрээр одоо Мандал даатгал ХК, Mongolian Growth Group, Монголын Финтек групп болон Сэндли ХК-ийн охин компанид ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажилладаг. Мөн Монголын Боловсролын Сангийн Ерөнхийлөгч, Монголын Бизнес Мэдээллийн Сангийн ТУЗ-ийн гишүүний албыг давхар хашиж байна.

2018 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



## Александр Пикер

### ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Александр Пикер нь Австри улсын Салзбургийн их сургуулийг бизнес, хуулийн чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн.

Анх 1989 онд ажлын гараагаа одоогийн Австри банкаас эхлүүлж, Die ERSTE bank, International Moscow Bank (IMB), Unicredit Bank, JSC ATF Bank Hypo Alpe-Adria Bank, HBI Bundesholding AG зэрэг банкнуудад Эрсдэл хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал зэрэг удирдлагын албан тушаалуудад ажиллаж байсан туршлагатай.

Тэрээр одоо Дэлхийн банкны томоохон төслүүдэд Ахлах зөвлөх, Узбекистаны Ипотека банкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалыг хашиж байсан бөгөөд одоогоор Молдав Улсын Молдиндкон банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байна.

Мөн 2021 оноос Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



## Роберт В.Ван Свитен

### ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Роберт В.Ван Свитен нь Нидерландын Хаант Улсын Лейден их сургууль болон АНУ-ын Колумбын их сургуулийг Хууль зүйн бакалавр, "Chicago Booth" их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Роберт В.Ван Свитен нь дэлхийн санхүүгийн зах зээл болон тогтвортой хөгжлийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр "Serendra Group"-ийн Гүйцэтгэх захирал, "SeaOil Philippines Inc."-ийн ТУЗ-ийн гишүүн, Засаглалын хорооны дарга, "Hong Bao Media Holdings Pte Ltd"-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүүгийн хорооны даргаар ажиллаж байна. Өмнө нь хөгжиж буй зах зээл дэх хувийн хөрөнгийн дэлхийн аж үйлдвэрийн холбоо болох EMPEA (одоо GPCA нэртэй)-ны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Сингапурын бирж, "Lehman Brothers", "General Electric", "ABN AMRO" банк зэрэг фирмүүдэд удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд Азийн хөгжлийн банкны Хувийн салбарын хөрөнгийн зах зээлийн Хэлтсийн захирлаар ажиллаж байсан. 2023 оноос Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

## ТУЗ-ийн бүрэлдэхүүн



### Ханс Холзхакер

#### ТУЗ-ийн гишүүн

Ханс Холзхакер нь 1984 онд БНАУ-ын Венийн их сургуульд Социологийн докторант, 1988 онд Эдийн засгийн магистрын зэрэг хамгаалсан. 1989 онд Венийн Ахисан түвшний судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн тэнхимд аспирантурын тэтгэлэгт хамрагдаж байсан.

Ханс Холзхакер нь 1989 оноос Лондон хотод төвтэй Венын Номура судалгааны хүрээлэнгийн Төв Европын орнуудыг хариуцсан эдийн засагчаар анх ажиллаж, 1993-1999 онд Австрийн Хөрөнгө оруулалтын банкны "GiroCredit Research"-д улс орны эрсдэл, судалгаа хариуцсан дарга, 1999-2001 онд АНУ-ын Вашингтон дахь Олон улсын санхүүгийн хүрээлэнд Чех, Словак, Словени, Украин улсуудыг хариуцсан Ахлах эдийн засагчаар ажиллаж байсан.

Тэрээр Төв болон Зүүн Европ, тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудад эдийн засагчаар 30 гаруй жил ажилласан туршлагатай. 2020 оноос Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны хүрээлэнгийн Ерөнхий эдийн засагчаар ажиллаж байгаа ба 2024 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



### З.Солонго

#### ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

З.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател их сургуулийн бакалавр, 2017 онд СЭЗИС-ийн Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

2017 онд Олон улсын санхүүгийн корпорац (IFC)-аас Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын мастер хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос хойш Голомт банканд ажиллахдаа Гүйцэтгэх захирлын түвшинд Нарийн бичгийн дарга, Туслахын албан тушаал хашиж, 2015 оны 9-р сараас хойш Голомт банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.



### А.Туяа

#### Дотоод аудитын газрын захирал

А.Туяа нь 2008 онд ХУИС-ийн Санхүүгийн удирдлагын бакалавр, МУБИС-ийн Боловсролын бакалавр, 2015 онд Австралийн үндэсний их сургуулийн Санхүүгийн магистрын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2008-2017 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2017-2019 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст ахлах аудитор, 2019-2023 онд Дотоод аудитын газрын Зайны аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсийн захирлаар тус тус ажилласан бөгөөд 2023 оноос Голомт банкны Дотоод аудитын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

## Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг

### ТУЗ-ийн хурал

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нийт 25 (4 ээлжит, 21 ээлжит бус) удаа хуралдаж, 66 асуудал хэлэлцэн 49 тогтоол (шийдвэр) гаргав.

### Шийдвэр

#### Стратеги, бизнес төлөвлөгөөтэй холбоотой:

ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 11 хэлэлцүүлэг болсны үндсэн дээр нийт 12 шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

#### Хөрөнгө оруулалттай холбоотой:

ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 8 хэлэлцүүлэг болсны үндсэн дээр нийт 18 шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

#### Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулах:

Нийт 8 шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

#### Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулах:

Нийт 13 бодлого журмыг сайжруулан шинэчлэв.

## Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх 4 хороо:

Эрсдэлийн удирдлагын  
хороо

Аудитын  
хороо

Нэр дэвшүүлэх  
хороо

Засаглал, ёс зүй,  
цалин урамшууллын  
хороо

## ТУЗ-ийн дэргэдэх хороод

### Эрсдэлийн удирдлагын хороо

#### Бүрэлдэхүүн:

#### Хорооны дарга:

Александр Пикер ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Хорооны гишүүд:

Жэймс Б. Двайер Хараат бус гишүүн

Роберт В. Ван Свитен Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг Гишүүн

Ж.Үнэнбат Гишүүн

Хорооны 5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Хорооны хурал:

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 онд нийт 29 удаа хуралдаж, нийт 94 асуудал хэлэлцэн холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

#### Хэлэлцсэн асуудал:

- 83% нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын зээлийн хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны шийдвэрийн хяналт
- 12% нь Эрсдэл, комплаенсийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн лимитийн хэрэгжилтийн хяналт
- 5% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл

### Аудитын хороо

#### Бүрэлдэхүүн:

#### Хорооны дарга:

Жэймс Б. Двайер ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Гишүүд:

Александр Пикер Хараат бус гишүүн

Ханс Холзхакер Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг Гишүүн

Д.Мөнхтөр Гишүүн

Хорооны 5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Хорооны нарийн бичгийн дарга:

А.Туяа Дотоод аудитын газрын захирал

Аудитын хороо нь дараах үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Санхүүгийн тайлан
- Дотоод хяналтын тогтолцоо
- Дотоод аудитын үйл ажиллагаа
- Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа
- Комплаенсын үйл ажиллагаа
- Тайлагналын үйл ажиллагаа
- Бусад үйл ажиллагаа

**Хорооны хурал:**

Аудитын хороо нь 2024 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 10 удаа, дунджаар 86%-ийн ирцтэй хуралдаж, 40 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

**27.5%**

Банкны үйл ажиллагаатай холбоотой

**10%**

Хөндлөнгийн аудитын үр дүн, зөвлөмжтэй холбоотой

**20%**

Дотоод аудитын тайлантай холбоотой

**2.5%**

Монголбанкны шалгалтын үр дүн, үүрэгтэй холбоотой

**17.5%**

Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой

**22.5%**

Бусад

Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байдаг. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Аудитын хороо нь банкны сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж, удирдлагын багт үүрэг, зөвлөмж өгдөг. Мөн хөндлөнгийн аудитын тайлан, Монголбанкны шалгалтын үр дүнг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д хүргүүлж ажилладаг.

Аудитын хороо нь Нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд гарч буй санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтүүд, банкыг нэр хүндийн эрсдэлд оруулж болзошгүй асуудлын талаар байнгын мэдээлэлтэй байдаг.

Аудитын хороо нь Дотоод аудитын үйл ажиллагааны эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлал, сайн туршлагыг нэвтрүүлж буй эсэхийг болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, дотоод аудитын үйл ажиллагааны нэгжүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

## Нэр дэвшүүлэх хороо

### Бүрэлдэхүүн

#### Хорооны дарга:

Александр Пикер ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Хорооны гишүүд:

Роберт В.Ван Свитен Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг Гишүүн

Хорооны 3 гишүүний 2 нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн, үүний нэг нь засаглалын мэргэжилтэн.

#### Хорооны хурал:

Нэр дэвшүүлэх хороо нь 2024 онд нийт 3 удаа хуралдаж, 6 асуудал хэлэлцэн холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

#### Хэлэлцсэн асуудал:

- Дүрмийн нэмэлт, өөрчлөлт
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалт
- Бүтэц зохион байгуулалт, Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв

## Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо

### Бүрэлдэхүүн

#### Хорооны дарга:

Жэймс Б.Двайер ТУЗ-ийн Хараат бус гишүүн

#### Хорооны гишүүд:

Александр Пикер Хараат бус гишүүн

Ч.Мөнхцэцэг Гишүүн

Хорооны 3 гишүүний 2 нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн, үүний нэг нь засаглалын мэргэжилтэн.

#### Хорооны хурал:

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь 2024 онд 3 удаа хуралдаж, нийт 4 асуудал хэлэлцэн холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

#### Хэлэлцсэн асуудал:

- Дүрмийн нэмэлт, өөрчлөлт, баримт бичгийн хэрэгжилт
- Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв
- Цалин урамшууллын бодлого, Гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэл, урамшуулал

## Засаглалын зарчим

Бат бөх засаглалын тогтолцоог бий болгон тогтвортой сайжруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахад өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллах засаглалын зарчмуудыг оновчтой тодорхойлж, бодлого журамдаа ил тодоор тусгах нь нийт засаглалын оролцогч талууд нийцэн ажиллахад хэрэглэгддэг суурь шаардлага юм.

Голомт банкны хувьд засаглалын суурь зарчим бодлогуудаа батлан хэрэгжүүлдэг ба жил бүр тогтмол сайжруулан, олон улсын жишиг стандартыг нэвтрүүлэн ажилладаг.

## Засаглалын кодекс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 00/08 дугаар тогтоолоор батлагдсан Засаглалын кодекс нь банкны урт хугацааны тогтвортой байдлыг хангахад зориулагдсан зарчим юм. Тус бичиг баримт нь ил тод байдал, нийгмийн хариуцлага, хууль тогтоомж болон ёс зүйн хэм хэмжээг дээдлэх зарчимд суурилсан банкны хариуцлагатай удирдлага, гүйцэтгэл, хяналтын тогтолцоог төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

Энэхүү Засаглалын кодексийг Голомт банк, түүний бүх ажилтан, албан тушаалтнууд сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл хангуулдаг.

Засаглалын кодекс нь дараах хэсгүүдээс бүрддэг. Үүнд:

### 1 Голомт банкны засаглалд оролцогч талууд

- Хувьцаа эзэмшигчдийн эрх
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Гүйцэтгэх удирдлага
- Аудит ба тайлагнал

### 2 Холбогдох бусад бодлогууд

- Ёс зүйн дүрэм
- Авлигын эсрэг бодлого
- Сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам
- Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого
- Луйврын эсрэг бодлого
- Улс төрийн оролцооны
- Зөрчлийг мэдээлэх тухай бодлого

## Ёс зүйн код

Голомт банкны бүх ажилтан, албан тушаалтнууд энэхүү ёс зүйн зарчмуудыг цаг үргэлж сахих ёстой бөгөөд зарчмууд нь банкны бодлого, журмын салшгүй нэг хэсэг байна. Энэхүү баримт бичиг нь Засаглалын кодексийн нэг хэсэг болон батлагдсан бөгөөд дараах 21 зарчмыг агуулна. Үүнд:

1. Харилцан итгэлцэлд үндэслэсэн харилцаа
2. Банкны болон харилцагчдын хөрөнгө, ашиг сонирхлыг хамгаалахуй
3. Хууль сахихуй
4. Голомт банкны бүхий л бодлого, журам, зааврыг мөрдөхүй
5. Мэдээллийн нууцыг хадгалахуй
6. Үг амлалт бүр хариуцлага
7. Бусад байгууллагад ажиллах тухай
8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцахуй
9. Олон нийтийн цахим сүлжээ
10. Зүй бус бэлэг урамшууллаас татгалзахуй
11. Сонирхлын зөрчлөөс зайлсхийхүй
12. Ажилтнуудын хувийн дансыг зохистой хэрэглэхүй
13. Хувийн өр
14. Хувийн гүйлгээ
15. Хувийн асуудалд анхаарал хандуулахуй
16. Мэргэжлийн өсөлт
17. Бусадтай харилцахдаа чин үнэнч байх
18. Биеэ зөв авч явахуй
19. Хувийн дүр төрхөө зохистой байлгахуй
20. Бэлгийн дарамтгүй ажлын байр
21. Дүгнэлт зарчим

## Соёлын кодекс

Байгууллагын соёл, дотоод эерэг уур амьсгалыг бэхжүүлэх болон нийт ажилтны дагаж мөрдөн үйл ажиллагаандаа баримтлах чухал засаглал болон соёлын бодлогын баримт бичиг болох Соёлын кодексийг ТУЗ-өөс санаачлан баталсан. Шинэ санаачилгыг дэмжих, олон улсын туршлагыг судлах хүрээнд ТУЗ нь банкны Соёлын кодексийг 18 зүйлтэй, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт 2023 оны 12 дугаар сарын 28-ны 00/39 дугаар тогтоолын хавсралтаар баталсан. Үүнд:Харилцан итгэлцэлд үндэслэсэн харилцаа

- Зөв зүйлийг хийхүй – ёс зүйтэй үйлдэхүй
- Бүгдийг хүндлэхүй – ялгаатай байдал, эрх тэгш байдал болон оролцоот байдал
- Шийдвэр гаргалт
- Голомт банкны удирдах ажилтны үүрэг
- Асуудлыг ярилцахуй
- Шударга чөлөөт зах зээл
- Харилцагчид шударга хандах, тэдэнтэй харилцахуй
- Ажилтантай холбоотой үйл ажиллагаа
- Тогтвортой байдал болон хүний эрхийг дээдлэхүй
- Зохицуулагч байгууллагатай харилцахуй
- Буруу санахын тухайд бидний үзэл бодол
- Ажлын байрыг эрүүл, аюулгүй байлгахуй
- Төрөл саданг ажилд авах болон сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй бусад харилцаа
- Харилцагч болон бизнесийн хамтрагчтай холбоотой сонирхлын зөрчил
- Байгууллагын тогтвортой байдлыг хангахуй
- Согтууруулах ундааны хэрэглээ
- Мөрийтэй болон бооцоотой тоглоом тоглохуй
- Хүчирхийлэл

## Банкны бодлого

Голомт банк нь өдөр тутмын болон урт хугацаанд төлөвлөсөн бүх үйл ажиллагааны хүрээнд бодлого хэрэгжүүлдэг. Бодлогын үйл ажиллагааг жигд зохион байгуулах, үр ашигтай засаглалыг хангах үүднээс ТУЗ нь банкны бодлогуудыг тогтмол шинэчилдэг. Үүнд:

- Актив, пассивын удирдлагын бодлого
- Мэдээллийн технологийн бодлого
- Хүний нөөцийн удирдлагын бодлого
- Маркетингийн бодлого
- Хэрэглэгч төвтэй банкны бодлого
- Бизнесийн процессын удирдлагын бодлого
- Комплаенсийн бодлого
- Эрсдэлийн удирдлагын бодлого
- Зээлийн журмын бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

## Цалин урамшууллын бодлого

Голомт банкны Хөгжлийн голомт нь ажилтан байх ба Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа нь ажилтан төвтэй банк байхад зорино.

Банкны Гүйцэтгэлийн удирдлагын системийг банк, нэгж болон ажилтан гэсэн шаталсан түвшинд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хянах гэсэн тасралтгүй байдлаар хэрэгжүүлдэг.

- Ажилтны цалин урамшуулал, хөнгөлөлт хангамжийн багц нь өрсөлдөхүйц байх ба цалин хөлсийг инфляцын төвшинтэй уялдуулан жил бүр шинэчилдэг.
- Цалин хөлсний систем нь ажил албан тушаалын онцлог, тухайн ажилтны чадамж, мэдлэг туршлагад үндэслэн ялгаатай байдаг.
- Урамшууллын систем нь хавтгайраагүй бөгөөд багийн болон хувь хүний гүйцэтгэлд үндэслэсэн байдаг.
- Чадамжийн удирдлагыг хэрэгжүүлснээр ажилтан албан тушаалаас үл хамааран өндөр цалин хөлс авах боломжтой байх ба чадамж өндөртэй ажилтныг тогтоон барих бодлогын хүрээнд арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

---

Цалин хөлсний бодлогод дараах стратегийг баримталдаг. Үүнд:

- Банкны ашиг, орлоготой уялдаатай байх
- Салбарын өрсөлдөгчийн цалин болон хөдөлмөрийн зах зээлтэй өрсөлдөхүйц байх
- Ажилтны чадамжийн үнэлгээнд суурилсан цалингийн өсөлт ялгаатай байх
- Ажлын байрны ангилал, зэрэглэл, мэргэжлийн ур чадвар болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байх

Цалин хөлсний системд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шударга байх
- Нэгдмэл нэг системтэй байх
- Нууцлалтай байх
- Хуульд нийцсэн байх
- Ялгаварлан гадуурхахгүй байх

Банк Ажилтны үндсэн цалин, ээлжийн амралтын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, хөнгөлөлтийг мөнгөн хэлбэрээр, үндэсний мөнгөн тэмдэгтээр олгоно.

---

### ТУЗ-ийн цалин урамшуулал

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталдаг. Энэ нь хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн төсвийг хянаж, хэлэлцэх, батлах боломжийг олгодог тул ил тод, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцсэн байдлыг хангадаг.

ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал нь дараах бодлогыг баримталдаг. Үүнд:

- Үндсэн цалин
- Хорооны гишүүний нэмэгдэл
- Хорооны даргын нэмэгдэл

## Оролцогч талууд

---

Зохистой засаглалыг хэрэгжүүлэгч үндсэн үүрэг ТУЗ-д байх боловч засаглалын тогтолцоонд оролцогч бүх талууд болох Хувьцаа эзэмшигчид, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, хамтрагч байгууллагууд, харилцагч нар бүгд өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлаж, зохистой хэмжээндээ тогтолцоонд оролцох үүрэг хариуцлагатай байх зарчмыг баримталдаг.

Харин энэхүү үүрэг, хариуцлага нь тодорхой, ойлгомжтой, ил тод байх засаглалын тогтолцоог бид бүрдүүлэн удирдан хэрэгжүүлдэг.

## Хувьцаа эзэмшигчид

Голомт банкны нийт хувьцааны  
11.6 хувь буюу 93 мянга гаруй нэгж  
хувьцааг олон нийт эзэмшиж байна.

### Голомт Файнэншил Групп ХХК

# 77.2%

Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус групп компанид даатгалын зах зээлд томоохон байр суурь эзэлдэг Мандал Даатгал зэрэг санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд багтдаг. Голомт Файнэншил Групп компанийг иргэн Д.Баясгалан 100% эзэмшдэг.

### Свисс-Мо Инвестмэнт Эй Жи

# 5.21%

Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Валют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон. Свисс-Мо Инвестмэнт Эй Жи компанийн 99%-ийг ноён Урс Э. Шварценбах эзэмшдэг.

### Бодь Интернэшнл ХХК

# 5.99%

Бодь Интернэшнл ХХК нь Голомт банкны энгийн хувьцааны 3.42 хувийг шууд эзэмшдэг, үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг. Бодь Интернэшнл ХХК-ийн 77%-ийг иргэн Д.Баясгалан, 23%-ийг иргэн Ч.Мөнхцэцэг эзэмшдэг.

Бодь Интернэшнл ХХК нь Голомт банкны 2.57%-ийг 2014 онд үүсгэн байгуулагдсан өөрийн 100%-ийн эзэмшлийн Голомт Инвестмэнт Лимитэд компаниар дамжуулан эзэмшдэг ба энэхүү компани нь эрх зүйн хувьд БВА (BVI)-д бүртгэлтэй болно.

### Олон нийт

# 11.6%

Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна. Голомт банкны хувьцааг эзэмшдэг жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо тогтмол нэмэгдсээр оны эцсийн байдлаар 21,000 орчим хувьцаа эзэмшигчтэй болсон байна.

---

### Дийлэнх хувьцаа эзэмшигчид

Дийлэнх хувьцаа эзэмшигч нартай харилцах банкны харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомж, журмын шаардлага хэрэгжилтийг хангах үүднээс нөлөө бүхий хувьцаа эзэмшигчидтэй ажиллах харилцааг банкны нарийн зохицуулалтаар хэрэгжүүлдэг.

Голомт банк нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудад холбогдох тайланг жилийн байдлаар, хагас жил, улирал, сар бүр хүргүүлж, ил тод, хариуцлагатай байдлыг ханган ажиллаж байна. Тайлангийн мэдээлэлд холбоотой талын хэлцэл, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан болон хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бусад тайлангууд хамаардаг.

---

### Жижиг хувьцаа эзэмшигчид

Голомт банк нь 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, 21,000 гаруй жижиг хувьцаа эзэмшигчидтэй болсон. Эдгээр жижиг хувьцаа эзэмшигчдийн хууль эрх зүйн эрхийг засаглалын зохистой тогтолцоогоор хамгаалсан байдаг ба компанийн удирдлагад Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оролцох боломжийг бүрэн хангаж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцох, санал өгөх, асуулт асуух эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлөөр хангах үүднээс хурлыг танхимаар биечлэн оролцох болон зайнаас цахим хэлбэрийг хослуулан оролцох байдлаар зохион байгуулж, урьдчилан санал авах цахим системийг хөгжүүлсэн. Үүгээр дамжуулан санал өгөх, хурлын материалтай танилцах, мэдээлэл авах боломжоор ханган ажилладаг. Хуралтай холбоотой аливаа асуулт, саналыг цахим шуудангаар болон лавлах утас, боломжит бүх харилцах боломжит сувгуудаар нээлттэй хүлээн авч, шийдвэрлэдэг.

---

Нээлттэй хувьцаат компанийн хувьд мэдээллийн ил тод, ойлгомжтой байдалд анхаарч ажилладаг. Үүнтэй холбоотойгоор Хөрөнгө оруулагчтай харилцах нэгжийг байгуулан банкны үйл ажиллагааны бүтцийг өөрчлөн шинэчлээд байна. Ингэснээр банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, засаглалын тайлан болон бусад холбогдох мэдээллийг ил тод мэдээлэх үйл ажиллагааг улам төрөлжүүлэн сайжруулсаар байна. Голомт банк бүх хувьцаа эзэмшигчдэд шударга хандах, үйл ажиллагаандаа ил тод байдлыг хангах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах хариуцлагатайгаар биелүүлэн хууль журмын дагуу бүрэн хэрэгжүүлэн ажилладаг.

---

### Хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах

Голомт банк анх 2022 онд IPO хийж, 2024 онд анхны олон улсын бонд гаргаснаар хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагааг улам сайжруулах стратегийг баримталж, харилцааны нэгжийг шинээр байгуулсан. Ингэснээр хөрөнгө оруулагчдад чиглэсэн сар бүрийн тайлан, банкны санхүүгийн жилийн, хагас жилийн үр дүн, үйл ажиллагааг танилцуулж, тайлагнах арга хэмжээ, уулзалтуудыг зохион байгуулан хөрөнгө оруулагчдыг тогтмол мэдээллээр хангахыг тэргүүн зорилгоо болгож ирсэн билээ. Харин 2024 оноос хөрөнгө оруулагчдын харилцааны олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, олон улсын нээлттэй компаниудыг жишиг стандартын дагуу үйл ажиллагаагаа сайжруулах зорилготойгоор хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого боловсруулаад байна.

---

Энэхүү бодлогын хүрээнд банк нь дараах зарчмуудыг баримтлан хөрөнгө оруулагчидтай харилцах функцийг хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Үүнд:

- Одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагч, оролцогч талуудтай итгэлцлийн харилцаа тогтоож, хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэн нөхцөл байдлыг бодитой үнэлж дүгнэхэд нь шаардлагатай, үнэн зөв, бүрэн мэдээллээр хангах
- Банкны хөрөнгө оруулагч, холбоотой талуудад мэдээлэл олгохдоо үл ялгаварлах зарчмыг баримтлан, ижил тэгш мэдээллээр хангах
- Банк нь зөвхөн томилсон төлөөлөгч ажилтнаар дамжуулан банкны үйл ажиллагаатай холбоотой чухал шийдвэр, мэдээллийг дамжуулан хүргэх
- Банк нь хэзээ, ямар мэдээллийг ямар сувгаар хөрөнгө оруулагч, болон бусад оролцогч талуудад хүргэхийг хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөөнд нийцтэй байх
- Банк нь мэдээлэл хүргэхдээ тодорхой бус, хоёрдмол агуулгатай мэдээ мэдээллийг гаргахаас зайлсхийнэ

Энэхүү бодлогын хүрээнд хөрөнгө оруулагчдад тогтмол хугацааны давтамжтайгаар мэдээллийг ил тод тайлагнах зорилгоор 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагааны календарийг боловсруулан олон нийтэд хүргэн ажиллаад байна. Тус календарийг нийтэд мэдээлснээр банкны тайлагнах санхүү үр дүн болон үйл ажиллагааны тайлан зэрэг банкны үнэлэмжид нөлөөлөхүйц ач холбогдол бүхий мэдээллийн нийтлэгдэх хугацаа тодорхой болж, улмаар хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эергээр нөлөөлнө хэмээн банкны зүгээс үзэж байна.

Банкны хөрөнгө оруулагчдад чиглэсэн 2025 оны календарьтай харилцагч, хөрөнгө оруулагчид Голомт банкны цахим хуудасны “Хөрөнгө оруулагчид” цэсээс танилцах боломжтой.

## Ёс зүй, ил тод байдал

Голомт банкны засаглалын тогтолцоонд ёс зүйтэй, ил тод байх зарчмууд багтаж, бүх үйл ажиллагаандаа хариуцлагатай байх зарчмыг баримталдаг бөгөөд зохицуулагч байгууллагууд, хөрөнгө оруулагчид, олон нийт зэрэг бүх оролцогч талуудтай тодорхой, нээлттэй харилцахыг эрмэлздэг. Санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь, хүртээмжтэй байлгахын тулд нээлттэй тайлагнах, мэдээллийг ил тод болгох зарчмыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Зохистой засаглалын тогтолцоогоор Голомт банк харилцагчдын итгэлийг хадгалж, шийдвэр гаргах бүх шатанд ёс зүйн дээд хэм хэмжээг баримталдаг.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанкны “ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Санхүүгийн зохицуулах хорооны “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх журам”, “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгасан мэдээллийг зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчид, олон нийтэд тогтмол мэдээлж, шинэчилдэг.

Үүнд:

- Жилийн эцсийн санхүүгийн тайлан
- Аудитлагдсан санхүүгийн тайлан
- Үйл ажиллагааны тайлан
- Хагас жилийн санхүүгийн тайлан
- Хагас жилийн үйл ажиллагааны тайлан
- Жилийн тайлан
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан
- Холбоотой талуудын тайлан
- Засаглалын тайлан
- Тогтвортой хөгжлийн тайлан
- ТУЗ-ийн Хараат бус гишүүдийн тайлан
- Бусад цаг тухайд мэдээлэх тайлан

## Комплаенс ба тайлагнал

### Комплаенс болон мөнгө угаахтай тэмцэх

Голомт банк комплаенсийн үйл ажиллагааг хууль журам, олон улсын жишиг стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна. Комплаенсийн хэлтэс нь Эрсдэл хариуцсан захиралд шууд харьяалагдан ажил үүргээ тайлагнахаас гадна Төлөөлөн удирдах Зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлан мэдээллийг шууд хүргүүлж, үүрэг даалгавар, чиглүүлэг авч ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс Комплаенсийн хэлтсийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, мэргэшсэн байдалд маш их анхаарч холбогдох нөөцийг хангалттай хуваарилдаг ба үүний үр дүнд Комплаенсийн хэлтэст олон улсын мэргэшсэн цол (Certified Anti-money Laundering Specialist)-ыг хүртсэн ажилтнууд ажиллаж байна. Түүнчлэн ажилтнууд нь олон улсын холбогдох байгууллагын гишүүнээр элсэж, мэргэжлийн сургалт, семинар, чуулга уулзалтад оролцож, олон улсын мэргэжил нэгтнүүдээс мэдлэг, туршлага хуваалцан улам илүү мэргэшиж байна.

ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал тутам Комплаенсийн /МУТСТ/ үйл ажиллагааны явц, нөхцөл байдал, эрсдэл, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээ авахыг үүрэг болгон хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. ТУЗ нь банкны Комплаенсийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах эрсдэлийн

аппетитыг тогтоож өгсөн байдаг. ТУЗ нь энэхүү бодлого болон эрсдэлийн аппетитын хэрэгжилтийн талаар, мөн банкны Комплаенсийн үйл ажиллагаанд хийгдсэн аливаа зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, бусад хөндлөнгийн аудитын үр дүн, тайлантай танилцаж, үүрэг даалгавар өгч ажилладаг. 2024 онд ТУЗ нь банкны Комплаенсийн 2024-2026 онуудад баримтлах зарчим, хэрэгжүүлэх стандарт, ажлуудыг Мөнгө угаах, терроризмтой тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрт хамруулан шинэчлэн баталсан.

Комплаенсийн бодлогын дагуу Ёс зүйн дүрэм, Комплаенсийн соёлыг банк даяар хэрэгжүүлэх үүднээс бизнесийн нэгж бүр дээр Ёс зүйн төлөөлөгчдийг томилон ажиллуулдаг. Одоогоор банкны хэмжээнд Ёс зүйн 168 төлөөлөгч ажиллаж байна.

Комплаенсийн хэлтэс нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг. Голомт банк 2024 онд Комплаенсийн үйл ажиллагааг сайжруулахаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Дотоодын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрөө шинэчлэн найруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулав.

- 
- Олон улсын геополитийкийн нөхцөл байдалтай холбоотой банкны гадаад харилцаа, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд Комплаенсийн хяналтыг улам чангатгаж, олон улсын хориг арга хэмжээний нэгдсэн мэдээллийн санг агуулсан АНУ-ын “Kharon” хайлтын системийг нэвтрүүлэв.
  - ОУ-ын томоохон банк, санхүүгийн байгууллагуудын шалгалтыг амжилттай давав.
  - БНХАУ-ын тусгай захиргааны бүс Хонконг улсад зохион байгуулагдсан “Asia Pacific AML Conference”-д оролцож, олон улсын эксперт, мэргэжилтнүүдтэй уулзаж мэдлэг, туршлагаа солилцов.
  - Банкны хэмжээнд Комплаенсийн соёлыг түгээх үүрэг бүхий Ёс зүйн төлөөлөгч нарыг идэвхжүүлэх ажлын хүрээнд тэдгээрийн дунд “Ёс зүйн төлөөлөгчийн банкны соёлд үзүүлэх нөлөө” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зарлаж, шилдэг 3 эсээг шалгаруулан Ёс зүйн төлөөлөгчдөө алдаршуулав.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд өндөр эрсдэл бүхий үйл ажиллагаа, бизнес, салбар, нэгж, харилцагчийн төрөл болон бүтээгдэхүүн, үйлчилгээнд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллав.

Банкны хэрэгжүүлж буй Комплаенсийн дотоод хяналтын хөтөлбөрт ажилтнуудын мэдлэг чухал байр эзэлдэг. Иймд банкны бүх түвшний ажилтанд комплаенс, тэр дундаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар цогц хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулдаг. 2024 онд банкны хэмжээнд давхардсан тоогоор нийт 2000 гаруй ажилтан (танхим болон цахим хэлбэрээр) холбогдох сургалтуудад хамрагдсан. Ажилтнуудын сургалтаас олж авсан мэдлэгийг бататгах зорилгоор жилд нэг удаа комплаенсийн сэдвээр онлайн шалгалтыг тест хэлбэрээр авдаг ба 2024 онд банкны нийт ажилтны 97 хувь нь уг шалгалтыг амжилттай өгч, тэнцсэн байна.

## Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)

### Тогтвортой хөгжлийн бодлого

Голомт банк “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээг өргөжүүлэн 2024 онд дахин шинэчлэн найруулснаар Банкны үйл ажиллагаанд баримтлах үндсэн чиглэл, хэм хэмжээ, мөн зээлийн үйл ажиллагаа дахь Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг тодорхойлох баримт бичиг болгон мөрдөж байна.

Банкны Тогтвортой хөгжлийн бодлогын үндсэн зорилго нь Голомт банк үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд байгаль орчинд ээлтэй, нийгмийн сайн сайхны төлөө, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тууштай баримтлан ажиллахад чиглэнэ.

### Бодлогын нийцэл:

- Монгол Улсын “Тогтвортой санхүүжилтийн зарчмууд”
- Монгол Улсын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг
- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн /UNEP FI/ “Хариуцлагатай банкны зарчмууд”
- НҮБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын зорилтууд”
- НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ”
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 Зорилго
- НҮБ-ын Суурь конвенцын Парисын хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт
- СТОУС-ын дэргэдэх Тогтвортой байдлын тайлагналын зөвлөлөөс гаргасан Тогтвортой байдлын стандартууд
- “Алсын Хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Кунмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ
- Монгол Улсын хууль, тогтоомжууд

Бодлогын хүрээнд банк нь дараах зарчмуудыг мөрдөн ажиллахаар тусгасан байдаг. Үүнд:

- Байгаль орчин, нийгэмд ээлтэй байх зарчим
- Хүний эрхийг хүндэтгэх, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих зарчим
- Соёлын өвийг хамгаалах зарчим
- Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих
- Санхүүгийн хүртээмжийг дэмжих
- Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих
- Ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих
- Манлайлан үлгэрлэх
- Дотоод үйл ажиллагаандаа баримтлах байгаль орчин, нийгмийн зарчим

Үүнээс гадна банкны бүх ажилтнууд тэгш эрх, тэгш боломжийг банкны хэмжээнд дараах бодлогуудад тусгасан байдаг:

- Хүний нөөцийн үйл ажиллагааны бодлого
- Сургалт хөгжилд баримтлах бодлого
- Маркетингийн үйл ажиллагааны бодлого
- Байгалийн нийгмийн хариуцлагын бодлого
- Зээлийг үйл ажиллагаанд баримтлах байгаль орчин, нийгмийн бодлого
- Зээлийн шийдвэр гаргахдаа баримтлах зарчим
- Банкны дотоод үйл ажиллагаандаа баримтлах бодлого

## Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого

Банк нь Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг 2018 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тогтмол давтамжаар хянан нийцүүлж байна.

Уг бодлогын зорилго нь Голомт банкны бүхий л үйл ажиллагаанд, тэр дундаа маркетинг болон худалдан авалт, бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, ажлын байранд үүсэх харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Бодлогын нийцэл:

- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилго, зорилтууд
- Монгол Улсын жендэрийн тэгш эрх байдлыг хангах тухай хууль, бусад акт
- Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө

Энэхүү бодлогыг Голомт банкны бүх ажилтан дагаж мөрдөнө. Мөн банкны түншүүд болон бизнесийн үйл ажиллагаанд оролцогч талуудад хамаарна.

### Бодлогын үндсэн бүтэц:

- Жендэрийн тэгш байдлыг хангах үндсэн зарчмууд
- Жендэрийн тэгш эрхийг хангах арга замууд
- Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох заалтууд
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц, тогтолцоо

Жендэрийн тэгш байдлыг хангах үндсэн зарчмыг дараах байдлаар бүлэглэн тусгасан. Үүнд:

- Жендэрийн тэгш эрхийн зарчим
- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим
- Банкны хариуцлагын зарчим
- Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим

---

### Тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандарт

Байгальд ээлтэй тогтвортой урт хугацааны үйл ажиллагаа нь банкны үйл ажиллагаанд баримтлан хэрэгжүүлдэг үндсэн зарчмуудын нэг ба дараах стандартуудаар зохицуулагдаж байна.

- Тогтвортой, ногоон худалдан авалтын стандарт
- Тогтвортой, ногоон засвар үйлчилгээний стандарт
- Тогтвортой, ногоон цэвэрлэгээний стандарт
- Тамхигүй орчин бүрдүүлэх хязгаарлалтын стандарт
- Хортон шавжтай тэмцэх стандарт

---

### Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэл

#### Стратеги төлөвлөгөөний хүрээ

Голомт банкны стратеги төлөвлөлтийн хүрээ нь олон улсын жишигт нийцүүлэн банкны бизнесийн богино, дунд, урт хугацааны зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн бизнес үйл ажиллагааг хэрхэн сайжруулах, хэрэгжүүлэх тухай баримт бичиг юм.

Стратегийн чиглэл баримжааг Төлөөлөн удирдах зөвлөлийн тодорхойлсноор Гүйцэтгэх захирал ахлан Санхүү хариуцсан захирал Санхүүгийн удирдлагын газрын Төлөвлөлт, үнэлгээний хэлтсийн зүгээс боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөл нь төсөв, бизнес төлөвлөгөөг хянан баталдаг.

---

### Гүйцэтгэл, тайлагналын зарчим

Банкны санхүүгийн үр дүн болон бизнес төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг Дотоод аудитын газрын баталгаажуулалт хийснээр ТУЗ-ийн Аудитын хорооны хурлаар сар бүр тогтмол тайлагнаж ажилладаг.

Тайлант хугацаанд засаглал, эрсдэлийн удирдлага, холбогдох хууль журмын дагуу банкны давуу талыг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлийг багасгах зорилгоор төсөв, бизнес төлөвлөгөөг боловсруулсан. Тус үйл явц нь банкны дотоод болон гадагшаа чиглэсэн үйл ажиллагааны зорилттой уялдаж байгаа эсэхийг KPI-аар болон тогтмол хяналтаар баталгаажуулдаг.

## Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын хүрээ

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн томоохон үүргүүдийн нэг нь эрсдэлийн хүчтэй соёлыг бий болгож, төлөвшүүлэх явдал байдаг. Тиймээс ТУЗ нь банкны стратеги зорилт, үйл ажиллагааны орчин, зохицуулагч байгууллагуудын шаардлагууд зэрэгтэй уялдсан эрсдэлийн аппетитийг баталж, үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг. ТУЗ нь энэ чиг үүргээ Эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд баталсан эрсдэлийн аппетит, эрсдэлийн лимитийн хэрэгжилтийг сар бүр хянан ажилладаг.

Дотоод хяналтын тогтолцоо нь эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналттай холбоотой журмуудаас бүрдэх бөгөөд эдгээр нь банкны бизнесийн үйл ажиллагаа, банканд одоо учирч байгаа болон ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдийг харгалзсан байдаг.

Бизнесийн бүх нэгжүүд өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээг хийдэг бөгөөд энэ нь дотоод хяналтын үр дүнтэй байдал, журам, зааврын хэрэгжилтийг дүгнэх зорилготой байдаг. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны Хоёрдугаар шугамын нэгжүүдийн зүгээс гол үйл ажиллагаа, хяналтууд дээр хяналт болон мониторингийг тасралтгүй хийдэг. Харин Гуравдугаар шугамын нэгж буюу Дотоод аудитын газраас Хараат бус баталгаажуулалтыг хийж гүйцэтгэдэг.

Банк ёс зүйн өндөр соёлыг хадгалж ажиллахын тулд Ёс зүйн код болон Соёлын кодыг мөрддөг бөгөөд эдгээр нь банкны зүгээс аливаа үйл ажиллагааг эрхлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг баримталж, шударга, хариуцлагатай ажиллахаа тунхагласан баримт бичгүүд юм. Эдгээр баримт бичгүүд зөрчигдсөн талаар мэдэгдсэн ажилтнуудыг хамгаалах, тэдэнд өс санахгүй байх зэрэг зохицуулалтуудыг дээрх баримт бичгүүдэд тусгасан байдаг.

## Дотоод аудитын үйл ажиллагаа

Роботик процесс автоматжуулалт ашиглан Real time аудитын суурийг тавьснаар бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагаанд тодорхойлсон үзүүлэлтийн хүрээнд байнгын мониторинг хийгдэх боломжтой болов.



Голомт банкны дотоод аудитын үйл ажиллагаа нь Олон улсын Дотоод аудитууудын институт (The Institute of Internal Auditors)-ийн гаргасан Дотоод аудитын мэргэжлийн туршлагын олон улсын хүрээ (International Professional Practices Framework)-нд нийцсэн бөгөөд үндсэн зорилго нь эрсдэлд суурилсан, хараат бус, бодит баталгаажуулалт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар банк, түүний нэгж, үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх, стратеги зорилгодоо хүрэхэд нь туслахад чиглэдэг.

### Бүтэц, тайлагнал

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаагаар дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг. Банкны нэгжүүд нь эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоогоо бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах үүрэгтэй байдаг бол Аудитын хороо нь банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй.

ТУЗ-ийн Аудитын хороо нь тус чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор банкны гүйцэтгэх удирдлагын багаас хараат бус бүтэцтэй Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит хариуцсан захирлыг томилох, Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, стратеги болон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, зардлын төсвийг баталдаг. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Аудит хариуцсан захирлын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Дотоод аудитын газар, Дата анализын алба гэсэн бүтцийн нэгжүүдтэй, 35 ажилтны батлагдсан орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Дотоод аудитын газар нь Ерөнхий аудитын хэлтэс, Мэдээллийн технологийн аудитын хэлтэс, Зайны аудит, чанарын баталгаажуулалтын хэлтсээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Голомт банкны Дотоод аудитын үйл ажиллагаа нь 2021 онд олон улсын нэр хүндтэй байгууллагаар Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэсэн. Олон улсын Дотоод аудитууудын институт (The Institute of Internal Auditors)-ийн Дотоод аудитын мэргэжлийн туршлагын олон улсын хүрээ (IPPF)-г бүрэн хангаж байна гэх сайн үнэлгээ авсан Монгол Улсын анхдагч байгууллага юм. Мөн жил бүр дотоод чанарын баталгаажуулалтыг хийж, Дотоод аудитын мэргэжлийн туршлагын Олон улсын хүрээ (IPPF)-г хангах, үйл ажиллагааг нийцүүлэх ажлыг хийж байна.

## Аудитын хамрах хүрээ, аргачлал

Дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан аргачлал ашигладаг бөгөөд улирал бүр банкны бизнес төлөвлөгөө, нэгж, үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, үр дүнд үндэслэн аудитын төлөвлөгөө болон хамрах хүрээг тодорхойлж байна.

Банк нь стратеги зорилтууддаа хүрэх, тодорхойлсон эрсдэлийн аппетитын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо хангалттай, үр дүнтэй байгаа эсэхийг Дотоод аудитын газар үнэлж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар банкны үйл ажиллагаанд үнэ цэн нэмж байна.

Зөвлөх үйлчилгээг банкны менежментийн багийн хүсэлтээр хийдэг. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор, удирдлагын болон гүйцэтгэх чиг үүрэг хүлээлгүйгээр банкны нэгж, үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

## Дотоод аудитын үйл ажиллагаа

- 2024 онд аудит хийхдээ сайн засаглалын зарчмуудын хэрэгжилт, банкны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл болон шинэ тутам бий болж буй эрсдэлд төвлөрч ажилласан.
- Аудитын өдөр тутмын үйл ажиллагааг хялбарчлах, ажлын баримтын бүртгэл, тайлан мэдээллийг сайжруулах зорилгоор Дотоод аудитын үйл ажиллагаандашиглагддаг "Аудит солюшн" системийг шинэчилж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Энэхүү шинэчлэлт нь аудитын өдөр тутмын үйл ажиллагааг олон улсын Дотоод аудиторчуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн Дотоод аудитын мэргэжлийн туршлагын олон улсын хүрээ (IPPF)-тэй бүрэн нийцүүлэхэд чухал нөлөө үзүүлэв.

- Дижитал банк концепцийн хүрээнд банкны дотоод дижитал шилжилтийг бүтэн процессоор нь үнэлж, баталгаажуулан дотоод үйл ажиллагааны автоматжуулалт, процессын төвөгшил, цаашид сайжруулах зүйлсийг тодорхойлсноор Голомт банкны гүйцэтгэх удирдлагын багийн зүгээс банкны процессыг хялбарчлах, асуудлыг бүхлээр нь олж илрүүлэхэд томоохон дэмжлэг болсон.
- Роботик процесс автоматжуулалт ашиглан Real time аудитын суурийг тавьснаар бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагаанд тодорхойлсон үзүүлэлтийн хүрээнд байнгын мониторинг хийгдэх боломжтой болсон.
- Эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай өгөгдөл цуглуулах, мэдээлэл боловсруулах, программд бүртгэх процесст роботик процесс автоматжуулалт нэвтрүүлснээр нийт ажиллагааны 50%-ийг хүний оролцоогүйгээр хийж эхлэв.
- Дотоод аудиторчууд мэргэжлийн ур чадвараа дараагийн түвшинд гаргаж, Олон улсын Дотоод аудитын институтиас олгодог CIA (Certified Internal Auditor) цолыг шинээр 3 аудитор, CEH Master (Certified Ethical hacker master) мэргэшлийн сертификатыг 1 аудитор авч, нийт аудиторчуудын 20%-ийг олон улсын цол зэрэгтэй, мэргэшсэн аудитор эзэлж байна.

## Удирдлагын баг



**А.Одонбаатар**  
Гүйцэтгэх захирал



**Г.Ганболд**  
Ерөнхийлөгч



**М.Сайнбилэг**  
Мэдээллийн технологи  
хариуцсан захирал



**С.Мөнхтуяа**  
Санхүүгийн удирдлагын  
газрын захирал



**М.Наранхүү**  
Зээлийн газрын захирал



**Т.Отгон**  
Эрсдэлийн удирдлагын  
газрын захирал



**Б.Содболор**  
Нөөцийн удирдлагын  
газрын захирал



**Б.Сугар-Эрдэнэ**  
Байгууллагын банкны  
газрын захирал



**Ц.Байгалмаа**  
Жижиг, дунд банкны  
газрын захирал



**З.Сугар**  
Иргэдийн банкны газрын  
захирал



**О.Батцэнгэл**  
Дижитал банкны газрын  
захирал

**Г.Уянга**

Хүний нөөцийн  
удирдлагын газрын  
захирал

**Н.Очирхуяг**

Маркетинг, олон нийттэй  
харилцах газрын захирал

**Б.Энхзаяа**

Олон улсын банкны  
газрын захирал

**Б.Энхтүвшин**

Зээл цуглуулах газрын  
захирал

**Ё.Пүрэвбат**

Бүртгэл тооцооны газрын  
захирал

**Ж.Оюун**

Дижитал шилжилтийн  
газрын захирал

**Х.Пүрэвдорж**

Захиргааны газрын  
захирал

**Г.Мандах**

Харилцагчийн бүртгэлийн  
газрын захирал


**А.Нямсүрэн**



Харилцагчийн  
үйлчилгээний газрын  
захирал

**Д.Баяржаргал**

Мэдээлэл технологийн  
газрын захирал

# Бүтэц, зохион байгуулалт





# Эдийн засаг, санхүүгийн тойм



Олон улсын зах зээлээс  
татан төвлөрүүлсэн бонд

# 400


сая ам.доллар

2024 онд импортын өсөлт урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэн валютын нөөцөд сэргөөр нөлөөлж байгаа ч олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Fitch, S&P, Moody's байгууллагууд 2014 оноос хойш анх удаа дахин Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж, B+, B2 түвшинд хүргэсэн нь гадаадын зах зээл дээр гаргах бондуудын тоог нэмэгдүүлж, санхүүжилт амжилттай татах боломжийг бий болгов.

## Эдийн засгийн тойм

### Дэлхийн эдийн засгийн тойм

2024 он бодлого боловсруулагчдын хувьд инфляцыг бууруулах, ажилгүйдлийг доогуур түвшинд барих, эдийн засгийн өсөлтийг хадгалах даалгавар авсан хүндхэн жил байлаа. Эдийн засгийн өсөлтийг дэмжих үү, инфляцыг буулгах уу? нөхцөлд бодлого боловсруулагчид орсон ч ихэнх улс орнууд инфляцын хөөргөдлийг буулгах шийдвэрийг сонгож, хоёр жилийн туршид мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлснээр үр дүнд нь инфляцыг зорилтот түвшинд хүргэж чадав.




Мөнгөний хатуу бодлогоос гадна Орос-Украины дайны дараах түүхий эдийн үнийн өсөлт, тэр дундаа эрчим хүчний үнийн "шок"-ын нөлөө төсөөллөөс хурдан арилсан нь инфляц буурахад мөн нөлөөлсөн байна. Улмаар дэлхийн инфляцын түвшин 2023 оны эцсийн байдлаарх 6.8%-аас буурч, 2024 оны эцэст 4.2%-д хүрэх, 2025 онд 3.5%-д хүрэх хүлээлттэй байна. Энэхүү 2025 оны түвшин 2000-2019 оны 20 жилийн дундаж 3.6%-ийн түвшнээс доогуур байгаа нь инфляц хэвийн түвшинд очиж байгааг илэрхийлж байна.

Гэсэн хэдий ч дэлхийн инфляцын бууралтын хурд 2024 оны дундаас удааширч эхэлсэн бөгөөд 2023, 2024 онуудад хэт өндөр инфляцтай холбоотойгоор нэрлэсэн цалин хөлс өссөн нь ийнхүү инфляцын бууралтын хурд удаашрахад хоцрогдолтойгоор нөлөөлжээ.

Мөн цаашлаад Геополитикийн тогтворгүй байдал болон АНУ-ын 47 дахь Ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсонтой холбоотойгоор макро орчинд тодорхойгүй байдал үргэлжилж байгаа тул инфляцын түвшин 2025 оноос нэмэгдэх эрсдэлтэй байна. Тиймээс төв банкнууд цаашид мөнгөний зөөлөн бодлого үргэлжлэн хэрэгжүүлэхэд болгоомжлолтой хандаж байгаа юм. Тухайлбал, 2025 онд Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүг дахин 3-4 удаа бууруулах магадлалтай гэсэн шинжээчдийн хүлээлт байсан бол сонгуулийн дараа Доналд Трампийн авч хэрэгжүүлэх гэж буй импортод тариф ногдуулах болон татварыг буулгах шийдэмгий бодлогуудын нөлөөллөөс шалтгаалан 2025 ондоо багтаж, дээд талдаа хоёр удаа л бууруулна гэж хүлээлтээ өөрчилжээ. (Forbes, CNBC, Fed, Bloomberg)

Зөвхөн АНУ-д төдийгүй импортын тариф ногдуулах бодлого нь дэлхийн худалдааны урсгалд сөргөөр нөлөөлж, улс орнуудын экспортыг бууруулах, инфляцыг хөөрөгдүүлэх эрсдэлтэй байгаа юм.



Улс орнуудад инфляцын түвшин харьцангуй буурч байгаатай холбоотойгоор төв банкнууд хоёр жилийн туршид үргэлжилсэн мөнгөний хатуу бодлогоо суллаж, 2024 онд дэлхийн эдийн засгийн эрчимжилт нэмэгдэж эхэллээ. Тухайлбал, АНУ-ын инфляц 9-р сард 2.4%-д хүрч буурснаар Холбооны нөөцийн сан 9-р сараас эхлэн бодлогын хүүг гурван удаа бууруулж, 12-р сарын байдлаар 5.25-5.5 түвшнээс 4.25-4.5

түвшинд хүргээд байгаа юм. Мөн дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 3.2%-тай, харин ирэх жилүүдэд дунджаар 3.3%-д хүрэх хүлээлттэй байна. (ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төсөөлөл" тайлан, 2025 оны 1-р сар) Энэхүү түвшин нь 2000-2019 оны 20 жилийн дундаж 3.7%-аас харьцангуй доогуур байгаа ч 2023 оны 2.7%-ийн өсөлттэй харьцуулахад сэргэж буй үзүүлэлт юм.

## Дэлхийн эдийн засгийн тойм

**БНХАУ:** Дэлхийн хоёр дахь том эдийн засаг БНХАУ-ын хувьд 2024 оны эцэст 4.8%-ийн өсөлт үзүүлэх төлөвтэй байгаа ба энэ нь оны эхний 5%-ийн төсөөлөөс доогуур үзүүлэлт болж байна. (ОУВС, “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайлан, 2025 оны 1-р сар) БНХАУ-ын экспорт сэргэж байгаа ч худалдан авагчдын итгэл хангалттай хэмжээнд сайжрахгүй байгаа, мөн үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал үргэлжилж байгаа нь ийнхүү эдийн засгийн өсөлт харьцангуй удаашралтай байхад нөлөөлжээ. Ирэх жилүүдэд өсөлтийн түвшин доогуур буюу 2025 онд 4.6%-д, 2026 онд 4.5%-д хүрэх хүлээлттэй байна.

Мөн Доналд Трамп ирэх дөрвөн жилд Ерөнхийлөгч байх хугацаандаа дотоод үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор импортын бүтээгдэхүүнүүдэд дор хаяж 10%-ийн тариф ногдуулахаа зарласан ба БНХАУ-аас импортолж буй импортын бүтээгдэхүүнүүдэд илүү өндөр тариф тогтоох бодлоготой байгаагаа илэрхийлсэн. Судалгаанаас дурдахад АНУ-аас БНХАУ-д 20%-ийн тариф нэмэгдүүлж, тарифын нийт хэмжээ 30%-д хүрэх магадлал 65%-тай ба энэ нь АНУ руу экспортлох БНХАУ-ын нийт экспортыг 20%-аар, эдийн засгийн өсөлтийг 0.6%-аар бууруулах эрсдэлтэй байна. (The Economist Group, Feb 2025)

**АНУ:** Харин үүний эсрэгээр АНУ-ын эдийн засгийн өсөлт үргэлжилж дотоод хэрэглээний өсөлтөөс шалтгаалан 3-р улиралд 2.7%-аар өсөөд байгаа ба 2024 оны эцэст 2.8%-тай, 2025 онд 2.7%-тай буюу өсөлтөө хадгалах төсөөлөлтэй байна. Гэсэн хэдий ч тариф ногдуулахтай холбоотой худалдааны сөрөг байдал нийт экспортыг бууруулахаас шалтгаалж, АНУ-ын эдийн засгийн өсөлтөөс хойш татах эрсдэлтэй байгаа юм.


**ОХУ:** ОХУ-ын хувьд дайнаас шалтгаалсан цэрэг зэвсгийн зардал, төсвийн тэлэлт өндөр байгаатай холбоотойгоор эдийн засгийн өсөлт оны эцэст 3.8%-д хүргэх төсөөлөлтэй байна. Харин ирэх жилүүдэд дайны зарцуулалт багасах, хөрөнгө оруулалтын орох урсгал бага байгаатай холбоотойгоор эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, дунджаар 1.2%-д хүргэх төсөөлөлтэй байна.

## Монголын эдийн засгийн тойм

2024 онд УИХ-ын сонгууль өрнөж, түүхэндээ анх удаа парламентын 126 гишүүн холимог тогтолцоогоор сонгогдсоны зэрэгцээ хамтарсан засгийн газар байгуулагдсанаараа онцлогтой жил байлаа. Сонгуулийн жилийг дагаад төсвийн зардал 5 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 27.4 их наяд төгрөгт хүрэх төсөөлөлтэй байсан бол 8-р сард төсвийн тодотголын дараа дахин 3 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 30 их наяд төгрөгийг давах данхар төсвийн зардал батлагдсан. Энэ нь цар тахлаас өмнөх 2019 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн үзүүлэлт билээ.


### Монгол Улсын эдийн засгийн өсөлт, салбаруудын оролцоо, жилийн өсөлт

Бодит ДНБ-ий өсөлт /2015 суурь/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Төсвийн зардал өссөнтэй холбоотойгоор 2024 оны 4-р сард тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ба төрийн албан хаагчдын цалинг 10-20 хувиар өсгөсөн.



Өрхийн бодит орлого

**5.9%**



Эдийн засгийн өсөлт

**4.9%**

Ийнхүү 2024 онд цалингийн хэмжээ өссөн болон төсвийн тэлэлттэй холбоотойгоор тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өндөр өсөлттэй байсан нь өрхийн бодит орлого, цаашлаад зардал өсөхөд нөлөөлжээ. Инфляцыг тохируулсан өрхийн бодит орлого сүүлийн хоёр жилд тасралтгүй өсөж 2024 онд 5.9%-д хүрсэн байна. Өрхийн орлого нэмэгдэхийн сацуу аж ахуй нэгж байгууллагуудын ашигт ажиллагаа сайжирч ногдол ашиг тарааснаар мөн дотоод эрэлтийг нэмэгдүүлж 2024 онд эдийн засгийн өсөлт 4.9%-тай гарлаа.

Эдийн засгийн өсөлтийг салбараар задлан үзвэл худалдаа, үйлчилгээний салбар 4.6%-ийг, уул уурхайн салбар 1.4%-ийг бүрдүүлсэн ба цаг агаарын тааламжгүй уур амьсгал, зуд, түүнээс шалтгаалсан малын хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын доройтол эдийн засгийн өсөлтийг 3.6%-аар хойш чангаажээ. 2024 оны жилийн эцсээр малын зүй бус хорогдол 9.4 сая толгойд хүрч, 2023 оны мөн үеэс хоёр дахин, 2022 оноос 14 дахин нэмэгдсэн байна.




Хэдий дотоод эрэлтийн өсөлт нь эдийн засгийн богино хугацааны идэвхжилийг дэмжиж байгаа ч импортын өсөлт болон инфляцыг нэмэгдүүлж голлох макро үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж байна.



Тухайлбал дотоод эрэлтийн өсөлт нь Монгол Улс шиг үйлдвэрлэгч биш орны хувьд импортыг нэмэгдүүлж, гадаад худалдааны тэнцэлд сөргөөр нөлөөлж байгаа юм. Үүнээс гадна гадаад зах зээл дээр нүүрсний үнэ буурч байгаа нь экспортын өсөлтийг хязгаарлаж, гадаад худалдааны тэнцэлд давхар сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Нүүрсний биет хэмжээ 2024 оны 12-р сарын эцэст 80 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувийн өсөлттэй байсан. Гэвч хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 26 хувиар буурч, 88 ам.долларт хүрснээр нүүрсний экспортын нийт орлого 3 хувиар буурчээ.

Ийнхүү 2024 онд импорт 11.6 тэрбум ам.долларт (өмнө оны мөн үетэй харьцуулахад 26%-ийн өсөлт) хүрсэн бол экспорт 15.8 тэрбум ам.долларт (өмнө оны мөн үетэй харьцуулахад 4%-аар өссөн) хүрснээр гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан ч энэ нь 2023 онтой харьцуулахад 30%-аар буурсан үзүүлэлт болоод байна.

### Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханшийн өөрчлөлт



Улмаар 2023 оны эцэст арваад жилийн дараа ахин ашигтай гарж эхлээд байсан урсгал данс 2024 онд 2.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Ийнхүү урсгал дансны алдагдал өндөр байгаа нь валютын албан нөөц буурахад нөлөөлснөөр 3-р сараас хойш тогтвортой байсан ханш 10-р сараас эхлэн хэлбэлзэж 2024 оны эцсээр нэг ам.долларт 3'420 төгрөгт хүрч сулраад байна. (энэ тоо 3-р сараас хойш 3'380 төгрөг байсан)

## Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ

/2013-2024/

### MOODY'S

2014.07.17	<b>B1</b>
2016.08.26	<b>B3</b>
2017.03.30	<b>Саа1</b>
2020.05.20	<b>B3</b>
2024.11.18	<b>B2</b>

### FitchRatings

2014.12.11	<b>B+</b>
2017.11.17	<b>B-</b>
2018.07.09	<b>B</b>
2019.07.04	<b>B</b>
2024.09.18	<b>B+</b>

### S&P Global

2014.04.29	<b>B+</b>
2015.11.03	<b>B</b>
2016.08.19	<b>B-</b>
2018.11.09	<b>B</b>
2024.10.04	<b>B+</b>

Эх сурвалж: Сангийн Яам

Хэдий импортын өсөлт урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж, валютын нөөцөд сөргөөр нөлөөлж байгаа ч олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Fitch, S&P, Moody's байгууллагуудаас 2014 оноос хойш удаа дахин Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж, B+, B2 түвшинд хүргэсэн нь гадаадын зах зээл дээр гаргах бондуудын тоог нэмэгдүүлж, санхүүжилт амжилттай татах боломжийг бий болголоо. Улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжин санхүүгийн дансанд эерэг нөлөөлөл үзүүлж, 11-р сард санхүүгийн дансанд 2 тэрбум гаруй ам.доллар төвлөрснөөр төлбөрийн тэнцэл 40 сая ам.долларын ашигтай гараад байна.

Цаашлаад 12-р сард Худалдаа Хөгжлийн Банк 200 сая ам.долларын бонд, Голомт банк нэмэлтээр 100 сая ам.долларын бонд, мөн Улаанбаатар Хотын бонд 500 сая ам.долларын санхүүжилт амжилттай татаж чаджээ. Тиймээс эдгээр бондуудын нөлөөллөөр 2024 оны эцэст төлбөрийн тэнцэл 150 сая ам.долларын ашигтай гарах хүлээлттэй байна. (Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, 2025)




Гадаад валютын нөөц

**5.5**

тэрбум ам.доллар

Гадаадын зах зээл дээр бондуудын санхүүжилт татсанаар валютын нөөц нэмэгдэж, 12-р сарын эцсийн байдлаар 5.5 тэрбум ам.долларт хүрсэн нь түүхэн дээд хэмжээг эвдлээ. Гэсэн хэдий ч импортын өсөлт өндөр байгаагийн улмаас валютын нөөцийн импортыг хангах сарын тоо бага буюу 12-р сарын эцсийн байдлаар 5.3 сар байна. Энэхүү тоо 2023 оны эхэнд харьцангуй өндөр, 7.5 сарыг хангах түвшинд байсан бол тухайн үед валютын нөөц ердөө 3.4 тэрбум ам.доллар байжээ. Тиймээс валютын албан нөөц 2024 оны эцэст өндөр хэмжээнд байгаа нь сайн үзүүлэлт мэт боловч импортыг хангах сарын бодит түвшин 2023 онтой харьцуулахад муудсан үзүүлэлт болж байгаа юм.




Дотоод эрэлт өндөр хэвээр байгаа болон 11-р сард цахилгааны үнэ өссөн суурь нөлөөллөөр үнийн өсөлт эрчимжиж, 12-р сард 9%-тай гарлаа. Инфляц 11-р сар хүртэл зорилтот интервал дотор хадгалагдаж байсан учраас оны эхнээс Монголбанкнаас бодлогын хүүг 3 удаа бууруулж, 13%-аас 10%-д хүргээд байсан билээ. Харин 12-р сарын мөнгөний бодлогын хуралдаанаар 12-р сард инфляц Монголбанкны зорилтот 6 +/-2 түвшнийг давсанд үндэслэж, бодлогын хүүг 10%-д хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Үүгээр ч зогсохгүй зээлийн өсөлт, тэр дундаа хэрэглээний зээл өндрөөр өсөж байгаа учраас зээлийг хязгаарлах зорилгоор төгрөг болон валютын заавал байлгах нөөцийн хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 11% болон 16%-д хүргэх бодлогын хатуу арга хэмжээ аваад байгаа юм.

2023 оны хувьд эдийн засгийн сэргэлтийн дийлэнхийг уул уурхай, тээврийн салбар бүрдүүлж байсан бол 2024 онд дотоод эрэлтээр эрчимжиж, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.



Эдийн засгийн өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн өсөлт	Шинэчилсэн	2025
Голомт банк	2024 12-р сар	5.0%
Дэлхийн банк	2024 11-р сар	6.5%
АХБ	2024 9-р сар	6.0%
ОУВС	2024 10-р сар	7.0%
S&P	2024 10-р сар	6.0%
Fitch	2024 9-р сар	6.0%
Moody's	2024 8-р сар	6.0%
Монголбанк	2024 12-р сар	6.2%
<b>Дундаж</b>		<b>6.1%</b>


Олон улсын болон дотоодын томоохон байгууллагуудын дундаж таамаглалаар эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.6%-д хүрэх хүлээлттэй байна.

## Томоохон 14 мега төслийн дэлгэрэнгүй мэдээлэл

№	Хэрэгжих төслүүд	Төслийн тухай	Хэрэгжих хугацаа	Шаардлагатай санхүүжилт, санхүүжүүлэх эх үүсвэр
1	Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын ажил	Экспортын хүчин чадал 40 сая.тн хүртэл нэмэгдэнэ. Мөн экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх боломжтой.	2024-2028	<b>Нийт 958 тэрбум ₮</b> Төрийн өмчит компани, хувийн хэвшлээр санхүүжүүлнэ.
2	Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц	Жилд 3,150 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, өмнө бүсийн уул уурхайн үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчийг дотоодоос хангана.	2024-2028	<b>Нийт 2,303 тэрбум ₮</b> Улсын төсөв 691 тэрбум ₮ Хувийн Хэвшил 1,600 тэрбум ₮
3	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц	Жилд 366 сая.тн киловатт/цаг эрчим хүч үйлдвэрлэж, баруун бүсийн цахилгаан хэрэглээг 100% хангана.	2021-2028	<b>Нийт 856 тэрбум ₮</b> Гадаад зээлээр санхүүжүүлнэ.
4	Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц	25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэж, нүүрсний хэрэглээг 439 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтын 709 мянган тонноор бууруулна.	2024-2032	<b>Нийт 1,377 тэрбум ₮</b> Улсын төсөв 60 тэрбум ₮ Гадаад зээл 212 тэрбум ₮
5	Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр	Судалгаагаар Монгол Улс 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй ба үүнийг ашигласнаар дотоодын цахилгааны эрчим хүчний дутагдлыг нөхөх, эдийн засгийг төрөлжүүлэх боломжтой.	2024-2028	<b>Нийт 1,377 тэрбум ₮</b> Улсын төсөв 60 тэрбум ₮ Гадаад зээл 212 тэрбум ₮
6	Газрын тос боловсруулах цогцолбор	Бүрэн ашиглалтад орсноор жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гаргаж, дотоодын газрын тосны хэрэглээний 55%-ийг хангана.	2016-2027	<b>Нийт 4,179 тэрбум ₮</b> Гадаад зээлээр санхүүжүүлнэ.
7	Үндэсний хиймэл дагуулын сүлжээ	Иргэд оршин суугаа газраас үл хамааран интернэттэй холбогдож, мэдээллийг тэгш хүртээмжтэй авах боломж бүрдэнэ.	2024-2027	<b>Нийт 829 тэрбум ₮</b> Улсын төсөв 69 тэрбум ₮ Гадаад зээл 761 тэрбум ₮
8	Гангийн үйлдвэр	1 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба дотоодын арматурын хэрэгцээг бүрэн хангана.	2025-2028	<b>Нийт 1,446 тэрбум ₮</b> Хувийн хэвшлээр санхүүжүүлнэ.
9	Монгол, Францын хамтарсан урат, атомын цахилгааны станц	Жилд 2,500 тонн уран олборлож, экспортлон 1 тэрбум ам.доллар орлого олох ба 1000 гаруй ажлын байр бий болгоно.	2024-2028	<b>Нийт 1,700 тэрбум ₮</b> Хувийн хэвшлээр санхүүжүүлнэ.
10	Нүүрс-Хими, Кокс-Химийн цогцолбор	Нүүрсийг дахин боловсруулж, устөрөгч болгох ба нүүрсийг угаах технологийн шийдлийг бий болгож экспортыг орлогыг нэмэх болон түүхий эдийн үнээс хэт хараат байдлыг бууруулна.	2025 оноос хэрэгжүүлнэ	<b>Нийт 12,133 тэрбум ₮</b> Хувийн хэвшлээр санхүүжүүлнэ.
11	Зэс боловсруулах цогцолбор	Тус төлийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын орлогыг бүрдүүлнэ.	2024-2028	<b>Нийт 2,580 тэрбум ₮</b>

Эх сурвалж: Сангийн яам

## Томоохон 12 мега төслийн тооцоологдсон санхүүжилт, ирэх жилүүдийн зардал



Эх сурвалж: Сангийн яам

Мега төслүүдийн хөрөнгө оруулалт, данхар төсвийн зардал, ногдол ашгийн тараалтын нөлөөллөөр эдийн засгийн өсөлт эрчимжиж, 2025 оны эцэст 6.1%-д хүрэх таамаглалтай байгаа юм.

2025 оны эдийн засгийн хувьд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан 14 мега төсөл томоохон нөлөөлөл үзүүлнэ. 14 мега төслийн 7 нь хэрэгжихэд бэлэн болж, 2025 онд 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэхээр тусгагдаж, үлдсэн 7 нь бэлтгэл хангах түвшинд байгаа юм.

Одоогоор 12 мега төсөлд нийт 36.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцжээ. Харин Оюутолгой төслийг түшиглэсэн “Алт цэвэршүүлэх үйлдвэр”, зүүн бүсийн Эрээнцэв-Чойбалсан-Баруун-Урт-Бичигт боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалт, эх үүсвэр тодорхойгүй байна. Хэрэв эдгээр төсөл амжилттай хэрэгжвэл тогтвортой, урт хугацааны өсөлтийн суурийг тавьж чадна. Үүний нэг тод жишээ нь Франц, Монгол хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 1-р сарын 17-нд батлагдсан Зөөвч-Овоогийн ураны төсөл юм. Энэхүү төсөл нь БНФУ-аас 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авчирч, ирэх жилүүдэд төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх хүлээлттэй байна.

Цаашлаад 2025 он дахин данхар төсөвтэй жил байх төсөөлөлтэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригоос шалтгаалан 35.6 их наяд төгрөгөөр батлагдаад байсан төсвийн зардал танагдаж, 33.5 их наяд төгрөг болж ахин батлагдсан ч энэхүү зардал нь 2024 оноос даруй 3 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байгаа юм. Нийт төсвийн нэмэгдлийн 90 гаруй хувь нь ердөө урсгал зардлын нэмэгдэл ба 2025 оны 1-р сараас төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 6%-аар нэмэгдэж байгаа. Мөн Эрдэнэс Тавантолгойн ногдол ашгийн үлдэгдэл 200 орчим мянган төгрөг 2025 оны 1, 2-р сард тараагдах хүлээлттэй байна.



Эдийн засгийн өсөлт	Шинэчилсэн	2025
Голомт банк	2024 12-р сар	7.8%
Дэлхийн банк	2024 11-р сар	8.0%
АХБ	2024 9-р сар	7.2%
ОУВС	2024 10-р сар	9.5%
Монголбанк	2024 12-р сар	8.4%
<b>Дундаж</b>		<b>8.0%</b>

2025 оны хувьд мөн л инфляцыг барихад амаргүй жил болох ба 2024 оны дүр зураг ахин ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, төсвийн зардал тэр дундаа урсгал зардал үнэмлэхүй өссөн, мөн ногдол ашгийг тараалт үргэлжилж, дотоод идэвхжил нэмэгдэх хүлээлттэй байгаагийн сацуу 5-р сараас дулааны тариф нэмэгдэхтэй холбоотойгоор инфляц хөөрөгдөх эрсдэл өндөр байна. Мөн цаг агаарын нөхцөл байдал, зудаас шалтгаалсан малын хорогдлын тоо 2025 онд өндөр байх нь махны үнэ өсөх, улмаар инфляцыг өндөр түвшинд хүргэх төсөөлөлтэй байна. Тиймээс 2025 оны 4-р сараас инфляц хоёр оронтой тоонд хүрч өсөх эрсдэл ч байгааг эдийн засагч нар анхааруулж байна. (Ц.Батсүх, СЭЗИС, профессор)

Улмаар 2025 онд одоо байгаа 10%-ийн бодлогын хүү ахин буурах хүлээлт байхгүй ба Монголбанкнаас олон талт арга хэмжээ хэрэгжүүлж зээлийн өсөлтийг хязгаарлахыг зорьж байна. Тухайлбал 2025 оны 1-р сард төв банкны Мөнгөний бодлогын хороо дахин хуралдаж, төгрөг болон валютын заавал байлгах нөөцийн хэмжээг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 13% болон 18%-д хүргэлээ.

Ийнхүү олон улс болон дотоодын байгууллагуудын дундаж таамаглалаар 2025 оны эцэст гэнэтийн “шок”-ийн нөлөө бага байх тохиолдолд инфляц Монголбанкны зорилтот дээд интервалд буюу 8%-д хүрэх хүлээлттэй байгаа юм.

## Банкны салбар

2024 оны эдийн засгийн идэвхижлийг дагаад банкны салбарын идэвхжил, зээл олголт тасралтгүй өслөө. 2024 оны 12 сарын байдлаар банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 37 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.5%-аар өсжээ. Зээлийн өсөлт он гарснаас хойш сард дунджаар 30% өсөж, зээлийн үлдэгдэл жилийн дотор 9.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.


Үзүүлэлтүүд	Нэгж	2022	2023Н1	2023	2024Н1	2024	Өсөлт
<b>Нийт актив</b>	<b>тэрбум ₮</b>	<b>45,956</b>	<b>47,998</b>	<b>57,070</b>	<b>62,185</b>	<b>71,405</b>	<b>25.1%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>тэрбум ₮</b>	<b>22,008</b>	<b>25,355</b>	<b>27,152</b>	<b>33,259</b>	<b>36,781</b>	<b>35.5%</b>
Хугацаа хэтэрсэн зээл	тэрбум ₮	1,123	1,317	1,264	1,227	1,271	0.5%
Чанаргүй зээл	тэрбум ₮	2,019	2,207	2,039	1,950	1,867	-8.5%
Чанаргүй зээлийн харьцаа	%	9.2%	8.7%	7.5%	5.9%	5.1%	-32.4%
<b>Иргэдийн зээл, ₮</b>	<b>тэрбум ₮</b>	<b>11,492</b>	<b>13,748</b>	<b>15,306</b>	<b>19,385</b>	<b>21,855</b>	<b>42.8%</b>
<b>Иргэдийн зээл, \$</b>	<b>тэрбум ₮</b>	<b>63</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>67</b>	<b>101</b>	<b>44.5%</b>
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	269	295	264	331	485	83.9%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, \$	тэрбум ₮	1	0	2	2	2	26.9%
Чанаргүй зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	479	477	479	488	554	15.7%
Чанаргүй зээл, Иргэд, \$	тэрбум ₮	22	22	24	23	23	-4.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, ₮	%	4.2%	3.5%	3.1%	2.5%	2.5%	-19.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, \$	%	34.8%	31.3%	34.2%	34.8%	22.7%	-33.6%
<b>Байгууллагын зээл, ₮</b>	<b>тэрбум ₮</b>	<b>8,980</b>	<b>9,765</b>	<b>9,905</b>	<b>11,281</b>	<b>11,910</b>	<b>20.2%</b>
<b>Байгууллагын зээл, \$</b>	<b>тэрбум ₮</b>	<b>1,156</b>	<b>1,440</b>	<b>1,560</b>	<b>1,900</b>	<b>1,855</b>	<b>18.9%</b>
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	690	686	618	554	563	-8.9%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	163	334	379	338	220	-41.9%
Чанаргүй зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	1,358	1,548	1,363	1,283	1,160	-14.9%
Чанаргүй зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	151	151	163	147	121	-26.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, ₮	%	15.12%	15.86%	13.76%	11.37%	9.74%	-29.2%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, \$	%	13.09%	10.45%	10.43%	7.75%	6.50%	-37.7%
<b>Нийт харилцах хадгаламж</b>	<b>тэрбум ₮</b>	<b>27,599</b>	<b>29,288</b>	<b>34,907</b>	<b>37,800</b>	<b>39,563</b>	<b>13.3%</b>
Харилцах данс, ₮	тэрбум ₮	6,073	7,175	8,579	10,350	10,326	20.4%
Харилцах данс, \$	тэрбум ₮	4,855	3,409	5,216	4,195	3,645	-30.1%
Хадгаламж, ₮	тэрбум ₮	12,033	13,750	16,346	18,841	20,955	28.2%
Хадгаламж, \$	тэрбум ₮	4,638	4,954	4,766	4,415	4,637	-2.7%
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>тэрбум ₮</b>	<b>4,979</b>	<b>5,528</b>	<b>6,182</b>	<b>6,523</b>	<b>7,337</b>	<b>18.7%</b>
<b>Нийт пассив</b>	<b>тэрбум ₮</b>	<b>40,977</b>	<b>42,470</b>	<b>50,887</b>	<b>55,661</b>	<b>64,068</b>	<b>25.9%</b>

Эх сурвалж: Монголбанк

## Нийт актив ба зээл

## Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эцэст 43.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 15.2 хувиар буюу 5.7 их наядаар төгрөгөөр өслөө.



Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 12 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 43.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.7 их наяд төгрөгөөр өссөн ба эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж 4.9 (28.8%) их наяд төгрөгөөр, төгрөгийн харилцах 1.8 (19.7%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөө үзүүлээ.


Төгрөгийн хадгаламж оны эцэст 22.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 4.7 хувиар, өмнөх оноос 28.8 хувиар өссөн ба хадгаламжийн 86 хувийг иргэдийн хадгаламж, 14 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна. Харин валютын хадгаламж 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.9 хувь буюу 142.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2024 онд УИХ-ын ээлжит сонгууль болон улсын төсвийн тэлэлттэй холбогдуулан мөнгөний нийлүүлэлт өндөр байсан. Оны хагаст гэхэд жилийн өсөлт 31.9 хувьд хүрч эрчимжсэн билээ. Харин сүүлийн 4 сарын

хугацаанд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд алгуур саарч, 15.2 хувьд хүрсэн нь төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж гадаад цэвэр активын өсөлт буурсантай холбоотой байна. Гэсэн хэдий ч зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжиж, мөнгөний нийлүүлэлтийг өсгөж байгаа нь ханш сулрах, инфляцыг өсөх эрсдэлтэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бас нэгэн суваг бол гадаадын шууд хөрөнгө оруулалт байдаг. 2024 оны 11 сарын байдлаар манай улсад орж ирсэн нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.4 тэрбум ам доллар буюу ойролцоогоор 8.1 их наяд төгрөгт хүрсэн. Энэхүү үзүүлэлт нь өмнөх онтой харьцуулахад 60 хувиар өссөн дүн бөгөөд дотоодын банкнуудын гаргасан бонд, мега төслүүдийн анхан шатны хөрөнгө оруулалт орж ирж байгаатай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт ийнхүү өндөр түвшинд байна.


## Ханш, төлбөрийн тэнцэл



Ам.долларын сарын дундаж зах зээлийн ханш 2024 оны 12-р сард 3,418 төгрөгтэй тэнцэж байна. Ханшийн хэлбэлзэлд гадаад валютын албан нөөцийн хэмжээ чухал нөлөө үзүүлдэг бөгөөд онц эцэст ГВАН 5.5 тэрбум ам.долларт хүрсэн нь экспортын орлого, засгийн газраас хэрэгжүүлэх мега төслүүдтэй холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалтууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдал 8-р сарын байдлаар 186 сая ам.долларт хүрч, албан нөөцийг бууруулах эрсдэлтэй байсан ч сүүлийн 3 сарын хугацаанд санхүүгийн данс ашигтай гарснаар төлбөрийн тэнцэл 11 сарын байдлаар 38 сая ам.долларын ашигтай гарсан. Гадаад валютын албан нөөц өндөр байгаа нь ханшийг тогтвортой байлгахад чухал нөлөөтэй бөгөөд 2025 онд импортын өсөлт нэмэгдэж, урсгал дансны алдагдал өндөр байх тохиолдолд ханш сулрах эрсдэл хэвээр байна.

### Банкны салбарын зээл




2024 оны эдийн засгийн идэвхижлийг дагаад банкны салбарын идэвхжил, зээл олголт тасралтгүй өслөө. 2024 оны 12 сарын байдлаар банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 37 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.5%-аар өсжээ. Зээлийн өсөлт он гарснаас хойш сард дунджаар 30% өсөж, зээлийн үлдэгдэл жилийн дотор 9.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкны салбарын зээлийн өсөлт 2024 онд эрчимтэй өссөн нь төсвийн тэлэлттэй холбоотойгоор цалин, тэтгэврийг нэмэгдүүлж дотоод эрэлт нэмэгдсэнтэй холбоотой. 2024 оны 4 сард төрийн албан хаагчдын цалинг 40 хувь хүртэл нэмэгдүүлж, дундаж тэтгэврийг 100 мянган төгрөгөөр өсгөж, 826 мянган төгрөг болгосон. Эдгээр багц шийдвэрүүд нь өрхийн орлогыг нэмэгдүүлсэн ба дотоод хэрэглээг өдөөж хэрэглээний зээлийн өсөлтийг хурдацтай нэмэгдүүлсэн байна.

Мөн хугацаа хэтэрсэн, анхаарал хандуулах шаардлагатай зээлийн үлдэгдэл 12 сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж өмнөх оноос 0.5 хувиар өссөн ба нийт зээлийн 3.5 хувийг эзэлж байна. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 8.5 хувиар буурч 1.9 их наяд төгрөг болсон бөгөөд нийт зээлийн 5.1 хувийг бүрдүүллээ.

2025 оны 1-р сараас эхлэн дахин төрийн албан хаагчдын цалин болон тэтгэврийг инфляцтай уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсан. Тиймээс үүнтэй холбоотой инфляцын дарамт нэмэгдэх хандлагатай байгаа тул Монголбанкны шийдвэрээр бодлогын хүүг 10 хувьд хэвээр барих хэдий ч зээлийн хэт өсөлт болон санхүүгийн салбарын эрсдэлийг хязгаарлахын тулд банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 2 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргасан байна.




Нийт зээлийн үлдэгдлийн бүрэлдэхүүнд иргэдийн зээл 22 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 42.8 хувиар өссөн бол байгууллагын зээл 13.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 20.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт зээлийн 61 хувийг иргэдийн зээл, 36.5 хувийг байгууллагын зээл бүрдүүлжээ. Иргэдэд олгож буй хэрэглээний чиглэлийн зээлээс цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийн эрэлт өндөр байгаа бол малчдад олгож байгаа зээлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Иргэдийн зээлийн хувьд анхаарах шаардлагатай хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оноос 83.5 хувиар өсөж, 487 тэрбум төгрөгт хүрсэн бол чанаргүй зээлийн хэмжээ 577 тэрбум төгрөгт хүрч, 15 хувиар нэмэгджээ. Ийнхүү иргэдийн орлого нэмэгдэхийн хэрээр хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж байгаа ч нөгөө талд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Харин байгууллагын зээлийн чанаргүй зээлийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнө жилээс 16 хувиар буурсан үзүүлэлт юм.

### Иргэдэд олгосон шинэ зээл /ангиллаар/

Иргэдэд олгож буй хэрэглээний зээлд цалин, тэтгэврийн зээл нийт дүнгээр 10.3 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт нь 45 хувьтай гарлаа.




2024 оны 12-р сарын байдлаар иргэдэд олгосон шинэ хэрэглээний зээлийн өсөлт өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 30 хувиар өсөж, 20.5 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь эргэн төлөлтийн дүнг тооцолгүй жилийн хугацаанд олгосон нийт зээлийн дүнг илэрхийлнэ.

Зээлийн бүрэлдэхүүнийг дэлгэрэнгүй авч үзвэл, цалин болон тэтгэврийн зээлийн өсөлт 45 хувиар нэмэгдэж, 10.3 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь 2024 онд тэтгэвэр болон цалингийн хэмжээг тус тус нэмэгдүүлснээр иргэдийн худалдан авах чадвар сайжирсантай холбоотой юм. Мөн хадгаламж барьцаалсан зээл 29 хувиар нэмэгдэж, нийт дүнгээр 7.8 их наяд төгрөгт хүрсэн нь 2022 онтой харьцуулахад даруй 1.5 дахин нэмэгдсэн үзүүлэлт болжээ.

Хөдөө, аж ахуйн салбарт 2024 онд малын хорогдлоос шалтгаалсан гарцын бууралт бий болж, үүнийгээ дагаад зээлийн өсөлт 38 хувиар буурч, 768 тэрбум төгрөгт хүрлээ. Харин нөгөө талд автомашин ба өрхийн хэрэглээний зээл нийт зээлийн хувьд бага дүн эзэлдэг хэдий ч өмнөх онтой харьцуулахад 45 хувиар өсөж, нийт дүнгээр 690 тэрбум төгрөгт хүрсэн байна. Дотоод эрэлт импортын өсөлтийг нэмэгдүүлж байгаа нь ирэх онд автомашин ба өрхийн хэрэглээний зээлийг эрчимжүүлэх магадлалтай.

## Банкуудын жигнэсэн дундаж хүү




Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр бодлогын хүүгийн түвшин 2024 онд 3 удаа тус бүрд 1 нэгж хувиар буурч, оны эхэнд 13 хувьтай байснаас 10 хувь болж буурсан. Хамгийн сүүлд 2025 оны 1 сарын 14-ний мэдэгдлээр бодлогын хүү 10 хувьд хэвээр хадгалагдах хэдий ч банкуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, харгалзан 13 хувь болон 18 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ. Ийнхүү заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлж буй нь банкны салбарын зээлийн өсөлт өндөр түвшинд байгаатай холбоотой ба хэрэглээний импорт, дотоод эрэлтийг өдөөж, цаашлаад санхүүгийн салбарт эрсдэл үүсэхээс сэргийлж байгааг тодотгожээ.

Дээрх шалтгаанаас үндэслэн хадгаламж болон зээлийн хүү бодлогын хүүг дагаж буурах орон зай бага байсан ба шинээр олгосон төгрөгийн зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү 2024 оны эцэст 5 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өсжээ. Үүнд, төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны эцсээс 0.29 хувиар өсөж, 11.9 хувьтай байгаа бол зээлийн хүү 0.20 хувиар өсөж, 16.9 хувьтай байна. Харин валютын зээл болон хадгаламжийн хүү аль аль нь 2023 оны эцсээс буурч, зөрүү нь 5.5 хувьтай гарчээ. Валютын хадгаламжийн хүү өмнөх оны эцсээс 0.1 хувиар буурч, 4.1 хувьд хүрсэн бол зээлийн хүү 0.9 хувиар буурч, 9.6 хувьтай байна.

### Байгууллагад олгосон шинэ зээл /салбараар/

Зээлийн өсөлтийг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл уул уурхай, барилгын салбарын өсөлт хамгийн өндөр хувьтай байна.




Хувийн байгууллагад шинээр олгосон нийт зээлийн үлдэгдэл 23.9 их наяд төгрөг байгаа бөгөөд үүний 53 хувийг худалдааны салбарын зээл, 13 хувийг уул уурхайн салбар, 10 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар тус тус эзэлж байна.

Уул уурхайн салбарын зээлийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89 хувиар өсөж, 3.2 их наяд төгрөгт хүрсэн бол үйлчилгээний салбар 21 хувиар өсөж, 2.9 их наяд төгрөгт хүрчээ. Харин өнгөрсөн жил 58 хувийн өсөлттэй байсан боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өсөлт 2024 онд 4 хувьтай гарч, 2.4 их наяд төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Худалдааны салбар нийт зээлийн дүнгээрээ хамгийн их хувийг эзэлж байгаа

бөгөөд жилийн өсөлт нь 33 хувьтай гарч, 12.6 их наядад хүрсэн бол барилгын салбар 42 хувиар өсөж 2.4 их наядтай гарлаа.

Зээлийн өсөлтийн хувийг харьцуулан авч үзвэл 2024 онд зудын хүнд нөхцөл байдалтай холбоотойгоор малын хорогдол нэмэгдэж хөдөө аж ахуйн салбар уналттай байсан тул боловсруулах үйлдвэрлэлийн зээл буурсан байна. Харин цалин, тэтгэврийн нэмэгдлийн улмаас дотоод эрэлт нэмэгдэж, хэрэглээний импорт өсөлттэй байсан нь худалдаа болон үйлчилгээний зээлийн өсөлтийг нэмэгдүүлэхэд голлон нөлөө үзүүлжээ.

### Чанаргүй зээлийн өөрчлөлтийн хувь



2024 оны байдлаар нийт банкны салбарын зээлийн 5.1 хувь буюу 1.9 их наяд төгрөгийг чанаргүй зээл, 5.9 хувь буюу 1.2 их наяд төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх жилтэй харьцуулахад 8.5 хувиар буурсан нь эдийн засгийн салбаруудын чанаргүй зээлүүд буурсантай холбоотой билээ. Тухайлбал, худалдаа, үйлчилгээний салбарын зээл тус тус 16 болон 18 хувиар буурсан бол уул уурхайн салбарын чанаргүй зээл 22 хувиар буурчээ. Ийнхүү буурахад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт түүхэн хугацаанд хамгийн өндөр байж, 2024 онд нийт 79.5 сая тонн нүүрс экспортлон эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нь голлон нөлөө үзүүлжээ.

2024 онд хэрэглээний зээл, тэр дундаа цалин болон тэтгэврийн зээл 10.3 их наяд төгрөгт хүрч, энэ нь 2022 онтой харьцуулахад 2.6 дахин өссөн үзүүлэлт юм. Үүнийгээ дагаад хэрэглээний чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны эцсээс 9.8 хувиар өсөж, 2.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

## Голомт банкны санхүүгийн үр дүн

Голомт банк 2024 оны 5-р сард анх удаа олон улсын зах зээл дээрээс гурван жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай босгосон ба 12-р сард дахин 100 сая ам.долларын бонд нэмж гаргаснаар арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкнуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээв.

Банкны салбарт нийт хөрөнгийн хэмжээгээр эзлэх хувь

# 21.6%

Нийт зээлийн хэмжээгээр эзлэх хувь

# 20.1%

Харилцагчийн эх үүсвэрээр эзлэх хувь

# 20.1%

### 2024 оны нөхцөл байдал


- Монгол Улсын эдийн засгийн өсөлт худалдаа, үйлчилгээний салбарын идэвхижлийн нөлөөгөөр 2024 онд 4.9 хувьтай байна.
- Гадаад валютын албан нөөц 5.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өссөнөөр төгрөгийн ам.долларт харьцах ханш 3,420 төгрөгт хүрэв.
- 2024 онд Монголбанк бодлогын хүүг 3 хувиар бууруулж, 10 хувьд, банкнуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 11 хувьд, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулан 16 хувь тус тус хүргэхээр шийдвэрлэв.
- Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B2", төлвийг "эерэг" болгон ахиулав.

### 2024 оны санхүүгийн гол амжилтууд

- Банкны нийт актив өмнөх оноос 4.0 их наяд төгрөгөөр буюу 34.1 хувиар өсөж, 15.6 их наяд төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн хэмжээ 54.3 хувиар өсөж, 7.5 их наяд төгрөгт, харилцагчдын эх үүсвэр 16.7 хувиар өсөж, 9.4 их наяд төгрөгт хүрэв.
- Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцааг 2 хувиар бууруулж, 3.0 хувьд хүргэсэн нь банкны системийн чанаргүй зээлийн хувиас доогуур буюу сайн үзүүлэлттэй байна.
- 2024 оны татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 100.2 хувиар өсөж, 418.8 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн өөрийн хөрөнгийн өгөөж 33.6% хувьд хүрч өслөө.


## Санхүүгийн үр дүн

Нийт актив өмнөх оны эцэстэй харьцуулахад 34.1 хувиар өсөж, 15.6 их наяд төгрөгт, харилцагчийн эх үүсвэр 16.7 хувиар өсөж, 9.4 их наяд төгрөгт хүрээд байна.




Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай идэвхтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, шинээр 89 сая ам.долларын зээл татахын зэрэгцээ олон улсын зах зээлээс 400 сая ам.долларын бондын эх үүсвэр татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа амжилттай тэллээ.

2024 онд банкны өөрийн хөрөнгө 33.5 хувиар өсөж, 1,430 тэрбум төгрөгт хүрлээ.




2024 онд банк цэвэр зээлийн багцаа 56.0 хувиар тэлэхийн зэрэгцээ активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, чанаргүй зээлийн харьцааг 3 хувьд хүргэн сайжрууллаа. Хөрөнгө оруулалтын багц 26.3 хувиар өсөж, 3.0 их наяд төгрөгт хүрлээ.



## Ашигт ажиллагаа

Голомт банк 2024 онд 418.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үйл ажиллагааны ашиг 496.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 95.9 хувиар өслөө. Хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.4 хувиар өсөж 1.2 их наяд төгрөгт, цэвэр хүүгийн орлого 18.3 хувиар өсөж, 564.6 тэрбум төгрөгт тус тус хүрэв. Бизнесийн өсөлт, зах зээлийн орчны нөлөөгөөр цэвэр хүүгийн бус орлого 202.8 тэрбум төгрөгт хүрлээ.




Банкны үйл ажиллагааны зардал 35.2 хувиар өсөж, 270.7 тэрбум төгрөгт хүрсэн бол сан үнэлгээний зардлын хувьд 48 тэрбум төгрөгийн сан буцаасны цэвэр орлоготой гарсан нь ашгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээд байна. Зардал, орлогын харьцаа 8.8 хувиар буурч, 35.3 хувьд хүрч сайжирлаа.



## Зохистой харьцаа

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.


### Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



—○— ӨХ-ийн хүрэлцээ >12%

—○— 1-р зэрэглэлийн ӨХ-ийн хүрэлцээ >9% /нөөц +4%/

### Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



—○— Төлбөрийн түргэн гүйцэтгэх харьцаа >25%

### Голомт банкны 5 жилийн санхүүгийн үр дүн (1/2)

Санхүүгийн үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
<b>Балансын үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)</b>					
Нийт актив	7,278	7,994	8,985	11,628	15,597
Харилцах, хадгаламж	5,286	5,464	5,743	8,037	9,377
Бондын эх үүсвэр					1,370
Бусад эх үүсвэр	1,237	1,748	2,180	2,254	3,238
Цэвэр зээл	3,031	3,339	3,698	4,712	7,351
Нийт өөрийн хөрөнгө	632	659	862	1,071	1,430
<b>Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)</b>					
Хүүгийн орлого	570	555	610	841	1,163
Хүүгийн зардал	(366)	(273)	(224)	(363)	(599)
Цэвэр хүүгийн орлого	204	282	386	477	565
Цэвэр хүүгийн бус орлого	83	49	142	(24)	203
Үйл ажиллагааны орлого	287	331	527	454	767
Үйл ажиллагааны зардал	(121)	(137)	(175)	(200)	(271)
Үйл ажиллагааны ашиг	166	193	352	254	497
Сан, үнэлгээний зардал	(143)	(141)	(158)	12	48
Татварын өмнөх ашиг	22	53	194	266	545
Татварын зардал	(12)	(27)	(77)	(57)	(126)
Татварын дараах ашиг	10	26	117	209	419

## Голомт банкны 5 жилийн санхүүгийн үр дүн (2/2)

Санхүүгийн үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023	2024
<b>Санхүүгийн бүтцийн харьцаанууд</b>					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	72.6%	68.3%	63.9%	69.1%	60.1%
Бусад эх үүсвэр / Нийт актив (%)	17.0%	21.9%	24.3%	19.4%	20.8%
Цэвэр зээл / Нийт актив (%)	41.7%	41.8%	41.2%	40.5%	47.1%
Чанаргүй зээлийн харьцаа (%)*	8.4%	7.6%	6.9%	5.0%	3.0%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ (%)*	71.9%	72.5%	96.4%	106.2%	120.6%
<b>Ашигт ажиллагааны харьцаанууд</b>					
Дундаж активын өгөөж (%)	0.2%	0.3%	1.4%	2.2%	3.5%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	2.5%	5.1%	19.5%	24.1%	33.6%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.0%	4.6%	5.9%	6.5%	6.2%
Зардал, орлогын харьцаа (%)	42.2%	41.5%	33.3%	44.1%	35.3%
<b>Зохистой харьцааны үзүүлэлтүүд*</b>					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12%	14.2%	13.3%	17.6%	15.9%	14.7%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ >9% (нөөц +4%)	13.7%	13.0%	17.6%	15.9%	14.7%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валют <+/-30%	26.2%	15.1%	10.8%	8.0%	6.7%
Нэгж гадаад валют <+/-15%	13.2%	12.0%	8.0%	1.0%	2.1%
Том зээлдэгчийн харьцаа <20%	18.7%	16.1%	14.7%	12.4%	12.9%
Холбоотой этгээдийн харьцаа <5%	4.6%	1.1%	3.9%	4.0%	2.3%
Холбоотой этгээдийн харьцаа - Нийт <20%	16.3%	2.8%	8.6%	13.2%	6.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа >25%	40.2%	41.3%	36.3%	38.3%	35.4%

\* Монголбанкны журмын дагуу

# Бизнесийн ТОЙМ

Өөрийн хөрөнгийн  
хэмжээ

# 1.4

их наяд төгрөг



Голомт банк өнгөрсөн хугацаанд корпорэйт суурьтай буюу байгууллагын зах зээлд төвлөрөн ажиллаж байсан. Харин “Нээлттэй банк” стратегийг хэрэгжүүлж эхэлснээр банкны зээлийн багцыг сегментээр нь задалбал, өдгөө байгууллагын зах зээлд 33%, иргэдийн зах зээлд 44%, жижиг дунд бизнесийн зах зээлд 23% гэсэн харьцаатайгаар үйл ажиллагаагаа хүртээмжтэй явуулж байна.

## Байгууллагын банк

Байгууллагын зээлээр  
зах зээлд эзлэх хувь (+SME)

**23.7%**

Байгууллагын эх үүсвэрээр  
зах зээлд эзлэх хувь (+SME)

**25.4%**

Монгол Улсын хөгжлийн голомт байх эрхэм зорилгынхоо хүрээнд эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон, стратегийн ач холбогдол бүхий томоохон аж ахуйн нэгжүүд, эдийн засгийг бүрдүүлэгч бизнесийн салбарын гол төлөөлөгч байгууллагуудад санхүүжилт олгож, тэдгээрийн шаардлагад нийцсэн тусгайлсан үйлчилгээг хүргэх замаар эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулан хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлэн ажиллаа.

### Онцлох үйл явдал

- Харилцагчийн сэтгэл ханамж 91%-д хүрч, “Best Corporate Banking” амжилтаа бататгав.
- Лизингийн төвийг шинээр байгуулж, 123 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийн багцыг бүрдүүлэв.
- Монгол Улсын хэмжээний нийт биет алт тушаалтын 44.9%-ийг дангаар бүрдүүлэн ажиллав.
- Ногоон, эрчим хүчний хэмнэлттэй төслүүдэд зориулан 72 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олголоо.

## Бүтээгдэхүүн үйлчилгээ

Байгууллагын банк нь корпорэйт харилцагчид 30 гаруй төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог бөгөөд төлбөр тооцоог дижиталчлах зорилгоор интернэт банкны үйлчилгээ, орлого, зарлагын гүйлгээг автоматжуулах “Corporate Gateway”, ажилтнуудын цалинг интернэт банкаар олгох “payroll”, төлбөр тооцоо хийх “paybill”, нэхэмжлэх үүсгэх “billing” зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг түлхүү санал болгож байна.

### Дижиталчлал

Нийт корпорэйт харилцагчдын 95% нь интернэт банкны үйлчилгээ ашигладаг бөгөөд тэдгээрийн 24% нь “Corporate Gateway”, 19% нь и-коммерс, 17% нь payroll, 11% нь SocialPay үйлчилгээг ашигладаг боллоо.

Интернэт банк

**95%**

Корпорэйт гэйтвэй

**24%**

И-коммерс

**19%**

Payroll

**17%**

SocialPay

**11%**

## Хамтын ажиллагаа

- “Байгууллагын интернет банкны шинэ боломжууд болон мэдээллийн аюулгүй байдлын сургалт”-ын хөтөлбөрийг боловсруулж, Голомт банкны Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэстэй хамтран 15 групп компанийн санхүү, мэдээллийн технологийн 200 орчим ажилтанд зориулан 30 цагийн сургалт явуулав. Сургалтын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий харилцагч байгууллагуудаа фишинг халдлагын эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэмжлэг үзүүлсэн үр дүнтэй хөтөлбөр байв.
- Корпорэйт байгууллагын ажилтнуудад зориулж, 5-р сараас эхлэн хоёр сарын хугацаанд “Хувь хүний санхүү” сэдвээр 822 хүн цагийн сургалтыг зохион байгуулав.
- Шинэ технологи, шинэ боломжуудтай танилцах, туршлага судлах зорилгоор БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагддаг 136 дахь удаагийн “Canton Fair” арга хэмжээнд ажилтнуудаа хамруулав.

## Санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр

### Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар

- Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудад хөнгөлөлттэй зээл олгосон. Ингэснээр,
  - Импортыг орлож, дотоодын зах зээлийн 50%-ийг хангах боломжтой өндөгний үйлдвэр ашиглалтад оров.
  - Хоол үйлдвэрлэлийн зах зээлийг 2.7 дахин нэмэгдүүлэв. Монгол хөрсөнд тариалсан лууван, хүрэн манжингийн 100 хувь цэвэр жүүсний үйлдвэрлэлийг дэмжив.
  - Импортын чихрийн үйлдвэрлэлийн 15%, какао, молоконы үйлдвэрлэлийг 20% орлох дотоодын үйлдвэр ашиглалтад оров.
- Томоохон сүлжээ дэлгүүрүүдтэй хамтран ажилласнаар шинээр 350 ажлын байр нэмэгдэв.
- Ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдийн түүхий эдийн зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тэднийг эргэлтийн хөрөнгөөр дэмжих зорилготой Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт олгов. Ингэснээр дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, түүхий ноолуурын үнийн хэлбэлзлийг бууруулах боломж бүрдэж байна.

### Шатахууны салбар

- МУ-ын хувьд стратегийн ач холбогдол бүхий шатахууны импортын тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, санхүүжилтийн 48%-ийг, нийт төлбөр тооцооны 90%-ийг дангаар хийж гүйцэтгэж байна.

### Тээвэр, ложистикийн салбар

- Монголын хамгийн анхны 3PL (third-party logistics) агуулах төслийг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгов. 3PL агуулах нь нийлүүлэгчээс хэрэглэгчид бараа бүтээгдэхүүнийг хүргэхийн тулд хүлээн авах, хадгалах, савлах, тээвэрлэх, терминалын үйл ажиллагаа, гаалийн зуучлал, нийлүүлэлтийн сүлжээний менежмент зэрэг үйлчилгээг цогцоор шийдвэрлэснээрээ онцлогтой. ОУ-ын стандарт бүхий уг агуулах нь зардал хэмнэх, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, supply chain-ийг дэмжих олон талын ач холбогдолтой юм.

### Уул уурхай, дэд бүтцийн салбар

- Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9%-аар өссөний 1.7%-ийг уул уурхайн салбар бүрдүүлжээ. Тус салбарын тэр дундаа алтны үндсэн болон шороон орд, төмрийн хүдэр, зэс, молибден, нүүрсний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч томоохон аж ахуйн нэгжүүд тэдгээрийн ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч талуудад шаардлагатай санхүүжилтийг Голомт банк олгож ажилласан. Салбарын зээлийн 25%-ийг Голомт банк дангаараа бүрдүүлж байна.



### Эрчим хүчний салбар

- Стратегийн ач холбогдол бүхий эрчим хүч, дэд бүтцийн салбарын оролцогч талууд болох эрчим хүчийг үйлдвэрлэх, түгээх, дамжуулах төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласнаар Монгол Улсын эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг 9%-аар нэмэгдүүлж, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахад хувь нэмрээ оруулан ажиллалаа.

### Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд

Жилд 7000 тн хар тугалган батареиг байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи ашиглан дахин боловсруулах “Дэлхийн жишиг үйлдвэр”-ийг барьж байгуулахад санхүүжилт олгож, хамтран ажиллалаа. Ингэснээр Монгол Улсад хаягдаж буй нийт хаягдал хар тугалгын батареиг 100 хувь боловсруулах боломж бүрдэв.



Статистик мэдээллээр Монгол Улсын нийт нас баралтын 14.3%-ийг бохирдол, 14 хар тугалганы бохирдол эзэлдэг. Мөн бага насны хүүхдүүдийн цусан дахь хар тугалганы хэмжээ нь ДЭМБ-аас батлагдсан зөвлөх хэмжээнээс 5-6 дахин их түвшинд хүрсэн нь судалгаагаар тогтоогджээ. Иймд төслийн хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 3: Эрүүл мэндийг дэмжих зорилтыг хэрэгжүүлэхэд чухал алхам төдийгүй хар тугалганы хор нөлөөг бууруулахад чиглэсэн стратегийн ач холбогдолтой.

## Лизингийн төв

Голомт Лизингийн төвийг 2024 онд байгуулж, албан ёсны үйл ажиллагааг эхлүүллээ. Тус төв нь лизинг буюу санхүүгийн түрээсийн бүтээгдэхүүнээр шинэ автомашин, хүнд даацын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн албан ёсны дилер эрхтэй нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2024 оны 12-р сарын байдлаар нийт 22 байгууллагатай гэрээ байгуулж, харилцагч нартаа санхүүгийн түрээсийн үйлчилгээг шуурхай үзүүлэн, тус зах зээл дээр хүчтэй тоглогч болохоор зорьж байна.



## Арга хэмжээ



# 500+

байгууллага

### Financial Manager's Convention 2024

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч аж ахуй нэгж, бизнесийн салбарын шилдэг санхүүчдэд зориулан “Bridging to the Global Market” уриан дор FMC 2024 арга хэмжээг тасралтгүй 6 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээний гол зорилго нь тухайн жилийн эдийн засаг, санхүүгийн үр дүн, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг дүгнэж, ирж буй жилүүдийн эдийн засгийн төлөв байдал хийгээд түүнд хэрхэн бэлэн байх талаар хэлэлцэж, бизнес эрхлэгчдэд харилцан туршлага хуваалцах боломжийг олгоход оршдог. Энэ жилийн тухайд арга хэмжээг үндсэн болон салбар хуралдаан хэлбэрээр зохион байгуулж, Голомт банк олон улсын зах зээлд гаргасан бондын талаар туршлагаасаа хуваалцахын зэрэгцээ “Макро эдийн засгийн нөхцөл байдал”, “Generative AI буюу хиймэл оюун ухааныг ашиглан байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх нь” зэрэг 14 илтгэл, судалгаа танилцуулж, илүү өргөн цар хүрээг хамарлаа. Мөн шинээр арга хэмжээний цахим хуудсыг хөгжүүлж, 7 өөр агуулгын хүрээнд гарын авлага, судалгаа байршуулснаараа харилцагчдын сайшаалыг хүртсэн юм.



# 300+

байгууллага

### Embassy Friendly Football Tournament 2024

Голомт банк болон Гадаад харилцааны яамнаас жил бүр зохион байгуулдаг Монгол Улс дахь Элчин сайдын яамд хоорондын хөлбөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг 12 дахь жилдээ боллоо. Дипломат төлөөлөгч, албан тушаалтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, найрсаг харилцааг бэхжүүлэх зорилготой энэхүү тэмцээнд Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, консулын газрууд болон олон улсын байгууллагуудаас бүрдсэн 12 багийн 300 гаруй тамирчин өрсөлдөж, аваргуудаа шалгаруулсан юм.

АЛТНЫ  
ФОРУМ | 20  
24

360+

байгууллага



#### Gold Forum 2024

Хариуцлагатай уул уурхайг дэмжих зорилгоор Монгол Улсын алтны салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд зориулан “Алтны форум”-ыг 5 дахь жилдээ зохион байгууллаа. Форумд алт олборлогч топ аж ахуйн нэгж, уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагууд оролцож, алтны зах зээлийн орчинд гарсан өөрчлөлт, ирээдүйн төлөвийн талаар хэлэлцлээ. Тухайлбал, дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал, уул уурхайн салбар дахь арилжааны банкуудын оролцоо, алт, газрын тосны газрын чиг хандлага гэх мэт алтны салбарт оролцогчдын үйл ажиллагаанд шаардлагатай судалгаа, мэдээллийг багтаасан илтгэлүүдийг хүргэлээ.

Голомт банк “Алтны форум”-ын үеэр нийгмийн хариуцлагын хүрээнд хандивын үйл ажиллагааг өрнүүлж, цугларсан мөнгийг хүүхэд, багачуудын ирээдүйд зориулан хандивладаг уламжлал тогтоод 2 жил болж байна. Энэ удаагийн арга хэмжээгээр 999 сорьцтой, 1 унц жинтэй цэвэр алтан медалионуудыг шинээр гаргасан бөгөөд “Алтны форум” арга хэмжээний үеэр дуудлага худалдаанд оруулж, 95 сая төгрөг бүрдүүлсэн бөгөөд нийт орлогыг зүрхний төрөлхийн гажигтай хүүхэд, багачуудыг эх орондоо үнэ төлбөргүй эмчлэх зорилготой “Зүрх мартахагүй” төсөл болон монгол гэрт суурилсан хүүхэд хөгжлийн тоглоомын төвийг байгуулах, ялангуяа гэр хорооллын бүсэд тоглох орчныг бий болгох, хүүхдүүдийг тоглоомоор дамжуулан хөгжүүлэх зорилготой “Монгол гэрт суурилсан хүүхэд хөгжлийн тоглоомын төв” төсөлд тус тус хандивлалаа.

MINEPRO 2024  
УУЛ УУРХАЙН ҮЗЭСГЭЛЭН · ЧУУЛГАН



#### Mining week & MinePro 2024

Эрдэс баялаг, уул уурхайн салбарын хамгийн том чуулга уулзалт “Mining Week & MinePro-2024” арга хэмжээнд Голомт банк “Diamond Sponsor”-оор хамтран ажиллалаа. 2022 оноос хойш 3 дахь жилдээ зохион байгуулагдаж буй уг арга хэмжээний үеэр уул уурхайн салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид бодлогын асуудлыг хамтдаа хэлэлцэж, уул уурхайн чиглэлээр ажилладаг компаниуд өөрсдийн үйл ажиллагааны талаар танилцуулсан юм. Голомт банкны тухайд арга хэмжээний үеэр уул уурхайн салбарт чиглэсэн банкны бүтээгдэхүүн, мэргэжлийн банкируудын зөвлөгөөг багтаасан “Tailor made” санхүүгийн үйлчилгээгээ танилцуулж, бизнес эрхлэгчдэд хамгийн таатай, уян хатан нөхцөлтэй боломжуудыг санал болгосон. Мөн “Уул уурхайг санхүүжүүлэх нь” хуралдаанд “Ханган нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн боломжууд” сэдвээр илтгэл тавьж, “Уул уурхайн санхүүжилтийн олон улсын боломж болон динамик” сэдэвт хэлэлцүүлэгт арилжааны банкуудаа төлөөлөн панелистаар оролцлоо.

## Жижиг, дунд бизнесийн банк

Жижиг, дунд бизнесийн зээлийн багц өмнөх онтой харьцуулахад

↑ **40%**

Жижиг, дунд байгууллагын эх үүсвэр өмнөх онтой харьцуулахад

↑ **20%**

Голомт банк Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон жижиг, дунд бизнесүүдээ дэмжин ажилласаар ирсэн. Тэр дундаа бизнес эрхлэгчдийн 37 хувийг, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 68 хувийг эзэлдэг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээ санхүүгийн хувьд дэмжин тэдэнд тохирсон бизнесийн орчин, бодит дэмжлэгийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээгээ тасралтгүй хүргэж байна.

### Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан зээл

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь зориулсан зээлийн багц 9 дахин өсөв.

### Бүтээгдэхүүн, үйлчилгээ

#### Дижитал ПОС-ын орлого барьцаалсан зээл

Бизнес эрхлэгчдэд зориулсан ПОС-ын орлого барьцаалсан зээлийн сайжруулалтыг хийж, зээлийн багцаа амжилттай өсгөлөө. Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь Голомт банкны энгийн болон EasyPay-ийн ПОС төхөөрөмжийг ашиглан борлуулалтын орлогоо хүлээн авдаг харилцагч нарт зориулагдсан онлайн зээлийн бүтээгдэхүүн юм.



#### QR Pay мерчантын дижитал зээл

QR Pay мерчантуудад зориулсан дижитал зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүллээ. Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь Голомт банкны харилцах дансаар QR Pay орлогоо хүлээн авдаг харилцагч нарт зориулсан онлайн зээлийн бүтээгдэхүүн юм.

## Хамтын ажиллагаа



## Жижиг, дунд бизнесийн 360° үнэлгээ

Жижиг, дунд бизнесийн үзүүлэх нөлөө, бизнес эрхлэгчдийн оролцоог нарийн тодорхойлох, тэдэнд чиглэсэн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөтөлбөрүүдийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагаандаа “Жижиг, дунд бизнесийн 360° үнэлгээ”-г хийлгэхээр Олон Улсын Санхүүгийн Корпорацтай хамтран ажиллах гэрээг байгуулав. Ингэснээр Олон Улсын Санхүүгийн Корпорацын мэргэшсэн зөвлөх баг Голомт банканд ажиллаж, олон улсын үнэлгээг газар дээр нь хийж, зөвлөх үйлчилгээг үзүүлэх юм.

## MENTORSHIP PROGRAM



## “Mentorship” хөтөлбөр

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг амжилттай өргөжүүлж, дараагийн шатанд гаргахад нь чадавхжуулах зорилготой “Mentorship” хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

Энэ удаагийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй харилцагчийн тоо 2023 онтой харьцуулахад 10 дахин өссөн бөгөөд танхимын болон тусгайлсан үйлчилгээ авах 62 харилцагчийг сонгож, зөвлөх үйлчилгээ, чиглүүлэх сургалтуудыг зохион байгуулав.

Хөтөлбөрийн явцад оролцогчдын борлуулалтын орлого 20 хувиар өсөж, салбар, сүлжээ дэлгүүрүүдээ нээж, үйл ажиллагаагаа тэлснээс гадна шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн стратеги төлөвлөгөө болон процесс зураглалаа сайжруулж, баг, хамт олноороо нэг зорилготой, нэгдсэн ойлголттой болж амжилттай үр дүнд хүрээд байна.



## “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн зээлийн санхүүжилт

“Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-ийн санхүүжилтийн гэрээнд Сангийн яам, ХХААХҮЯ, Монголбанк болон Голомт банк зэрэг арилжааны 10 банк 2024 оны 12-р сарын 26-нд гарын үсэг зурлаа. Ингэснээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг албан ёсоор эхлүүлэв.




#### Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжсэн худалдан авалтын бодлого

Голомт банк бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжиж, тэдний зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо “Эмэгтэй бизнесийг дэмжсэн худалдан авалтын бодлого”-ыг боловсруулан ажиллаж байна. 2024 онд Голомт банкны найдвартай худалдан авагч, ханган нийлүүлэгчдээс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн эзлэх худалдан авалтын дүн 2023 онтой харьцуулахад 68 хувиар өсжээ.



#### “Women Owned” тохирлын тэмдэг

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд таниулах, аливаа хөнгөлөлт урамшуулал, сургалт хөгжлийн хөтөлбөрт хамруулах, бизнес эрхлэгч эмэгтэй мөн гэдгийг нь баталгаажуулах “Women Owned” тохирлын тэмдгийг 50 байгууллагад олгосноос 13 байгууллага нь өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлж, шошгондоо байршуулаад байна.



#### [www.womenowned.mn](http://www.womenowned.mn)

“Women Owned” тохирлын тэмдэг хэрэглэгч байгууллагууд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нэгдсэн сүлжээг бий болгож, тэдний хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд тохирлын тэмдгийн талаар цогц мэдээлэл бүхий [www.womenowned.mn](http://www.womenowned.mn) албан ёсны цахим хуудсыг ашиглалтад орууллаа.



#### **Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих цогц хөтөлбөр**

“Women Owned” тохирлын тэмдэг хэрэглэгч байгууллагууд, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжиж, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Голомт банк, МҮХАҮТ, Скай хайпермаркет компани санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд Скай хайпермаркет компани буюу “Имарт” сүлжээ дэлгүүрээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэдэг “Women owned” тохирлын тэмдэгт бүхий бизнес эрхлэгчдийг дэмжих хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх юм.

## Арга хэмжээ



### World Women Forum

Дэлхийн 45 орны 800 гаруй зочин, төлөөлөгч оролцсон “Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт” 2024 оны 8-р сарын 22, 23-нд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, дэлхий дахинд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг, оролцооны тухай өргөн цар хүрээтэй яриа өрнүүлж, харилцан туршлага солилцох энэхүү арга хэмжээнд Голомт банк хамтран ажиллаж, “Women Owned” тохирлын тэмдгээ танилцуулав. Мөн чуулга уулзалтын үеэр “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж” салбар хэлэлцүүлэгт оролцож, дэвшүүлсэн асуудлын хүрээнд оновчтой шийдлийг хэлэлцлээ.

### She trades summit 2024

Олон улсын бизнесийн зах зээлд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих, дэлхийн худалдааны өсөлт, тогтвортой байдал болон зах зээлд оруулах эмэгтэйчүүдийн хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой “She trades summit 2024” арга хэмжээнд Голомт банк оролцлоо. Дэлхийн 60 орны 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг дэмжигч томоохон компани, корпорац, Засгийн газрын төлөөллүүд оролцсон уг арга хэмжээнд Голомт банкнаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон “Women Owned” тохирлын тэмдгээ танилцуулсан юм.

### She Leads 2024

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон “Women Owned” тохирлын тэмдэг хэрэглэгч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг нь сурталчлах зорилготой “She Leads 2024” арга хэмжээг 12-р сарын 5-нд зохион байгууллаа.





# 450+

байгууллага

## Business conference 2024

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч 450 гаруй аж, ахуйн нэгжийн удирдлагуудад зориулсан “Business conference” арга хэмжээг зохион байгууллаа. “Bridging to the global market” уриан дор хуран чуулсан арга хэмжээний үеэр олон улсын зах зээлд гарах боломжийг хамтдаа эрэлхийлэхийг зорьсон. Мөн дэлхийн эдийн засгийн төлөв байдал, бизнесийн салбарын хөгжлийн чиг хандлага, тогтвортой санхүүжилт, эдийн засгийн чиглэлээр сонирхолтой судалгааны үр дүнг онцлон мэдээлэл солилцож, үр дүнтэй арга хэмжээ боллоо.



## Digital SME

2 0 2 4

## Digital SME 2024

Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт дижитал технологийг нэвтрүүлэх, шинэлэг шийдэл бүхий инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг эрэлхийлэх “Digital SME 2024” арга хэмжээг “Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” болон Германы ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих” төсөлтэй хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 150 гаруй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид оролцлоо.

## Иргэдийн банк

Иргэдээс татан төвлөрүүлсэн эх үүсвэр

↑ **27%**

Иргэдийн зээлийн багц

↑ **49%**

Иргэдийн эх үүсвэрээр зах зээлд эзлэх хувь

**16.1%**

Иргэдийн зээлийн зах зээлд эзлэх хувь

**17.7%**

Орон сууцны зээлийн зах зээлд эзлэх хувь

**24.3%**

Голомт банк харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг хүргэхийг зорин ажилладаг. 2024 онд харилцагч төвтэй банкны бүтээгдэхүүн, үйлчилгээгээ салбар, тооцооны төвүүд болон цахим сувгуудаараа амжилттай хүргэлээ.

- 2024 онд хэрэглээний зээл олголтыг салбар болон дижитал сувгаар дэмжин таатай нөхцөлийг санал болгож, хэрэглээний зээлийн зах зээлд эзлэх хувийг амжилттай хадгаллаа. Харилцагчдын гэнэтийн мөнгөний хэрэгцээг богино хугацаанд хангах зориулалт бүхий дижитал зээлийн үйлчилгээ хэрэглэгчид дадал болж, хэрэглэгчийн тоо болон зээлийн багц өндөр өсөлтийг үзүүллээ.
- Цалингийн харилцагч байгууллага болон ажилтнуудад цалингийн зээлийн таатай нөхцөл санал болгон цалингийн зээлийн багцын өсөлтийг нэмэгдүүлэв.
- Иргэдийг орон сууцжуулах ажилд идэвхтэй оролцож, 2024 онд нийт 4,433 харилцагчид орон сууцны зээл олголоо. Ингэснээр банкны зах зээлд 24.3 хувийг дангаараа бүрдүүлж байна.
- Харилцагч, зээлдэгч нартаа санхүүгийн нэгдсэн үйлчилгээг үзүүлснээр банкны даатгалын зуучлалын зах зээлд сүүлийн гурван жил дараалан түүчээлж, тэргүүлэгч банк байр сууриа хадгалж чадлаа. Мөн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэн ач холбогдлыг таниулан сурталчилж, зээлдэгч нарын 90-ээс дээш хувийг даатгалд хамрууллаа.

## Бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Нийт харилцагчдаа зориулан богино хугацаанд уян хатан нөхцөлтэйгөөр, хялбар аргаар санхүүгийн хэрэгцээгээ хангах боломж бүхий дижитал цалингийн зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.
- Нийгмийн хариуцлага, Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг “Ногоон хэрэглээний зээл”-ээр дамжуулан санхүүжүүлж эхэллээ. Мөн эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, амины орон сууцыг зээлээр санхүүжүүлэн ажиллалаа.



- Амьдралын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр нэвтрүүлж, харилцагч нартаа санал болгож эхэллээ. Даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, ач холбогдлыг таниулан сурталчилж, зээлдэгч нарын 90-ээс дээш хувийг даатгалд хамруулав.
- Уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, малчны хамтын санаачилга, хоршоог дэмжих хүрээнд “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн бүтээгдэхүүн нэвтрүүллээ.

## Аян, урамшуулал, борлуулалт



### “Хадгаламжтай аялал” аян

Голомт банк харилцагч нартаа зориулан ирээдүйдээ хөрөнгө оруулж, санхүүгийн дархлаатай болоход нь дэмжих зорилгоор бүтэн жилийн турш хадгаламжийн сугалаат аянуудыг хэрэгжүүлдэг. 2024 онд Голомт банкны 220,000 гаруй харилцагч хуримтлалаа өсгөж, “Хадгаламжтай аялал” аянд хамрагдсанаас Парисын Олимп үзэх эрхийн 5 хос азтан, Хонконгийн “Disneyland” руу аялах эрхийн 20 хос азтан, Ойрхи Дорнод буюу Катар, Оман болон АНЭУ-аар хил дамнан усан онгоцоор аялах 10 хос азтаныг шалгаруулав.



### “New born” аян

Нийслэлийн болон орон нутгийн 22 амаржих газартай хамтран ажиллаж, Монгол Улсад мэндэлж буй бяцхан үрсийг Голомт банкны харилцагчаа болгох “New born” аяныг 3 дахь жилдээ хэрэгжүүллээ. Аяны үр дүнд 1516 хүүхдэд зориулан шинээр хадгаламж нээлээ.



### “GenZ Loyalty” хөтөлбөр

Хүүхэд, залууст санхүүгийн зөв туршлага хуримтлуулахад нь тусалж, тэдний ухаалаг хэрэглээг урамшуулах, санхүүгийн боловсрол олгож, банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэж таниулах “GenZ Loyalty” урамшуулалт хөтөлбөрөө 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ. 0-22 насны хүүхэд, залууст зориулсан уг аянд 217,000 гаруй харилцагч хамрагдсанаас 101 сугалааны азтан шалгарч, 1 харилцагч супер азтанаар тодрон Хонконгд 2ne1 хамтлагийн тоглолтыг хосоороо үзэх эрх хожлоо.



#### **“Big Loyalty” хөтөлбөр**

Нийт харилцагчаа идэвхжүүлэх, үнэ цэнтэй харилцагчдыг нэмэгдүүлэх зорилготой “Big Loyalty” урамшуулалт хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүллээ. Уг аянд 967,660 харилцагч хамрагдаж, лоялти оноо, түүнийг дагасан урамшууллаудаас хүртлээ. Аян хэрэгжсэн 9 сарын хугацаанд 8 удаагийн тохирлоор “iPhone 15 Pro Max” гар утасны азтануудыг шалгаруулжээ.

#### **“Хуримтлалтай хилчин” хөтөлбөр**

Хил хамгаалах байгууллагын “Хуримтлалтай хилчин” хөтөлбөрт хамтран ажиллах замаар цалингаа авдаг харилцагчийн тоо, иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх зорилгоор “Хуримтлалтай хилчин аян”-г тайлант хугацаанд хэрэгжүүллээ. Аяны хүрээнд 393 харилцагч хадгаламж шинээр нээлгэсэн бөгөөд Голомт банкаар цалингаа авдаг хилийн цэрэг харилцагчийн тоо 78%-аар өсөж, 1,328 харилцагч боллоо. Аяны хүрээнд нийт 2 удаагийн тохирлоор 20 азтан тодрууллаа.

#### **Шууд борлуулалт**

Банкны үйлчилгээг харилцагчийн байгаа газарт нь очиж хүргэдэг шууд борлуулалтын хүрээнд 2024 онд 621 байгууллагад ажиллаж, банкны 10,800 бүтээгдэхүүн үйлчилгээг борлууллаа. Нийт 1799 харилцагчийн 30.3 тэрбум төгрөгийн зээлийн багцыг бүрдүүлэв.

#### **Утсан борлуулалт**

Харилцагчдад банкны бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг түргэн шуурхай хүргэх, борлуулалт хийх утсан борлуулалтын хүрээнд тайлант хугацаанд нийт 393,539 харилцагч руу амжилттай холбогдож, мэдээлэл хүргэсэн бөгөөд 50,229 ширхэг бүтээгдэхүүн борлуулав.

## Хамтын ажиллагаа

Харилцагчийн бааз суурийг цалингийн байгууллагаар дамжуулан тэлэх зорилгоор чанартай зээлийн багц бүхий төрийн байгууллагуудад онцгой хөнгөлөлттэй нөхцөл санал болгож, хамтран ажиллах гэрээ байгууллаа.



### “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Монгол Улсын хэмжээнд 2023 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ойн санг 9%-д хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэхээр Голомт банк хамтран ажилладаг. 2024 онд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан”-г банк хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагаагаар дэмжин 2.3 тэрбум төгрөгийг санд төвлөрүүлж ажиллалаа.



### МИК

Орон сууцны ипотекийн зээлийг нэн тэргүүнд зорилтот харилцагчид нь хүргэх, нээлттэй шударга тогтолцоог бүрдүүлэхийг зорилгоо болгож, зохицуулагч байгууллагуудтай хамтран удирдлагаар ханган 262 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 2,232 иргэнд 6%-ийн хүүтэй ипотекийн зээл олгож, орон сууцжуулав.


Харилцагчдад хүрч үйлчлэх сувгийг өргөжүүлэн Улаанбаатар хот болон орон нутагт нийт 8 салбар тооцооны төв, төлбөр тооцооны 2 кассын үйл ажиллагааг эхлүүлэв.




Цэнгэлдэх салбар, Гөү ТҮ Маркет салбар, Акоюа салбар, Драгон салбар




Хэнтий салбар



Жи центр хувийн банкны салбар, Тара центр хувийн банкны салбар, Алтан жолоо хувийн банкны салбар



83-р касс /Сонгинохайрхан салбарын харьяа, 5 шарын Оргил худалдааны төв/



86-р касс /Солонго салбарын харьяа, Алтан жолоо 1-р давхар/

Ачаачал ихтэй салбаруудын зарим үйлчилгээг дижитал төхөөрөмжүүд рүү шилжүүлж, харилцагчийн хүлээгдлийг бууруулах зорилгоор дижитал шилжилтийн хүрээнд шинэ киоск төхөөрөмжийг эхний 10 салбарт байршууллаа.

## Арга хэмжээ

Голомт банк удирдах ажилтнуудаа чадавхжуулах, туршлага солилцох зорилгоор олон арга хэмжээ, сургалт зохион байгуулдаг. Үүнд, бизнес төв, салбар, тооцооны төвүүдийн захирлууд руу чиглэсэн “Branch manager’s meeting” хурлыг 2024.02.02-нд амжилттай зохион байгуулав. Арга хэмжээний үеэр банкны 2023 оны үр дүн, 2024 оны бизнесийн зорилт, стратеги, баримтлах бодлого чиглэлүүд, шинэ бүтэц зохион байгуулалтыг танилцуулав.



Орон нутгийн салбар тооцооны төвийн захирлуудад зориулсан арга хэмжээ, сургалт зохион байгуулж, салбарын үйл ажиллагаатай холбоотой санал солилцох хэлэлцүүлэг өрнүүлж, удирдах ажилтанд шаардлагатай сүүлийн үеийн чиг хандлагын талаар хуваалцлаа.

Тайлант хугацаанд гүйцэтгэл, үр ашиг, чанараараа тэргүүлсэн “Шилдэг салбар”-ууд болон “Онцгой амжилт гаргасан салбар”-ыг тодруулж, алдаршуулав.



## Дижитал банк

Дижитал сувгийн нийт хэрэглэгчийн тоо

↑ **12.6%**

SocialPay нийт хэрэглэгчийн тоо

↑ **35.1%**

Дижитал сувгаар хийгдсэн гүйлгээний тоо

↑ **26.8%**

Дижитал зээлийн багц

↑ **3.2** дахин



Стратегийн ач холбогдол бүхий дижитал шилжилтийг дэмжсэн томоохон төслүүдийг хэрэгжүүлэн харилцагч төвтэй, хэрэглээний хялбар шийдлийг бий болгох шинэ үйлчилгээ, хөгжүүлэлтүүдийг хийж, амжилттай нэвтрүүлэв.



## Бүтээгдэхүүн, үйлчилгээ

### Интернэт банк, Смарт банк

- IBAN дугаараар гүйлгээ хийх,
- Кредит картын сунгалт хийх болон гүйлгээ хийх,
- Кредит карт нөхөн авах боломжтой болов.
- Хэрэглээний төлбөр цэс дээрх байгууллагын тоог нэмэгдүүлэв.



### Интернэт банк

- И-баримтын хялбар бүртгэлийг шинэчлэв.
- IBAN дугаараар онлайн тодорхойлолт гаргах,
- Дансны хуулгыг тоон гарын үсгээр баталгаажуулах,
- Харилцагчийн данс нээсэн гэрээг цахим шуудан руу илгээх,
- Хувийн мэдээлэл шинэчлэх, захиалгат шилжүүлэг бүртгэхэд харилцагч руу мэдэгдэл илгээх,
- 7-17 насны хүүхдэд интернэт банк нээх,
- 7-17 насны хүүхдэдээ The Color карт захиалах боломж бүрдэв.
- Кредит карт нөхөн авах, сунгалт хийх, өдрийн гүйлгээний лимит өөрчлөх, өөрийн бусад данс руугаа шилжүүлэг хийдэг болов.

- Тоон гарын үсгийн баталгаажуулалт нэвтрүүлэв.

Харилцагч нар интернэт банкаараа дамжуулан өөрийн дансны хуулгыг тоон гарын үсгээр баталгаажуулан авснаар банкны салбарт хандах шаардлагагүйгээр баталгаажсан хуулга татаж авах боломж бүрдсэн.

- Хүүхдийн мөнгөний харилцах данс нээх боломжийг бүрдүүлэв.

Монгол Улсын Засгийн газраас сар бүр олгодог “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” хүлээн авах дансыг интернэт банк ашиглан нээх боломжтой боллоо. Голомт банкны харилцагч өөрийн интернэт банкны эрхээр нэвтэрч, 0-16 насны хүүхдэдээ данс нээснээр сар бүрийн тэтгэмжээ авах харилцах данс нээгдэнэ. Дансны дугаараа [www.ehalamj.mn](http://www.ehalamj.mn) болон И-Монголиа үйлчилгээгээр дамжуулан хүлээн авах данс болгох эсвэл хорооныхоо халамжийн ажилтанд мэдэгдэж, дансаа солиулах боломжтой.

- Виз мэдүүлэхэд шаардагддаг дансны хураангуй хуулгыг англи хэлээр авах боломжтой болов.

Хилийн чанадын зарим улсыг зорихоор виз мэдүүлж буй иргэдийн бүрдүүлэх материалын жагсаалтад дансны хураангуй хуулга багтдаг. Тухайлбал, БНСУ-ын ЭСЯ-ны хүсэлтийн дагуу Голомт банк дансны хураангуй хуулгыг монгол хувилбараар олгодог. Гэвч зарим улсын ЭСЯ руу виз мэдүүлэхэд дансны хуулгыг орчуулах шаардлага тулгарч байгаа тул англи хэл дээр гаргах боломжийг бий болголоо.



- Дижитал хэрэглээний зээл авах боломжийг бүрдүүлэв.

Голомт банкны 8 төрлийн зээлийг дижитал сувгаар олгох боломжтой болов. Тодруулбал, Голомт банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан мерчантаас бараа, бүтээгдэхүүнийг дижитал хэрэглээний зээлийн хүрээнд интернэт банк болон смарт банк аппликэйшнээр дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү зээл нь салбараар үйлчлүүлэх шаардлагагүй, байгаа газраасаа зээлийн хэмжээгээ тогтоолгох боломжтой, хугацааны сонголттой юм. Бусад төрлийн хэрэглээний зээлтэй харьцуулахад бага хүүгийн нөхцөлийг харилцагчдад санал болгож байна.



### Смарт банк

- Смарт банкны бүх гүйлгээг нууц үгээр баталгаажуулах,
- Данс нээх үед батлах нууц үг оруулах,
- Нууц үгийн блок гаргах үйлдлийг аппликэйшнээр хийх,
- Дебит карт захиалах, нөхөн авах, сунгах шимтгэл хураамжийг MDW-ээс авах,
- Харилцах, Зээл, Кредит картын дансны дэлгэрэнгүй хуулах боломжтой болов.



### SocialPay

- Аппликэйшнээр дамжуулан харилцагчид хоорондоо үнийн дүнтэй бэлэг илгээх,
- OCR системээр дансны дугаарын зургийг танин гүйлгээ хийх,
- "GGames" цэс дээрх тоглоомын төрөл, худалдан авалт хийх боломж нэмэгдсэн.
- Хуваан төлөх үйлчилгээг нэвтрүүлэв.

Энэхүү үйлчилгээний хүрээнд SocialPay аппликэйшнээр дамжуулан бараа, бүтээгдэхүүний төлбөрийг 3-7 хуваан төлөх сонголттой. 30-90 хүртэлх хоногийн хугацаатайгаар хүүгүй, шимтгэлгүй нөхцөлөөр худалдан авах боломжийг дамжуулан харилцагч нартаа олгож байна.



### SocialPay Junior

- Гэр бүл цэс шинээр нэмлээ.

Гэр бүл цэс дээр эцэг, эхээсээ даалгавар авч биелүүлээд даалгаврын шагнал болгон нэхэмжлэл илгээх боломжтой. Уг аппликэйшн хэрэглэгч хүүхдүүд санхүүгийн боловсрол олгох, гэр бүлийн бүх гишүүдийг хамарсан үйлчилгээ тул технологид суурилсан шинэ туршлагыг хуримтлуулах боломжтой болж байгаа юм.

- SocialPay Junior руу бүртгэл үүсгэж, нэвтрэх боломжтой болов.

0-17 насны хэрэглэгчид SocialPay Junior аппликэйшний бүртгэл цэсийг ашиглан өөрсдөө бүртгүүлэх, аппликэйшндээ карт холбох, чат бичих, theme солих зэргээр ашиглах боломжтой боллоо.



#### Лоялти

- Лоялти цахим хуудастай болов.

Ингэснээр олон улсын болон дотоодын хөнгөлөлтийн сүлжээний байгууллагуудын мэдээллийг нэг дор төвлөрүүлэв.

- Лоялти цахим хуудас болон SocialPay аппликэйшнээр Хадгаламжийн купон, Картын купон болон Бэлэн мөнгөний купон үүсгэж, ашиглах боломж бүрдэв. Мөн Big Loyalty, GenZ Loyalty аяны хүрээнд цуглуулсан оноогоо ашиглах боломжтой юм.

- Хадгаламжийн купон

SocialPay аппликэйшн дэх Лоялти цэсээр дамжуулан өөрийн нэр дээрх хадгаламждаа нэмэх эсвэл шинээр хадгаламж нээж, купоны мөнгөн дүнгээрээ орлого хийж болно.

- Картын купон

Шинээр карт захиалж, дурын дансыг холбон карттай болсноор сугалаатай хөтөлбөрт ашиглах, оноотой хөтөлбөрт оноогоор сольж авах зэрэг давуу талтай. Мөн купоны мөнгөн дүнгээрээ орлого хийх боломжтой.

- Бэлэн мөнгөний купон

SocialPay болон SocialPay Junior аппликэйшн ашиглан QR код уншуулж, Голомт банкны картаараа худалдан авалт хийх, өөрт байгаа ашиглах боломжтой бэлэн мөнгөний купоноос нэг худалдан авалтад нэгийг ашиглах байдлаар ашиглаж болно.

- SocialPay аппликэйшн дээрх Лоялти цэсэнд Хөнгөлөлтийн сүлжээний байгууллагууд, "Купоны дэлгүүр" цэсийг нэмэв.


СошиалПэй аппликэйшн болон Лоялти цахим хуудсаар дамжуулан "Купоны дэлгүүр" үйлчилгээ рүү нэвтэрч, хамтрагч байгууллага болон Голомт банкнаас зарласан купонуудыг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжтой болсон.

## Карт

### Хүүхэд, залуусын The Color картыг шинэчлэв

Санхүүгийн боловсролд эртнээс суралцаж, санхүүгээ зохицуулан удирдах боломжийг 7-22 насны хүүхэд, залууст олгодог The Color картыг илүү өнгөлөг болголоо. Мөн картын доод хэсэгт notch буюу ховилтой болж, харилцагч төвтэй дэвшилтэт шийдлүүдийг шинээр нэмсэн. Түүнчлэн энэхүү шинэчлэгдсэн картыг Голомт банкны харилцагч нар 16 хүртэлх насны хүүхдэдээ салбарт хандах шаардлагагүйгээр өөрийн интернэт банкаараа нэвтрэн Хүүхдийн карт захиалга цэсээр захиалж болох юм.







### SocialPay виртуал кредит картыг шинэчлэн зах зээлд нэвтрүүлэв

Энэхүү виртуал кредит картыг SocialPay аппликэйшний хэтэвч цэснээс идэвхжүүлж, 500,000 төгрөг хүртэлх зээлийн эрхээр ашиглах боломжтой болов.

### Бүх төрлийн дебит буюу төлбөрийн картуудыг шууд хэвлэн олгох боломжтой болов

Харилцагчдынхаа төлбөр тооцооны яаралтай хэрэгцээ шаардлагыг хангах, цаг хугацааг хэмнэхийн тулд төлбөрийн картыг газар дээр нь 1-2 минутад хэвлэн олгодог боллоо. Өөрөөр хэлбэл, Голомт банкны харилцагчид гадаад болон дотоод төлбөрийн карт яаралтай хэрэгтэй болсон үед салбарт хандан шууд хэвлүүлэх боломжтой. Мөн шууд борлуулалтын аяны үеэр энэ үйлчилгээ хэрэгжинэ.

- Байгууллагуудтай хамтарч, 6 төрлийн кобрэнд дебит картуудыг зах зээлд нэвтрүүлэв.
- Кредит карт захиалах боломжит сувгийг нэмэгдүүлж, [www.cards.mn](http://www.cards.mn) цахим хуудсаар дамжуулан захиалах боломжтой болов.
- Голомт банкны кредит карт эзэмшигчид өөрийн зээлийн эрхээс хуваалцаж, гэр бүлийн гишүүддээ дэд карт олгох боломж бүрдэв.



## Дижитал сувгийн бусад онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээ



### Apple Pay хэтэвчээр төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлэв

Дэлхийн 90 орчим улсын 800 сая гаруй хүн ашиглаж буй Apple Pay төлбөрийн системийг Голомт банк 2024 оны 12-р сарын 10-нд Монгол Улсад анхлан нэвтрүүлэв. Энэхүү дижитал төлбөрийн шийдэл нь харилцагчдад илүү аюулгүй, хурдан, хялбар гүйлгээ хийх боломжийг олгож байна.

Төслийг хэрэгжүүлснээр:

- Голомт банкны биет болон виртуал Мастеркартыг Apple Pay-д холбох боломжтой болсон.
- Бүх төрлийн үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхдээ iPhone, iWatch гэх мэт төхөөрөмжүүдээ ПОС төхөөрөмжид уншуулж, төлбөр төлөх боломжтой. Харин онлайн худалдан авалтад iPhone, iWatch, iPad, iMac, Macbook зэрэг ухаалаг төхөөрөмжөөр төлбөрөө төлж болно.
- Ердөө хоёрхон товшилтоор секундийн дотор гүйлгээ хийгдэж, Монгол Улсын iOS үйлдлийн систем хэрэглэж буй 1.6 сая гаруй хүн Apple Pay хэтэвчээ ашиглан дэлхийн хаана ч төлбөр тооцоо хийх боломж бүрдсэн юм.

Apple Pay хэтэвч нь Apple брэндийн ухаалаг төхөөрөмжүүдийн NFC технологиор дамжуулан банкны пластик болон виртуал картаараа төлбөр тооцоо хийх хурдан, хялбар шийдэл юм.

## 29 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх киоскыг нэвтрүүлэв

Салбарын ачааллыг бууруулах, харилцагчдад хялбар, шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор бүх төрлийн гүйлгээ, харилцах болон хадгаламжийн бүтээгдэхүүн, карт болон зээлийн үйлчилгээ зэрэг 29 нэр төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой киоскыг салбарууддаа нэвтрүүлэв. Ингэснээр үйлчилгээ авах хугацааг 46 хувиар буурууллаа.



- Голомт банкны харилцагч нар UnionPay аппликэйшнд UnionPay брэндийн картаа холбосноор ямар ч шимтгэлгүй, түргэн шуурхай төлбөр тооцоогоо хийдэг боллоо.
- Чимэгэ системс компанитай хамтран AI суурьтай ухаалаг чат ботыг нэвтрүүлэв. Уламжлалт блок схем суурьтай ботыг хэрэглээнээс халж, AI модельд үндэслэн дурын асуултаа асуух замаар харилцагч хүссэн мэдээлэл авах боломжийг бүрдүүлснээрээ онцлогтой. Банкны чатаар харилцсан түүхэн датаг Large language model дээр сургаж, мэдлэгийн сан үүсгэсэн нь AI суурьтай банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд сайн туршлага болж байна.
- Агент банкны үйлчилгээ нэвтрүүлж, харилцагч бүртгэх, данс нээх, карт захиалах гэх мэт үйлчилгээг гуравдагч байгууллагаас авах боломжтой болов.

## Урамшуулалт аян, хөтөлбөр

### SocialPay урамшуулалт аян

SocialPay 3.0 болон SocialPay Junior аппликэйшнийг зах зээлд идэвхжүүлэх, лоялти хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор SocialPay урамшуулалт аяныг 5-р сарын 1-ээс 8-р сарын 31-ний өдрүүдэд зохион байгууллаа. Аяны хүрээнд хэрэглэгчид “Big loyalty” болон “GenZ loyalty” хөтөлбөрүүдтэй уялдахуйц байдлаар аппликэйшндээ оноо цуглуулж, түүгээрээ купон худалдан авч ашиглах боломж бүрдсэн.

### GenZ Loyalty урамшуулалт аян

22-оос доош насны харилцагчдадаа зориулан SocialPay, SocialPay Junior аппликэйшн, Лоялти цахим хуудас болон Голомт банкны бүтэээгдэхүүн, үйлчилгээг ашиглах бүрд оноо цуглуулж, цуглуулсан оноогоороо хөнгөлөлтийн купон авах, К-рор тоглолт үзэх шагналтай сугалаат урамшууллыг зохион байгуулав.

### “Пуужин Баяраа” тоглолт

Тоглолтын ерөнхий ивээн тэтгэгчээр SocialPay аппликэйшн хамтран ажиллалаа. Энэ хүрээнд тоглолтын тасалбарыг тус аппликэйшний Нэмэлт үйлчилгээ цэсээр 43,000 тасалбар борлуулж, 20 хувийн буцаан олголт болон сугалаат хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэв.



## Харилцагчийн үнэнч байдлыг урамшуулах, идэвхжүүлэх зорилготой 22 төрлийн лоялти хөтөлбөрийг хэрэгжүүлэв.



### Картын буцаан олголт


VIP картаараа "Link Lounge" үйлчлүүлэх боломж бүрдэв.



Дээрх байгууллагуудаас The Color Card-аар хийсэн худалдан авалтад буцаан олголттой.

### Картын буцаан олголт

The Color картын урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэв.



дараах вэбсайтуудаас худалдан авалт бүрдээ


### Картын буцаан олголт

Онлайн худалдан авалт хийхэд үйлчлэх урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэв.



### Картын буцаан олголт

Олон улсын эрхтэй картуудаараа хөнгөлөлттэй үйлчлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэв.



Голомт банкны бүх төрлийн кредит карт болон Премьер, Si, Алтан дебит картуудаар хийсэн худалдан авалтад

буцаан олголттой

### Картын буцаан олголт

Кредит картны олон улсын урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэв.



www.golomtbank.com 1800-1646

### Картын буцаан олголт

Олон улсын үйлчлэх буцаан олголттой урамшуулалт хэрэгжүүлэв.



### Сугалаат хөтөлбөр

ЮнионПэй картаараа олон улсад гүйлгээ хийсэн харилцагч нараас азтан шалгаруулав.



### Сугалаат хөтөлбөр

Виза карт эзэмшигч нараас "Парис 2024" олимп үзэх азтан шалгаруулав.



### Картын 25 жилийн ой

Голомт банк Монгол Улсад анхлан ОУ-ын төлбөрийн карт нэвтрүүлсний 25 жилийн ойн урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэв.

### Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан хөтөлбөр

Голомт банкны ПОС эзэмшигч нартаа зориулан хүлээн авсан мөнгөн дүнд нь сугалаа олгож, 1 харилцагчид автомашин, 3 харилцагчид гадаад аяллын эрхийн бичиг, 30 харилцагчид гар утас, 28 харилцагчид хадгаламжийн купон олголоо.

### Арга хэмжээ



### Картын 25 жилийн ой

Монгол Улсад олон улсын төлбөрийн карт нэвтрүүлсний 25 жилийн ой тохиолоо. Анх 1999 онд Голомт банк олон улсын “MasterCard Worldwide” байгууллагын албан ёсны гишүүн болж, Голомт нэрийн Мастер картыг картын зах зээлд нэвтрүүлсэн түүхтэй. Энэхүү ойг тохиолдуулан дараах арга хэмжээг зохион байгуулав.



### Нээлттэй ирээдүй – Дижитал аймаг

Голомт банк орон нутагт технологийн шинэ шийдлийг таниулах, дижитал хөгжлийг түгээх зорилготой “Нээлттэй ирээдүй” арга хэмжээг 2022 - 2024 онд Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Дорнод, Ховд, Баянхонгор аймагт зохион байгуулж, нийт 16,000 гаруй иргэнийг хамруулсан. хамруулан амжилттай зохион байгуулж байсан.

2024 онд “Нээлттэй Ирээдүй – Дижитал Өмнөговь” арга хэмжээнд технологи, дижитал шилжилтийг өөрсдийн бүтээгдэхүүнд нэвтрүүлсэн салбар, салбарын 22 байгууллага оролцож, санал солилцсоноос гадна тус байгууллагууд өөрсдийн мэдээллийн цэг дамжуулан хүрэлцэн ирсэн зочдод бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулан бүх төрлийн дижитал үйлчилгээг үзүүлэв.



### SocialPay - "Singapore Fintech Festival"

Азийн хамгийн том финтек үзэсгэлэн, яармаг болох "Singapore Fintech Festival" -д SocialPay аппликейшнээ танилцуулан амжилттай оролцлоо. Сингапур улсад 2024 оны 11-р сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулагдсан энэхүү арга хэмжээнд нийт 134 орны 62,000 гаруй байгууллага оролцож, санхүүгийн салбарт нэвтрүүлсэн технологийн шилдэг шийдлүүдээ танилцуулсан юм. "Singapore Fintech Festival"-д Монгол Улсыг төлөөлөн Монголбанк, Тэрбум мод сан, Монголын банкны холбоо, Монголын финтекийн холбоо, Сторпэй ХХК, Оптимал Эн Макс ХХК, М банк болон Голомт банк гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцсон ба дэлхий дахины бодлого боловсруулагчид болон санхүү, технологийн салбарын мэргэжилтнүүдтэй нэг дор цугларан өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилж, амжилттай оролцов.

### "Олон улсын төлбөр тооцооны чиг хандлага" чуулга уулзалт

Голомт банк "Олон улсын төлбөр тооцооны чиг хандлага" чуулга уулзалтыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд банк санхүү, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын 95 байгууллагын нийт 130 орчим зочин, төлөөлөгч хамрагдлаа. Чуулга уулзалтын үеэр Visa, MasterCard, GRG Banking, UnionPay, Cardzone зэрэг дэлхийд тэргүүлэгч компанийн төлөөллүүд орчин үеийн төлбөр тооцооны хэрэгслийн хөгжил, банкны үйлчилгээний шинэ чиг хандлага, түүнийг дагасан технологи, бизнесийн шаардлага, гарц, шийдлүүдийн талаар хэлэлцүүлэг өрнүүлээ. Мөн Монгол Улсын картын төлбөр тооцооны системийн түүх, ОУ-ын төлбөр тооцооны МУ-д үзүүлсэн нөлөө, төлбөр тооцооны системд тулгарч буй технологийн бэрхшээл, шинэлэг амьдралын шинэ инноваци болон харилцагчийн туршлага, ногоон хөрөнгө оруулалт зэрэг сэдвээр хэлэлцсэн юм.



### "Discover Mongolia, Discover Magic 2024"

Картын төлбөр тооцооны бизнес, мэдээлэл технологийн салбарт хамтран ажиллаж буй олон улсын вендор байгууллагуудын дунд зохион байгуулдаг "Discover Mongolia" арга хэмжээ 20 дахь жилдээ боллоо. Бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх, монгол ёс заншлыг таниулах, амжилтаа эргэн дурсах, бизнесийн шинэ боломжуудыг эрэлхийлэх зорилготой уг арга хэмжээг Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хангал нууранд зохион байгуулж, хамтран ажиллагч 16 байгууллагын зочид, төлөөлөгчдийг хамруулав.

## Олон улсын бизнес, хамтын ажиллагаа

Голомт банк олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагууд болох Moody's болон S&P Global байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийг 2011 оноос хойш үнэлүүлж, хамтран ажиллаж байна. 2024 онд зээлжих зэрэглэлүүд сайжирч, Moody's агентлаг "B2", S&P агентлаг "B+" болгон тус тус "тогтвортой" төлөвтэй хэмээн үнэлэв.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг Moody's агентлаг "B2", "тогтвортой"; S&P агентлаг "B+, эерэг"; Fitch Ratings агентлаг "B+, тогтвортой" болгож шинэчлэн сайжруулсныг зарлав.

### Голомт банкны зээлжих зэрэглэл

#### Moody's

Ангилал	Үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B2
Төлөв	Stable
Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3
Үнэт цаасны үнэлгээ	B2

#### S&P Global

Ангилал	Үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B+/Stable/B
Төлөв	Stable
Үнэт цаасны үнэлгээ	B
Хөрвөх чадварын үнэлгээ	B+

### Монгол Улсын зээлжих зэрэглэл

Moody's	S&P Global	Fitch Ratings
Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	Урт хугацаат гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл
B2/Тогтвортой	B+/Эерэг	B+/Тогтвортой

Голомт банк ногоон, тогтвортой хөгжлийн чиг баримжаатай бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн тэгш хүртээмж, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, дотоодын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилтот санхүүжилтийг нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангуудаас татлаа. Эдгээр санхүүжилт нь урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй байхаас гадна мэргэшсэн зөвлөх үйлчилгээний баг банк болон харилцагчдын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



Швейцар улсад төвтэй responsAbility Investments AG-ийн удирддаг Global Climate Partnership Fund-аас дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, үйлдвэрийн барилгын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэсэн эх үүсвэрийг хоёр дахь удаадаа олгов.



Швейцар улсад төвтэй responsAbility Investments AG байгууллагын удирддаг Global Gender Smart Fund байгууллагаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих, тэдний эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах зорилгоор урт хугацааны санхүүжилт татав.



Сингапур улсын Saison Investment Management Private Limited байгууллагаас урт хугацаат ногоон зээлийн санхүүжилтийн хоёр дахь удаагийн хамтын ажиллагаа амжилттай үргэлжлэв. Тус ногоон зээлийн санхүүжилт нь байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэхээс гадна Монгол Улсын Ногоон Таксономын дагуу сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга гэх мэт олон төрлийн ногоон зээлийн санаачилгыг дэмжих зорилготой



Бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор ХБНГУ-ын Agents for Impact санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

### Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч түнш байгууллагууд




Голомт банк АНУ-ын The Bank New York Mellon (BNY) банканд ам.долларын корреспондент харилцааг тогтоож, харилцагчдынхаа олон улс руу хийгдэх ам.долларын гүйлгээг илүү түргэн шуурхай, бага зардлаар хийгдэх нөхцөлийг бүрдүүлэв. Ингэснээр нийт 15 гадаад валютын 52 корреспондент банкны дансаар дамжуулан гадаад төлбөр, тооцооны үйлчилгээг хамгийн өргөн сонголттойгоор гүйцэтгэж байна.




Бид харилцагчдынхаа хил дамнасан төлбөр тооцоог хурдан, шуурхай хийж гүйцэтгэх зорилгоор корреспондент банкнуудын хамтын ажиллагаа, сүлжээг тогтмол өргөжүүлэн ажилладаг.

### Гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувь



Илгээсэн гүйлгээний тоогоор



Илгээсэн гүйлгээний дүнгээр

### SWIFT сүлжээгээр хийгдэж буй гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувь

Голомт банк 2024 онд Монгол Улсын банкны системийн нийт гадаад төлбөр тооцооны гүйлгээний 24.8 хувийг дангаар хийж гүйцэтгэсэн тухай SWIFT олон улсын байгууллагын SWIFT Watch тайланд тусгажээ.



Эх сурвалж: SWIFT Watch report

Олон улсын корреспондент банкнууд

## Гадаад худалдааны санхүүжилт

### Гадаад худалдааны санхүүжилтийн нийт багц, зах зээлд эзлэх байр суурь

Голомт банк харилцагчдадаа гадаад худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээг саадгүй үзүүлэхэд зориулж, олон улсын 300 гаруй түнш банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран харилцагчдадаа хамгийн өртөг багатай санхүүжилтийн шийдлийг санал болгохын зэрэгцээ импорт, экспортын эргэлтийг нэмэгдүүлэх, үүсэж болох төлбөрийн болон нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Тухайлбал, 2024 онд Голомт банкны Худалдааны санхүүжилтийн нийт багц 515.2 тэрбум төгрөг (үлдэгдлээр) байгаа бол банкны нийт Гадаад худалдааны санхүүжилтийн эргэлт 1.8 их наяд төгрөг (олголтоор) буюу энэ хэмжээний бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж болон төслүүдийг худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр дэмжин ажиллав.

Монгол Улсад 2024 онд нийт 39.72 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортлогдсон ба үүний 21.7%-ийг машин, тээврийн хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл болон эд анги эзэлж байна. Харин Голомт банк 2024 онд нийт 890 тэрбум төгрөгийн импортын бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг санхүүжүүллээ.

Мөн экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, ноос ноолуурын бараа бүтээгдэхүүний экспортод зориулан гаднын банк санхүүгийн байгууллагуудаас нээгдсэн 510 тэрбум төгрөгийн дүнтэй тэнцэх аккредитив, гадаад баталгааны хүсэлтийг хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэн ажиллав. Ингэснээр 2024 оны жилийн эцсийн байдлаар гадаадын худалдан авагчдаас Монгол Улсын үйлдвэрлэгчид рүү нээгдсэн нийт экспортын аккредитив, гадаад баталгааны зах зээлийн 53%-ийг Голомт банк дангаар гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.

### Импортын аккредитивын цахим үйлчилгээ

Бид харилцагчдадаа хүргэх үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэх, цаасан хэрэглээг бууруулах зорилгоор импортын аккредитив нээх хүсэлтийг цахимаар хүлээн авах үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Уг үйлчилгээг авах хүсэлтэй нийслэл болон орон нутгийн харилцагчид банкны салбарт хандах шаардлагагүйгээр интернэт банкны цахим эрхээрээ хандан аккредитив нээлгэх хүсэлтээ илгээхийн зэрэгцээ нээгдсэн аккредитивын төлөвөө хянах боломж бүрдэж байна.

### Гадаад баталгаа, аккредитивээр зах зээлд эзлэх хувь

Олон улсын SWIFT байгууллагаас гаргасан тоон мэдээгээр Голомт банк нь 2024 онд гадаад баталгаа, аккредитив нээх үйлчилгээгээр тэргүүлэх байр сууриа хадгалж зах зээлийн 53.2%-ийг эзэлж байна.




### Олон улсын худалдааны санхүүжилтийн хөтөлбөр

Голомт банк Олон улсын санхүүгийн корпорац болон Азийн хөгжлийн банкны “Гадаад худалдааны санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хамтын ажиллагааны хүрээнд нийт 74.5 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн импортыг санхүүжүүлэв.

### Монгол Улсын экспорт болон дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг худалдааны санхүүжилтээр дэмжиж ажиллаа

- Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжихэд Голомт банк чухал үүрэгтэй оролцож, 2024 онд нийт 140.4 тэрбум төгрөгийн уул уурхайн машин техник, тоног төхөөрөмжийн импортын аккредитив, 71.4 тэрбум төгрөгийн уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын аккредитив, 4.3 тэрбум төгрөгийн ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын аккредитивын үйлчилгээг үзүүлэв.



- Монгол Улсад хэрэгжиж буй дэд бүтцийн мега болон үйлдвэрийн бүтээн байгуулалтын төсөлд зориулж, Голомт банк БНХАУ-ын Bank of China (BoC), Agricultural Bank of China (ABC), China Construction Bank (CCB), Канад улсын Toronto Dominion Bank (TD), БНСУ-ын Kookmin Bank, Японы Mizuho Bank нартай хамтран тендер, урьдчилгаа төлбөр, гүйцэтгэл болон чанарын баталгаануудыг нээн ажиллалаа.



- Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж буй "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-д зориулж, туслан гүйцэтгэгч байгууллагын өмнөөс Ерөнхий гүйцэтгэгч рүү урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргав.
- Улаанбаатар хотын нийтийн тээврийн шинэчлэлд зориулан НЗДТГ-аас их оврын багтаамжийн автобус худалдан авахад зориулж, БНХАУ-ын Bank of China-тай хамтран урьдчилгаа төлбөр, гүйцэтгэл болон чанарын баталгаанууд гаргалаа.
- Зам, тээврийн яамнаас зарласан Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн нийт 65.2км авто замын өргөтгөл, Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах, засварлах дэд бүтцийн ажлуудад зориулан тендерийн баталгаануудыг нээж, БНХАУ-ын банкуудтай хамтран ажиллав.

# Тогтвортой хөгжил

Ногоон санхүүжилтийн  
хэмжээ

# 308

тэрбум төгрөг

Голомт банк дунд болон урт хугацааны зорилтуудын хүрээнд байгальд орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажиллахаар чиглэлүүдээ баталсан. 2019 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд харилцагчдынхаа ногоон шилжилтийг дэмжин ажиллаж байна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн S&P Global байгууллагаар Голомт банк Тогтвортой байдлын үнэлгээг (CSA) Монгол Улсын банк санхүүгийн байгууллагуудаас анхлан хийлгэсэн. Үнэлгээгээр нийт үнэлгээнд оролцсон олон улсын банк, санхүүгийн 668 байгууллагаас “Top third” ангилалд оров.

## Тогтвортой хөгжил

Голомт банкны уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтууд

Хүлэмжийн хийн ялгарал

2030 ↓30%




Усны нөөц

2030 ↓5%



### Тогтвортой санхүүжилт

Голомт банк 2019 оноос хойш нийт 875 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон. Үүнээс 2024 онд нийт 308 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилт олгож, жилийн эцсийн байдлаар тогтвортой, ногоон зээлийн багц 265 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.



Ингэснээр Голомт банкны нийт зээлийн багцын 3.6%-ийг ногоон зээлийн багц бүрдүүлж байна. Харин банкны системийн ногоон зээлийн багцын 19.6%-ийг Голомт банк бүрдүүлжээ.

Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10%-ийг тогтвортой, ногоон зээлийн багцаар бүрдүүлэх зорилтыг тавин ажиллаж байгаа бөгөөд энэхүү зорилтод хүрэхээр дараах 6 төрлийн тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож байна.

	Хүү (сарын)	Дээд хэмжээ	Хугацаа
Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн	1.2% - 1.4%	5-10 тэрбум төгрөг	30-84 сар
Хүү хуваан төлөх нөхцөлтэй бизнесийн ногоон зээл	1.2% - 1.4%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	84 сар
Ногоон АОС зээл	1.25%-1.4%	160-300 сая төгрөг	120-240 сар
Эко автомашины зээл	1%-1.1%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30-96 сар
Ногоон хэрэглээний зээл	1.25%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30 сар
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих	1.2% - 1.4%	100 сая төгрөг	36 сар

### Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

Голомт банк байгаль орчин, нийгмийн эрсдэлийг таних, хэмжих, үнэлэх, хянах, тайлагнах, бууруулах, удирдахад шаардлагатай банкны бодлого журмууд болон тогтолцоог ногоон эдийн засагт шилжих Үндэсний төлөвлөгөөтэй уялдуулж, байгаль орчны холбогдох хууль тогтоомж, бодлого журамд нийцүүлэн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийг удирдан ажиллаж байна.

2024 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн 2,321 үнэлгээг хийлээ. Үнэлгээний 72% нь эрсдэлгүй салбаруудад харьяалагдах санхүүжилтийн хүсэлт байсан бөгөөд үүнээс 84%-д нь санхүүжилт олгогджээ. Үлдсэн 28% нь байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх нөлөө өндөр салбаруудад харьяалагдах санхүүжилтийн хүсэлт байснаас 81%-д нь санхүүжилт олгожээ.

Нийт олгосон зээлийн тоо

525

1,412

Нийт үнэлгээ хийсэн тоо

646

1,675

● Эрсдэл өндөрт салбар ● Эрсдэлгүй салбар



Дэлхийн уур амьсгалын түншлэлийн сан (GCPF) хамтын ажиллагааны хүрээн дэх техник туслалцааны дагуу PRA (Pacific Risk Advisors) байгууллага нь Голомт банкны байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний систем, харилцагчийн болон ажилтнуудын санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх процесст анализ хийж, сайжруулах дүгнэлт өгсний дагуу үйл ажиллагаа, холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн сайжруулав. Улмаар Голомт банкны байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн стандарттай бүрэн нийцүүлэн ажиллаж байна. Мөн гаднын эх үүсвэрээр олгогдож буй зээлийн харилцагчийн гэрээнд нэмэлтээр “Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө” (ESAP) суулган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж эхлээд байна.

### Арга хэмжээ



### Financial Managers' Convention болон Business conference

Голомт банкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Financial Managers' Convention болон Business Conference арга хэмжээнүүдийг сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжилд нийцүүлэн зохион байгуулж байна. Энэ жилийн тухайд тогтвортой санхүүжилтийг онцлон “Тогтвортой усны болон хог хаягдлын менежмент”, “Монгол Улсын ногоон барилгын стандарт” зэрэг сэдвүүдээр салбарын төлөөлөгчдийг хамруулж, хэлэлцүүлгийн хүрээнд харилцагч нарт ногоон эдийн засгийн шилжилтийг цогцлоох мэдээллийг хүргэлээ. Мөн арга хэмжээний үеэр тогтвортой санхүүжилтийн булангаар дамжуулан Голомт банкны ногоон зээлийн бүтээгдэхүүний талаар танилцуулахын зэрэгцээ ногоон санхүүжилтийн сайн туршлагауд, бизнесээ ногоон болгох боломжуудын талаар мэдээллийг оролцогч нарт түгээв.





### Монголын Тогтвортой санхүүгийн форум 2024

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Монгол Улс - Ногоон хөгжлийг санхүүжүүлэх нь” сэдвийн хүрээнд 11-р сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын Тогтвортой санхүүгийн форум 2024” арга хэмжээнд Голомт банкны удирдлагууд оролцож, тогтвортой санхүүжилт, нөлөөллийн хөрөнгө оруулалтын боломжууд, хөрөнгө оруулагчдын шаардлагын талаар туршлагаа хуваалцлаа.



### Улаанбаатарын яриа хэлэлцээ 2024

лаанбаатар хотноо зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын IX бага хурлыг Голомт банк ивээн тэтгэж, дэмжин оролцлоо. Энэхүү хуралд “Зүүн хойд Ази дахь уур амьсгалын өөрчлөлт, аюулгүй байдлын сорилтууд” сэдвийн хүрээнд 30 гаруй улс, олон улсын байгууллага, дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид хэлэлцүүлгүүд өрнүүлсэн юм.



## Төсөл, хөтөлбөр



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

### Хамтын ажиллагаа

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд Усны тухай хууль, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Тогтвортой хөгжлийн 6-р зорилт “Баталгаат ундны ус, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх”, Монгол Улсын Ногоон таксономийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүдийн ус дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, усны нөөцийн нэгдсэн менежментийг сайжруулах, сайн туршлага, нөлөөллийг бий болгох, олон нийтэд сурталчлан таниулах юм.



### Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономийн туршилтын төсөл

Голомт банк 2023 оны 11-р сараас 2024 оны 4-р сарын хооронд Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зүгээс Тогтвортой Санхүүжилтийн холбоо (ТоС)-той хамтран гүйцэтгэсэн “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономын туршилтын төсөл”-ийг хамтран амжилттай хэрэгжүүлэв. Одоогийн Ногоон таксономи нь 8 ангилалтай бол шинэ таксономи нь 12 ангилалтай болж, боловсрол, эрүүл мэнд, харилцаа холбоо гэх мэт нийгмийн салбаруудыг нэмснээрээ илүү онцлогтой. Монгол Улсад 2025 оноос дагаж мөрдөгдөх төлөвлөгөөтэй байна. Төслийн үр дүнд 2023 оны 3-р улирлын байдлаар 1.2 их наяд төгрөгийн дүн бүхий 94 төсөл, хөтөлбөрийг Тогтвортой, ногоон зээлийн ангилалд оруулах боломжтой гэж дүгнэжээ.

**S&P Global**



**Sustainable 1**

### Тогтвортой байдлын үнэлгээ

Голомт банк олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн S&P Global байгууллагаар Тогтвортой байдлын үнэлгээг (CSA) Монгол Улсын банк санхүүгийн байгууллагуудаас анхлан хийлгэв. Тус үнэлгээ нь компанийн ил тод байдал болон Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) хэрэгжилт, гүйцэтгэлийг чухалчлан авч үздэг. Голомт банк нь S&P Global байгууллагын тогтвортой байдлын үнэлгээгээр нийт үнэлгээнд оролцсон 668 олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас “TOP THIRD” ангилалд орсон байна.



### Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ

J.P.Morgan Хөгжлийн Санхүүгийн Институттэй (JPM DFI) хамтран Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг хийж, олон нийтэд мэдээллээ. Голомт банк Тогтвортой хөгжлийн 2, 4, 5, 6, 7, 8, 12 болон 13 зорилгуудын хэрэгжилтийг хангахад өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээр дамжуулан хувь нэмрээ оруулан ажиллахаар тусгаж, цаашид ч Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээнд тусгасан үзүүлэлтүүдийг жил бүр тайлагнахаар амлалт өгч ажиллаж байна.



### Тогтвортой санхүүжилт, нөлөөллийн хамрах хүрээ

Дэлхийд тэргүүлэгч санхүүгийн байгууллага болох MUFG (Mitsubishi UFJ Financial Group) банкны тогтвортой санхүүжилтийн зөвлөх баг Голомт банкны "Тогтвортой санхүүжилт, нөлөөллийн хамрах хүрээ" баримт бичгийг хамтран боловсруулж, S&P Global ratings олон улсын үнэлгээний байгууллагаар амжилттай баталгаажууллаа. Энэхүү баримт бичиг нь Голомт банкны зүгээс харилцагчдадаа санал болгодог тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй байх гэсэн олон улсын стандарт, босго шалгууртай нийцэж буйг тодорхойлсноороо онцлогтой.



### Ногоон барилгын LEED O+M "GOLD" гэрчилгээ

АНУ-ын ногоон барилгын зөвлөлөөс олгодог ногоон барилгын LEED O+M үнэлгээний "Gold" гэрчилгээг Голомт банкны төв барилгад авлаа. Уг гэрчилгээ нь барилгын байршил, талбайн зохион байгуулалт, ус, эрчим хүчний хэрэглээ, материал ба нөөц, дотоод орчны чанар зэрэг үзүүлэлтүүдээр үнэлэн оноо олгодог олон улсын ногоон барилгын нэр хүнд бүхий гэрчилгээ юм. Голомт банк дотоод үйл ажиллагаа болох худалдан авалт, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, тамхигүй орчин бүрдүүлэх хязгаарлалт, хортон шавжтай тэмцэх ажиллагаа тус бүр дээр тогтвортой, ногоон үйл ажиллагааны стандартыг мөрдөн ажиллаж байна.





### Хүний эрх ба бизнес

Банк нь дотоод үйл ажиллагаа болон бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэн, НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд болон бусад олон улсын болон үндэсний хүний эрх, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой стандарт, зарчмуудыг мөрдөн ажиллахаа Тогтвортой хөгжлийн бодлогодоо тусгасан.

### Сургалт, хөгжил

Голомт банкны нийт ажилтан болон харилцагчдынхаа тогтвортой хөгжил, БОНЗ-ын мэдлэгийг нэмэгдүүлэх, ногоон шилжилтэд хамтдаа шилжихээр сургалт, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг идэвхтэй зохион байгуулж байна. 2024 онд Ногоон уур амьсгалын түншлэлийн сан (GCPF)-аас тусгайлан бэлтгэгдсэн сургагч багш нарын сургалтад хамрагдаж, цаашид Голомт банкны ногоон элч, сургагч багш нараар дамжуулан нийт 79 салбар, тооцооны төвийн 865 борлуулалтын ажилтанд тогтвортой санхүүжилтийн чадавх бэхжүүлэх сургалтыг орлоо.



### ОНЦЛОХ ТоС БАНК 2024

Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн холбоо (ТоС), Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран жил бүр тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтээр манлайлан ажиллаж буй байгууллагуудыг шалгаруулдаг. 2023 онд Голомт банк “Жендэрийн манлай банк”-аар шалгарч байсан бол 2024 онд “Онцлох ТоС банк” -аар тодорлоо.



### “ТЭРБУМ МОД” САНГИЙН ШИЛДЭГ ДЭМЖИГЧ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Монголбанк болон арилжааны банкнууд дэмжин ажиллаж, “Тэрбум мод” санг байгуулан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа. Улмаар тус сангийн 2024 оны үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг үнэлэн Голомт банкныг “Шилдэг дэмжигч байгууллага”-аар шалгаруулав.

# Нийгмийн хариуцлага

Тэтгэлэгт хамрагдсан  
нийт оюутан

**+1,900**

Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн тэтгэлгийн хэмжээг 2,000,000 төгрөг болгон нэмэгдүүллээ.

## Нийгмийн хариуцлага



**ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ**  
ТҮҮХ АРХЕОЛОГИЙН ТӨСӨЛ

### “Өв соёлын голомт” төсөл

Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүдийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр “Өв соёлын голомт” төслийг санаачлан 2022 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд хувийн хэвшлийн байгууллагуудаас анхлан археологийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Монголын түүх, шашин, соёлыг судлахад чухал нөлөө, томоохон дэмжлэг үзүүлж байгаа юм. Энэхүү төслийн дэд төсөл болох “Ингэт толгой”-н дурсгалт газрын археологийн малтлага, судалгааны ажлууд амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд Монголд төдийгүй олон улсад анхаарал татаж буй түүх, археологийн олдвор болоод байна.



### “OneSky” хүүхэд хөгжлийн байгууллага

Эх орны ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа эрүүл мэнд, боловсролд анхаарал хандуулж, хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг бөгөөд 2023 оноос хүүхдийн төлөөх сайн үйлсийн ажлуудаа өргөжүүлэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт амьдардаг бага насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжихээр “OneSky” байгууллагатай хамтран ажиллаж байна. “Хүүхэд бүрийн төлөө” уриатай “OneSky” байгууллага нь Вьетнам, Хятад, Хонконг зэрэг орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2018 онд Монголд “Гэр бүлийн төв”-ийг байгуулсан. Тус төвөөр дамжуулан бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдээ ойлгон хүмүүжүүлэх, суралцах боломжуудыг нь нээхэд туслах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухаанд суурилан боловсруулсан хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, хоол тэжээл, орчны аюулгүй байдлын талаарх “Гэр бүлийг чадавхжуулах” цогц сургалт хөтөлбөрүүдэд хүүхдүүд, гэр бүл, эцэг эхчүүдийг үнэ төлбөргүй хамруулах юм.



### Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Улс эх орны тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж, боловсролыг дэмжих, оюутан залууст санхүүгийн болон тэдний хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн салбараас анхлан “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын 50 гаруй их, дээд сургуулийн мэргэжлийн чиглэл харгалзахгүй 1,800 гаруй оюутанд сургалтын тэтгэлэг олгосон байна.

2024 онд “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-т Монгол Улсын их, дээд сургуулиудын 3, 4-р дамжааны 1,500 гаруй оюутан материалаа ирүүлснээс шилдэг оюутнуудаа шалгарууллаа. Тэтгэлэгт хөтөлбөрийн 20 дахь жилийн ойн босгон дээр тэтгэлгийн хэмжээг 2,000,000 төгрөг болгон нэмэгдүүлж, тэтгэлэгт оюутан Голомт банканд урилгаар бүтэн болон хагас цагаар шууд ажиллаж эхлэх боломжтой болсон. Энэхүү хөтөлбөрийн тэтгэлэгт оюутан болсноор Голомт академийн хувийн хөгжлийн болон мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдаж, суралцах хугацаандаа мэргэжлийн ментор, коучингийн удирдлагатай хамтран ажиллах зэрэг олон боломжийг хүртэж байна.

“Оюутны тэтгэлэгт хөтөлбөр” нь үндэсний хэмжээний, нэр хүндтэй хөтөлбөр бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 200 сая төгрөгийн тэтгэлгийг ийнхүү 100 оюутанд олгосноор тэтгэлгийн үр шимийг хүртсэн шилдэг оюутны тоо 1,900 гаруйд, тэтгэлгийн хэмжээ 1.3 тэрбум төгрөгт хүрчээ.



### “Зүрх мартагч” төсөл

Голомт банкны дэргэдэх “Алтантүлхүүр” хүүхдийн сан “Зүрх мартагч” төслийг 2020 оноос хойш дэмжин ажиллаж байна. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн юм. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад зүйлсээр дэмжин ажилладаг бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт 40 мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулж, 1200 гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийжээ.

Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог 350-360 болгон нэмэгдүүлээд байна.



### Морин хуурын чуулга

Голомт банкны хамт олон үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор эх орны онцгой өв соёлын гол төлөөлөл болох Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгчээр 14 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Морин хуурын чуулгын зүгээс дотооддоо төдийгүй дэлхийн тайзнаа нэр хүндээ бататгаж, олон мянган хүний талархлыг хүлээсэн, чанартай уран бүтээлүүдийг эрхлэн гаргаснаас “Playing Love” болон “Novel Melody” зэрэг бүтээлүүд нь олон улсад танигдаад байна. Хоёр байгууллагын хамтын ажиллагааны хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж, нийт 40 орчим томоохон тоглолт хийгээд байна.



### “Боломжийг бүгдэд” төсөл

Голомт банк Монголын тусгай олимпын хороо болон Улаанбаатар Ротари клубтэй 2024 оноос хамтран ажиллаж эхэлсэн. Тус байгууллагуудын санаачилгаар зохион байгуулдаг “Боломжийг бүгдэд” төслийн ээлжит арга хэмжээг Өвөрхангай хэрэгжүүлэхэд Голомт банк дэмжин ажиллалаа.

Хангай бүсийн 6 аймгийг хамарсан уг арга хэмжээнд оюуны хөгжлийн онцлогтой 230 гаруй хүүхэд, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч оролцсон бөгөөд арга хэмжээний хүрээнд сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулав.

Монголын тусгай олимпын хорооны “Боломжийг бүгдэд” төслийн онцлог нь спортоор дамжуулан оюуны хөгжлийн онцлогтой хүүхдүүдийн хөгжил, оролцоог дэмжих зорилготой. Иймд хүүхдүүдийн дунд спортын өдөрлөг зохион байгуулж, төслийн арга хэмжээний үр дүнг хүртэх хүүхэд, багачууд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын цар хүрээг нэмэх боломжийг бий болголоо.

# Үйл ажиллагааны удирдлага

Нийт зээлийн  
хэмжээ

# 7.5


их наяд төгрөг



Голомт банк 2024 онд зээлийн багцын чанарт онцгой анхаарал хандуулан ажилласнаар чанаргүй зээлийн түвшин 3 хувь, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ түүхэн дээд хэмжээ буюу 121 хувьд хүрэв.

## Хүний нөөцийн удирдлага

Голомт банк ажилтан болон ажилтны гэр бүлд ээлтэй бодлогын хүрээнд мэнд оршихуй буюу тэдний бие, сэтгэл зүй, санхүүгийн эрүүл мэндийг дэмжих замаар банканд урт хугацаанд, тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад чиглэн ажиллаж байна.



Технологи, эдийн засаг, соёл, нийгмийн асуудал, цар тахал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ажил олгогчдод хүний нөөцийн “new normal” байдал руу шилжих шаардлага тулгамдаж байна. Харин Голомт банк сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарт байнгын анхаарлын төвд байсаар ирсэн нь ажилтнууддаа зориулан хийж буй үр өгөөжтэй хөрөнгө оруулалтын үр дүн юм. Энэхүү үр өгөөж нь бид ажилтнуудаасаа жил бүр авч буй судалгаа, санал хүсэлтээр үнэлэгддэг. Үүний үр дүнд Голомт банк олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Great Place to Work Institute”-ээс “Ажиллахад таатай газар” батламжийг 2022 онд Монгол Улсын банк, санхүүгийн салбараас анхлан авч, 2023, 2024 онд дахин бататгаж, 3 жил дараалан авсан МУ-ын анхны байгууллага болсон юм.

## Багийн мэнд оршихуй



Багийн хөгжлийн хөтөлбөрийг бид сүүлийн 4 жил тасралтгүй хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь ажилтнуудын багийн ажиллагаа, сэтгэл зүй, бие, санхүүгийн эрүүл мэндийг дэмжих зорилготой бөгөөд 6 удаагийн 4260 хүн цагийн сургалтыг зохион байгуулснаар нэгжид дэд соёлыг төлөвшүүлэх, шинэ ажилтныг банкны соёлд суралцуулах, үе хоорондын үр дүнтэй харилцаа, багийн бүтээмж нэмэгдүүлэх ач холбогдолтой байв. Учир нь олон талт, хүртээмжтэй ажлын байраар дамжуулан ажилтнууд өөрсдийн өсөлт хөгжлийг үргэлжлүүлж, олон янзын ялгаатай туршлага дээр үндэслэн бусдаасаа тасралтгүй суралцдаг.

## Ажилтны мэнд оршихуй

Бид сүүлийн жилүүдэд ажилтнуудынхаа мэнд оршихуйд зориулан сургалт, хөтөлбөр, арга хэмжээг нэмэгдүүлэн ажиллаж байна. Сургалтын олон арга барилыг ашиглан 2024 онд 39 удаагийн 2142 хүн цагийн сургалтыг зохион байгуулжээ. Энэ нь цаашлаад бизнесийн зорилго, зорилтуудад чухал нөлөө үзүүлдэг.

### Биеийн эрүүл мэнд



Ажилтнуудынхаа биеийн эрүүл мэндэд анхаарахдаа ажилтнуудад хүртээмжтэй байдлыг чухалчилдаг. Үүнд, урьдчилсан сэргийлэх болон эмчийн анхан шатны үзлэг, үйлчилгээ, эрүүл мэндийн аян, цус хандивлах аян, бариа засал, нэмэлт эрүүл мэндийн даатгал гэх мэт олон төрлийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Мөн ажилтнуудын гэр бүлд ээлтэй бодлогын хүрээнд ажилтны гэр бүлд чиглэсэн сургалт, зөвлөгөө, арга хэмжээг жил бүр хэрэгжүүлсээр байна.



Багийн хамтын ажиллагаа, харилцаа холбоог өргөжүүлэхийн зэрэгцээ ажилтны биеийн эрүүл мэндэд анхаарах зорилгоор олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Онцолбол, Голомт банкны уламжлалт “Спорт явган аялал”-ыг 25 дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд Хагийн хар нуур, Хар зүрхний хөх нуур, Асралт хайрхан, Цэцээ гүн, Гүнжийн сүм, Заан тэрэлж, Дуган хад, Хүйсийн найман нуур, Аглаг бүтээлийн хийд зэрэг 9 чиглэлд амжилттай аялжээ. Өнгөрсөн хугацаанд нийт 1000 гаруй ажилтан спорт явган аяллын хөтөлбөрт хамрагдаж, аялагчдын багаас өдгөө спортын мастер 4, спортын дэд мастер 5, аяллын спортын зэрэгтэй 100 гаруй хүн бэлтгэгджээ. Түүнчлэн Голомт банкны “Спорт наадам”-ыг хавар, намрын улиралд зохион байгуулж, жил бүр 1100 орчим ажилтнаа хамруулж байна.



### Сэтгэл зүйн эрүүл мэнд

Ажилтны мэнд оршихуйд чиглэсэн цогц арга барилын нэг хэсэг болох ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавьж, энэ хүрээнд ажилтнууддаа мэдлэг олгож, дэмжин ажиллаж байна.

ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн “Ажиллахад таатай газар” судалгааны 2024 оны үр дүнд Голомт банкны ажилтны сэтгэл ханамжийн хувь 91 хувьтай үнэлэгдэж, Азийн байгууллагуудтай эн зэрэгцэж, тэргүүн эгнээнд эрэмбэлэгдсэн. Энэхүү үзүүлэлтэд бизнесийн зөв оновчлол, удирдлагын манлайлал, ажилтан болон удирдлагын хоорондын харилцаа, байгууллагын соёл, зөв менежмент зэрэг олон хүчин зүйлс голлон нөлөөлдөг.



### Санхүүгийн эрүүл мэнд

Санхүүгийн эрүүл мэнд нь мөнгөө зарцуулах болон хадгалахтай холбоотой дадлыг бий болгох, хөгжүүлэх, ойрын болон урт хугацааны зардлыг төлөвлөх, онцгой байдлын үед хуримтлал үүсгэхийг илэрхийлдэг. Бид ажилтнууддаа Голомт банкны “Тэтгэврийн ууган сан”-аар дамжуулан урт хугацааны хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлэн ажилладаг. Мөн бусад хөтөлбөр, сургалтуудаар дамжуулан санхүүгээ үр ашигтай удирдахад нь дэмжлэг үзүүлж, мэргэжлийн зөвлөхүүдээс зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэн ажилладаг.



### Ажилтанд зориулсан оюуны хөрөнгө оруулалт, эрдмийн дэмжлэг

Бид “Голомт академи” сургалтын нэгжээрээ дамжуулан ажилтны өсөн дэвжих, сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэн ажилладаг. Тодруулбал, ажилтны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор мэргэжлийн гэрчилгээ болон шалгалтын төлбөрийг дэмжих, олон улсын тэргүүн туршлагаас суралцах боломжоор хангадаг. Үүгээр дамжуулан ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг бэлтгэх, тогтоон барих замаар банкны урт хугацааны стратеги төлөвлөгөөнд хүргэхэд ач холбогдолтой. Түүнчлэн 2024-2025 оны хичээлийн жилд Мандах их сургуультай хамтран ажиллаж, 40 гаруй ажилтнаа магистрын хөтөлбөрт хамруулж байна.

## Карьер хөгжил

Дижитал сургалт

# 50%

# 150

гаруй цахим сургалт,  
контент

# 82,000

удаагийн хандалт

## Ажилтны ажил мэргэжлийн хөгжлийг дэмжих

Байгууллагаас ажилтнууддаа хөрөнгө оруулж буй ажлуудын нэг хэсэг нь тэднийг шинэ ур чадвар эзэмших, карьер хөгжлийн төлөвлөлтийг нь төлөвлөхөд дэмжих, бодлогоор хангах явдал юм. Иймд бид ажилтныг ажилд орсон эхний өдрөөс эхлээд тэтгэвэрт гарах хүртэл нь банкны үйл ажиллагаа, сургалт, хөтөлбөр, арга хэмжээгээр дамжуулан карьер хөгжлийг төлөвлөдөг.

2024 онд шинээр 880 гаруй ажилтан Голомт банканд нэгдсэнээс 33% нь шинэ төгсөгч байв. Нийт зарлагдсан ажлын байрны 80 гаруй хувийг дотоодоосоо бүрдүүллээ. Голомт банкны шинэ ажилтнаа чиглүүлэх хөтөлбөр нь нэгжийн зохион байгуулалтад дасгах, банкны соёл, шинэ ур чадварт суралцах, карьераа дараагийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлдэг. Ажилтнууд хийж байгаа ажлаараа бахархдаг, хувийн болон мэргэжлийн зорилгодоо хүрэх боломжийг олгодог банк болоход бид анхааран ажиллаж байна.

Ажилтан бүр тасралтгүй суралцах, хөгжих, мэдлэгээ хуваалцах соёлыг бэхжүүлэх зорилгоор “Ажилтан та - Хөгжлийн Голомт”, “Удирдах ажилтан бүр сургагч багш” уриан дор 2024 онд сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, сургалтад БОНЗ-ын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн цаас болон усны хэрэглээг бүрэн зогсоолоо.

Тасралтгүй суралцах соёлын хүрээнд ажилтан хүссэн газраасаа, хүссэн үедээ Голомт академийн сургалтын платформоор дамжуулан сурч, хөгжих боломжтой байдаг.

## Удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөр

Банкны залгамж халааг тасралтгүй бэлтгэх, ажилтны удирдах ур чадварыг тогтмол хөгжүүлэх зорилгоор удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэв.

- Удирдлагын манлайллын хөтөлбөр
- Удирдах ажилтанд зориулсан хүний нөөцийн менежментийн хөтөлбөр
- Шинэ удирдах ажилтнуудыг ажлын байранд богино хугацаанд дасан зохицоход чиглүүлэх менторшип хөтөлбөр
- Шинэ удирдах ажилтны залгамж халаа бэлтгэх Удирдах ажилтан бэлтгэх хөтөлбөр

## Хамтын ажиллагаа

- Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 20 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, шилдэг 100 оюутанд тэтгэлэг гардууллаа. 2024-2025 оны хичээлийн жилд “Ажилтай, тэтгэлэгтэй оюутан” тодотголтойгоор зохион байгуулж, тэтгэлэгт оюутнууд маань Голомт банканд хагас цагаар цалинтай ажиллах боломж бүрдсэн юм.
- Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Үндэсний соёл амралтын хүрээлэн дэх Голомтын төгөлд 5 дахь жилдээ 200 гаруй гацуур мод тарилаа. Ингэснээр тус төгөл 1030 модтой боллоо.



- Голомт банкны ажилтнууд 2019 оноос жил бүр цусаа хандивладаг уламжлалтай ба 2024 оны хувьд 120 гаруй ажилтан цусаа хандивлаж 360 гаруй хүний амь аварлаа.
- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хайраа хуваалцъя” аяныг амжилттай зохион байгууллаа.

## Хөрөнгийн удирдлага

Банк өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг зохистой түвшинд барьж, өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ хангаж ажиллалаа.

### Актив, пассивын удирдлага

Голомт банк 2024 онд Актив, пассивын удирдлагын хүрээнд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж, эрсдэлийг зохистой түвшинд удирдаж ажиллалаа. Активын ашиглалтыг сайжруулан эх үүсвэрийн бүтцийг төрөлжүүлэх замаар ашигт ажиллагааг сайжруулаад байна.

### Зохистой харьцаа

Тайлант хугацаанд актив, пассивын эргэн төлөлтийн хугацааны зөрүүг харилцагчдын зан төлөв дээр суурилан тооцох аргачлалаа ашиглан хүүгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ тогтмол удирдаж ажиллав.

Банк хөрвөх чадвараа өндөр түвшинд хадгалж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтмол 30%-аас дээш хангаж ажиллахын хажуугаар Базелын хорооны хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд болох LCR (30 хоногийн хөрвөх чадвар), NSFR (1 жилийн тогтвортой эх үүсвэр)-ийн үзүүлэлтүүдийг тооцож, тогтмол 100 хувиас дээш хангаж ажиллаад байна.

Дотоодын зах зээл дээр эх үүсвэрийн өрсөлдөөн өндөр байсантай холбоотойгоор олон улсын зах зээлээс нийт 400 сая ам.долларын бондын эх үүсвэр татан төвлөрүүлсэн. Ийнхүү 400 сая ам.долларын бондыг амжилттай арилжсан нь Монголын банкны секторын хувьд ам.долларын зах зээлийн оролцоог эргэн сэргээж, Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой үйл явдал болсон.

---

## Ашигт ажиллагаа

Голомт банк 2024 онд сул активын ашиглалтыг сайжруулахад анхаарч, бондын зах зээлд оролцон Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж ажиллахаас гадна зээлийн багцаа нэмэгдүүлж, төрөлжүүлэх чиглэлд төвлөрөн ажиллав.

## Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ

Голомт банк 2023 онд Монгол Улсад анх удаа Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээг (Private Wealth Management) нэвтрүүлсэн. Одоогоор банкны Хөрөнгө оруулалтын хадгаламжийн бүтээгдэхүүнээр дамжуулан дотоод болон гадаадын харилцагчдад олон улсын стандарт бүтээгдэхүүнийг хүргэн ажиллаж байна.

Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ (Private Wealth Management Service) бол харилцагчийн хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадварын хүрэн дэх хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээний хүрээнд харилцагчдад багцын хөрөнгө оруулалт болон дагалдах консьерж үйлчилгээг хүргэн ажилладаг бөгөөд үүний хүрээнд 2024 онд харилцагчдад тав тухтай үйлчилгээг хүргэх VIP салбаруудыг нээлээ. Энэхүү үйлчилгээний гол зорилго нь өндөр дүнтэй хадгаламж эзэмшигч, хөрөнгө оруулагч, хөрөнгө эзэмшигчид рүү чиглэж, тэдгээрийн хөрөнгийг оновчтой багц бүрдүүлэх замаар удирдахад оршдог бөгөөд 2024 онд тогтвортой өсөлтийг үзүүлэн ажиллав. Цаашид үйлчилгээг харилцагчдадаа хүртээмжтэй бөгөөд хурдан шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

## Харилцагчийн үйлчилгээ



Харилцагч төвтэй банкны бодлогын хүрээнд Голомт банк үйлчилгээний нийт сувгаар бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхдээ Монгол Улсын банкны үйлчилгээний кодексыг үйл ажиллагаандаа нийцүүлэн мөрддөг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний суваг бүрд харилцагчийн эерэг замналыг бий болгож, сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, чанарыг нэмэгдүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалахад чиглэн ажиллаж байна.

### Харилцагчийн үйлчилгээний ОУ-ын стандарт нэвтрүүлэлт

Банкны “Contact center” болон Гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг БНФУ-ын AFNOR групп, Үйлчилгээний төгөлдөршил ISO 23592:2021 стандартыг Олон улсын сургалт, баталгаажуулалтын “МонСертф” ХХК байгууллагуудаар баталгаажуулсан. Эдгээр стандартыг нэвтрүүлснээр Голомт банк харилцагчдынхаа итгэлийг улам бэхжүүлж, зайны сувгийн үйлчилгээ, гомдлын удирдлагын тогтолцооны чанарыг тогтмол сайжруулах, харилцагчдад хүлээлтээс давсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх юм. Цаашид Голомт банкны харилцагчийн үйлчилгээг олон улсын түвшинд нийцүүлэн ажиллахаар зорьж байна.



### Хиймэл оюун ухаан BOT нэвтрүүлэлт

“Contact center”-ийн үйл ажиллагаанд AI BOT-ыг нэвтрүүллээ. Ингэснээр хиймэл оюун ухааныг ашиглан харилцагчийн асуултад дэлгэрэнгүй хариулт өгөх чадвартайгаар тасралтгүй хөгжүүлж байна. Тус AI BOT нь нэг дор 5 харилцагчид зэрэг хариулт өгөх боломжтой. Одоогоор харилцагчийн онлайн хандалтын 85 хүртэлх хувийг виртуал агентаар шийдвэрлэж байна.

### Харилцагчийн эрх ашиг

- Харилцагчийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд “Харилцагч төвтэй банкны бодлого”, Банкны үйлчилгээний кодексыг даган мөрдөхөд чиглэн харилцагчийн эерэг туршлагад чиглэсэн мэдээ мэдээллийг банкны цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулав.
- Голомт банкаас санаачлан Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академитай хамтран “Харилцагчийн эрх ашгийг хамгаалах” хэлэлцүүлгийг нийт банкнуудыг хамруулан Монголд анх удаа зохион байгуулан Харилцагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг манлайлан ажиллалаа.



### Зайны үйлчилгээний цар хүрээ

- 2024 онд “Contact center”-т харилцагчдын нийт 1.4 сая хандалтыг 97%-ийн амжилттай хүлээн авч, харилцагч нартаа зөвлөгөө, мэдээлэл өгч сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн хүртээмжтэй ажиллав.
- “Харилцагч төвтэй банкны бодлого”, Тогтвортой санхүүжилт, ногоон шилжилтийг дэмжих ажлын хүрээнд салбар, тооцооны төв үзүүлдэг үйлчилгээний 32%-ийг зайны сувгуудаар үзүүлдэг боллоо. Ингэснээр харилцагчдын цаг хугацааг хэмнэх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломж бүрдэв.

### Үйлчилгээний чанар

- Банкны салбарт хийгддэг шимтгэл, хураамжийн үйлчилгээг Дижитал сувгаар хялбар төлөх шийдлийг нэвтрүүллээ. Ингэснээр харилцагчдын хувьд шимтгэл төлөх хугацааг 70% бууруулж, жилд 1000 гаруй боодол цаасыг хэмнэв.
- Салбарт үйлчилгээ авах харилцагчдын бүртгэлийн процессыг хялбаршуулж, бүртгэл хийх хугацааг 63%-аар буурууллаа.
- Банкны хэмжээнд бүртгэгдэж буй санал хүсэлт, гомдлыг анхны хандалтаар шийдвэрлэх хувийг 2 дахин нэмэгдүүлж, 120 мянга гаруй харилцагчид төвөгшил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллав.
- 2024 онд Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний замнал, бүтээгдэхүүний чанарын үндсэн 7 метрикс үзүүлэлтийн дундаж үнэлгээ 98.5%, салбар, тооцооны төвийн нийт ажилтны мэдлэг, Харилцагчийн үйлчилгээний стандарт 98.2%, салбар, тооцооны төвийн тохижилтын стандартыг 96.2%-тай хангаж ажиллалаа.
- Харилцагч төвтэй банкны бодлого”-ын хүрээнд нийт ажилтан руу чиглэсэн мэргэшүүлэх 3731 хүн/цагийн сургалтыг зохион байгуулж, ажилтнуудын мэргэжлийн байдлыг үргэлж нэмэгдүүлэн ажиллаж байна.

## Эрсдэлийн удирдлага

2024 онд зээлийн багцын чанарт онцгой анхаарал хандуулан ажилласнаар банкны чанаргүй зээлийн түвшин 3 хувь, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ түүхэн дээд хэмжээ буюу 121 хувьд хүрэв.

Эрсдэлийн засаглал, “Гурван шугамын загвар”, эрсдэл даах чадвар, стресс тестийн үр дүнд суурилсан эрсдэл даах чадварын нөөц интервал бүрдүүлэлт, эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, гэрлэн дохионы аргачлал зэрэг Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хамаарах үндсэн бүрэлдэхүүнүүдийг улам төгөлдөржүүлж, дотооддоо мөрдөн ажиллаж байна.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож, нэгтгэсэн стресс тестэнд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд “Гурван шугамын загвар”-ыг дараах байдлаар тодорхойлж, банкны бүх нэгжийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна. Үүнд:

#### Нэгдүгээр шугам

Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд.

#### Хоёрдугаар шугам

Нэгдүгээр шугамд хамаарах нэгжүүд эрсдэлээ хэрхэн удирдаж буйд хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд.

#### Гуравдугаар шугам

Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд.

Голомт банкны  
Зээлийн  
эрсдэлийн  
удирдлага нь  
зээлдэгчийн  
гэрээгээр  
хүлээсэн үүрэг  
биелэгдээгүйн  
улмаас банкны  
алдагдал хүлээх  
эрсдэлийг  
удирдах, банкны  
ашигт ажиллагааг  
боломжит  
өндөр түвшинд  
хадгалахыг  
зорьдог.

## Зээлийн эрсдэлийн удирдлага

### Банкны зээлийн багцын чанар сайжирлаа

Банк 2024 онд зээлийн багцын чанарт онцгой анхаарал хандуулан ажилласнаар чанаргүй зээлийн түвшин 3 хувь, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ түүхэн дээд хэмжээ буюу 121 хувьд хүрсэн. Зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах бодлогын хүрээнд эдийн засгийн циклд өртөмтгий секторуудаас хамаарах хамаарлыг бууруулах, зээлдэгчийн сегментийн төвлөрлийг тархаах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зээлийн багцын оновчтой бүтцийг хадгаллаа. Ирэх 2025 онд ч зээлийн багцын чанарыг хадгалсан зээлийн багцын өсөлтийн бодлогыг баримтална.

### Банкны зээлийн үйл ажиллагааны хурд нэмэгдэв

Голомт банк зээлийн үйл ажиллагааны хурдыг нэмэгдүүлэхийг зорин ажилласаар ирсэн. Тухайлбал, 2024 онд бизнесийн зээлийн судалгааны 6 загвар аргачлалыг хялбаршуулж, бизнесийн зээлийн судалгааны хурдыг 30%-аар нэмэгдүүлсэн. Харин иргэдийн зээлийн судалгаанд 2019 онд RLOS системийг, 2023 онд K2 системийг тус тус нэвтрүүлсэн. 2024 онд эдгээр системүүдийн ашиглалтыг сайжруулснаар салбар дээрх зээл олгох хугацааг 8 дахин, иргэдийн зээлийн судалгааны ачааллыг 45%-аар бууруулсан. Түүнчлэн зээлийн судалгааны 22 аргачлалыг төгөлдөржүүлэх, өгөгдлийн чанарыг сайжруулах, скорингийн үр дүнг хянах баталгаажуулалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр зээлийн үйл ажиллагааны процессын үр ашигтай, оновчтой байдал сайжрав. 2025 онд зээлийн судалгааны нийт процессыг төвлөрүүлсэн нэгдсэн системийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

## Зээл цуглуулах үйл ажиллагаа

### Процесс автоматжуулалт

Голомт банкны Дата удирлагын хэлтэс, Процесс автоматжуулалтын хэлтэс, Зээл цуглуулах нэгж хамтран дуут мессеж илгээх процессыг бүрэн автоматжууллаа. Ингэснээр өдөрт 4-5 хүн цаг зарцуулдаг ажлыг хүний оролцоогүйгээр гүйцэтгэхээс гадна амралтын өдөр дуут мессеж илгээдэг болсноор хүртээмж нэмэгдэж, бүх төрлийн хэрэглээний зээл авсан харилцагчид руу илгээж байна. Одоогоор сард дунджаар 60 мянган зээл рүү дуут мессеж илгээж, 35%-тай нь холбогдож, холбогдсон зээлийн төлөлт сард 87.4%, холбогдоогүй зээлийн төлөлт 79.7%-тай байна.

2024 оны 5-р сараас хугацаа хэтэрсэн зээлтэй харилцагчийн бүх депозит дансыг автоматаар битүүмжлэх ажиллагаанд “Robotic Process Automation” хөгжүүлж, нэвтрүүлсэн. Энэхүү ажиллагаа нь бусад дансаар гүйлгээ хийх эрсдэлийг 90%-аар бууруулж, зээл төлөлтийг 5%-аар өсгөсөн. Өдөрт 2 цаг хийгддэг ажлыг 15 минут болгон хүн цагийг хэмнэж байна.

### “СТОУС-9” стандартын дагуу зээлийн үнэ цэн бууралтыг тогтмол тооцож байна

Олон улсын Нягтлан бодох бүртгэлийн зөвлөл (ОУНББЗ)-өөс батлан гаргасан “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9” (IFRS-9) стандартыг Голомт банк 2018 онд нэвтрүүлж байсан бол 2024 онд тус стандартын дагуух зээлийн тооцооллыг олон улсын PWC хөндлөнгийн аудитын фирмийн зөвлөх үйлчилгээний дагуу автоматжуулж, зохицуулагч байгууллага руу сар бүр амжилттай тайлагнан ажиллаж байна.

### Барьцаа хөрөнгийн бодлого

Банк барьцаа хөрөнгийн бодлогын дагуу зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив болон хүлээж болзошгүй үүрэгт зээлдэгч болон гуравдагч этгээдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож барьцаа шаарддаг.

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны төрөл, онцлогоос хамааран орон сууц, оффис, худалдаа, дулаан зогсоол, амины орон сууц зэрэг үл хөдлөхийн төрөл тус бүрд барьцаа хөрөнгийн жишиг үнийг мөрдөж, хагас жил тутамд шинэчилдэг бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа нь “Үнэлгээний олон улсын стандарт” (IVS)-ын дагуу нийцтэй байдаг.

Банк 2024 онд барьцаа хөрөнгийг үнэлэх хурдыг нэмэгдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн өгөгдлийн чанарыг сайжруулах, систем дээрх бүртгэлийн талбаруудыг стандартжуулах болон хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааны хяналтын дашбоардыг хөгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

## Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэн болон ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж, алдагдал хүлээх эрсдэл юм. Хүү, валютын ханш, арилжаа, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаас, хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт эсвэл зах зээлийн хөдөлгөөнөөс хамаарч, банкны нээлттэй байгаа позицод зах зээлийн эрсдэл нэмэгддэг.

Тайлант хугацаанд Монгол Улсын макро эдийн засгийн орчин тогтворжиж эхэлсэн боловч геополитикийн эрсдэлүүд нэмэгдэж, санхүүгийн зах зээлд хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, зэрэг эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна.

2024 онд Голомт банк нээлттэй гадаад валютын позицуудын хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажилласан. Түүнчлэн АПХ-оос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг "Value at Risk" аргачлалаар тооцож, өдөр бүр хяналт тавин ажиллав.

Мөн харилцагч тал болон улс орны эрсдэлийг харилцагч харилцагчийн зээлжих зэрэглэл болоод санхүүгийн харьцаа үзүүлэлтэд үндэслэн харилцагч нэг бүрийн хувьд лимитийг тодорхойлж, гүйцэтгэлд өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд банк өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа. Мөн түүнчлэн Базел III стандартын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг ашиглан учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэж, өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдан ажиллаж байна.

Банк нь хүүгийн зохистой түвшнийг бодлогын хүү, зах зээлийн өрсөлдөөн зэрэг олон талт нөхцөл байдлаас хамааруулан тодорхойлдог. Уг хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн орчинд банк нь богино хугацаанд цэвэр хүүгийн орлогод үүсэх өөрчлөлт (NII)-ийг, урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд үзүүлэх нөлөөлөл (ΔEVE)-ийг үнэлж, хүүгийн өөрчлөлтийн стресс нөхцөлд учирч болзошгүй аливаа эрсдэлүүдийг тодорхойлж удирдан ажилладаг.

## Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм.

Банкны хөрвөх чадвар 2024 оны турш Монголбанкнаас тогтоосон зохистой түвшин болон банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хүрээнд хангалттай өндөр түвшинд бай. Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол тооцож, хангаж ажиллалаа.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, мөрдөн ажиллалаа.

Мөн түүнчлэн Базел III стандартын дагуу хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-аар учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэн үр дүнг шийдвэр гаргалтад ашиглан хөрвөх чадварын эрсдэлийг удирдан ажиллаж байна.

## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь банкны дотоод үйл ажиллагаа, системүүдийн хяналтын хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл болон хүний хүчин зүйлээс шалтгаалан эрсдэлийн зохистой түвшинг хангаж чадахгүй болохыг хэлнэ.

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг оновчтой болгох ажлыг Эрсдэлийн удирдлагын системд нэвтрүүлсэн. Эрсдэлийн дашбоард, Эрсдэлийн сан, Эрсдэлийн тохиолдлын сан, Эрсдэлийн түлхүүр үзүүлэлт, Эрсдэлийн зөвлөмж зэрэг функциональ боломжуудын тусламжтайгаар гүйцэтгэж ажилласны үр дүнд үйл ажиллагааны эрсдэлийн аппетитийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан үйл ажиллагааны эрсдэлийн аппетиттэй уялдуулан банкны хэмжээнд үйл ажиллагааны эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг шинэчилж, тогтмол давтамжтай хяналтыг хэрэгжүүлж байна.

---

### Эрсдэлийн соёлын хөтөлбөр

Банк нь жил бүр Эрсдэлийн соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хөтөлбөрийн хүрээнд ёс зүй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, мэдээллийг бататгах, дээшлүүлэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулдаг.

2024 онд “Эрсдэлийн соёлын хөтөлбөр”-ийн хүрээнд олон төрлийн сургалт, инфографикаар дамжуулан мэдлэг, мэдээлэл түгээхээс гадна нийт ажилтныг хамруулсан уралдаан, тэмцээн, симуляци зохион байгуулсан нь үр дүнтэй байлаа.

Түүнчлэн олон улсын аргачлалын хүрээнд “Эрсдэлийн соёлын судалгаа”-г жил бүр ажилтнуудаас авч байгаа бөгөөд судалгааны үр дүнд анхаарах шаардлагатай нэгж, үйл ажиллагааг тодорхойлж, тухайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

---

### Бизнесийн тасралтгүй ажиллагаа

Голомт банк 2024 онд Бизнесийн тасралтгүй ажиллагааны олон улсын ISO 22301:2019 стандартыг нэвтрүүлж, баталгаажуулсан Монгол Улсын анхны банк санхүүгийн байгууллага болов.

ISO 22301:2019 (Business Continuity Management System) стандартыг нэвтрүүлснээр Голомт банк аливаа эрсдэлийн үед уян хатан байдлаа хадгалж, үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн үргэлжлүүлэх бүрэн чадамжтай гэдгийг нотолж буйн баталгаа юм.

## Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлага

Голомт банк мэдээллийн технологиос үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс мэдээллийн технологитой холбоотой эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх болон тайлагнах процессыг тогтмол хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд мэдээллийн технологийн нийлүүлэгчээс үүдэлтэй эрсдэлийг бууруулах үүднээс мэдээллийн технологийн нийлүүлэлтийн гинжин хэлхээний эрсдэлийг үнэлэх аргачлалыг сайжруулж, мэдээллийн технологийн нийлүүлэгчийн хяналтыг тогтмол давтамжтай хэрэгжүүлж ажиллав.

### Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Голомт банк олон улсын нэр хүнд бүхий шинэчлэгдсэн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох ISO27001:2022 стандарт, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS 4.0, PCI-3DS стандартууд болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах GDPR буюу Европын холбооны Хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн шаардлага тус бүрийг ханган үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.



2017 оны 7-р сараас  
хойш



2018 оны 3-р сараас  
хойш



2018 оны 10-р сараас  
хойш

---

Мөн 2024 онд мэдээллийн аюулгүй байдлын олон төрлийн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, зааварчилгааг шинэчлэн боловсруулж, ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Системийн аюулгүй байдлыг бүрэн хангаж буй эсэхийг хөндлөнгийн мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаар банкны системийн эмзэг байдлын үнэлгээг тогтмол хийж баталгаажуулсан.

Банкны систем руу чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security Operations Maturity Model (SOMM) стандартын шаардлагуудыг бүрэн хангасан Кибер аюулгүй байдлын удирдлагын төв (КАБУТ)-ийг бий болгон ажиллаж байна. Энэхүү төв нь бодит цагийн горимоор хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн халдлага, довтолгоог зогсоох, хариу арга хэмжээ авах (SOAR), урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Банкны кибер аюулгүй байдлын хамгаалалтын тоног төхөөрөмж, программ хангамжууд нь олон улсын судалгааны байгууллагуудаар үнэлэгдэж, салбартаа шилдэг шийдлүүдийг ашиглаж байна.

Банкны системүүд рүү ажилтнуудын хандах үйл ажиллагааг олон улсын шилдэг туршлагууд (Zero Trust) дээр тулгуурлан хяналт тавин ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлын нэгж нь банкны ажилтнуудын үндсэн системүүдийн эрхийн хяналтыг тогтмол хийдэг нь дотоод залилан, луйвар гаргахаас урьдчилан сэргийлж байна.

Банкны интернэт хандалттай болон дотоод системүүдийн эмзэг байдлын шалгалтыг олон улсын хөндлөнгийн болон дотоодын шилдэг гэрээт кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэдэг. Мөн "Open Bug Bounty" хөтөлбөрт Голомт банк нэгдсэнээр олон улсын ёс зүйт хакерууд нь банкны системээс эмзэг байдлыг илрүүлэн урамшуулал авах хөтөлбөрийн хүрээнд харилцагчийн мэдээлэл руу халдах гэсэн оролдлогыг цаг алдалгүй илрүүлэх боломж нэмэгдсэн.

Түүнчлэн дэлхийн өнцөг бүрийн 1100 гаруй байгууллага нэгдсэн кибер аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагааны төсөл болох Парисын Кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдэн туршлага солилцож байна.

2024 онд кибер аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор машин сургалтын техникүүдийг амжилттай нэвтрүүлсэн. Машин сургалтын алгоритмуудыг ашиглан кибер халдлагыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл явцыг автоматжуулсан. Энэ нь халдлагын эрсдэлийг бууруулах, мэдээллийн аюулгүй байдлын түвшнийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.



Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн  
Санхүүгийн тайлангууд болон Хараат бус аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31



## Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Голомт Банк ХК (цаашид "Банк" гэх)-ийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Банкны санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Банкны удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 6-д дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.

		
Ч.МӨНХЦЭЦЭГ	ОДОНБААТАР Гүйцэтгэх Захирал	С.МӨНХТУЯА
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга		Санхүүгийн Удирдлагын Газрын Захирал

Улаанбаатар,  
Монгол Улс

Огноо: 2025 оны 3 дугаар сарын 28



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар-14240,  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө 17,  
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101  
Факс: +976 7011 8102  
www.kpmg.com/mn

## Хараат Бус Аудиторын Тайлан

Голомт Банк Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

### Дүгнэлт

Бид Голомт Банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого, үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлан нь Банкны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЭЗОУС3-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Банкнаас хараат бус байж, НБЭЗОУС3-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

### Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.

### Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын сангийн хэмжилт

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа төлбөрийн хүлээгдэж буй зээлийн алдагдлын сан нь 172,192,723 мянган төгрөг байна. Энэхүү санг Банк СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүрийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдал (“ХБЗА”) -ын хүрээнд үндэслэн тогтоодог.



### Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Санхүүгийн тайлангийн Тодруулга 12 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, Тодруулга 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж болон Тодруулга 4.9 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа хэсэгт тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
